



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

ННА 67
ДАА 340
С-568

СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судлаачдын баг:

Ахлагч: Б.Баялагмаа (LL.M), Д.Баттулга

Гишүүд: Э.Энхцэцэг (LL.M), Б.Анирмаа (LL.M), Б.Наранцэцэг,
Г.Амаржаргал, О.Маралмаа, Б.Бямбадалай

© Нээлттэй Нийгэм Форум, 2025

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг,
Л.Түдэвийн гудамж-5/3

Утас: 976-76113207

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN: 978-9919-529-07-9

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ.....	8
----------------------	----------

УДИРТГАЛ	9
-----------------------	----------

НЭГ. СОНГУУЛИЙН МАРГААН, ТҮҮНИЙ ОНЦЛОГ ШИНЖ	11
--	-----------

1.1. Сонгуулийн маргааны онцлог, төрөл, ангилал	11
1.2. Сонгуулийн үндсэн зарчмууд болон маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын үндэс	17

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД	23
---	-----------

2.1. Монгол Улсын хууль тогтоомж дахь сонгуулийн маргаан шийдвэрлэх зохицуулалт	23
2.2. Сонгуулийн маргаан шийдвэрлэж буй байгууллагуудын эрх хэмжээ, зохион байгуулалт	29
2.3. Эрх зүйн зохицуулалт, тогтолцооны хүрээнд хийсэн шинжилгээ	36
2.4. Маргаан шийдвэрлэх ажиллагаа дахь олон нийтийн оролцоо ба ил тод байдал.....	59
2.5. Практик судалгаа: 2020, 2021, 2024 оны сонгуультай холбоотой зөрчил, маргаан, түүнийг хянан шийдвэрлэсэн үйл ажиллагааны мэдээлэл шинжилгээ	61

ГУРАВ. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕССЫН САЙН ТУРШЛАГА..... 93

- 3.1. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох олон улсын туршлага ба харьцуулалт: Мексик, Бүгд Найрамдах Солонгос, Эстони, АНУ (Калифорни).....95
- 3.2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны хяналт, цахим систем хэрэгжүүлж буй олон улсын туршлага ба харьцуулалт: Мексик, Бүгд Найрамдах Солонгос, Эстони, АНУ (Калифорни) 110

ДҮГНЭЛТ..... 115

ЗӨВЛӨМЖ 118

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ 123

ХАВСРАЛТ 128

- Хавсралт №1: Нэр дэвшигчээс хасах гэмт хэрэг, зөрчлийн зохицуулалт128
- Хавсралт №2: Гомдол мэдээлэл гаргах эрх олгосон хууль тогтоомжийн зохицуулалтууд 131
- Хавсралт №3: Цэцийн шийдвэрүүдийн түүвэр шинжилгээ 132
- Хавсралт №4: Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын суурь зарчим, шаардлагуудын тодорхойлсон баримт бичгийн түүвэр 135
- Хавсралт №5: Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчил ба түүнийг шалган шийдвэрлэх байгууллагын чиг үүргийн уялдаа 138
- Хавсралт №6: 1992 оноос 2020 он хүртэлх УИХ-ын сонгуулийн тухай хуулиуд болон холбогдох хуулиудын маргаан шийдвэрлэх зохицуулалтуудын харьцуулалт 142
- Хавсралт №7: Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зураглал 146
- Хавсралт №8: Түгээмэл сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны харьцуулалт (харьцуулсан судалгаанд сонгон авсан улсуудын хүрээнд) 148

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1:	Маргаан шийдвэрлэх ерөнхий хугацаа	47
Хүснэгт 2:	Улсын бүртгэлийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэл.....	62
Хүснэгт 3:	Шилжүүлсэн өргөдөл гомдлын дүн	66
Хүснэгт 4:	Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэсэн үзүүлэлт.....	66
Хүснэгт 5:	Бүртгэгдсэн гомдол мэдээллийн шийдвэрлэлт	68
Хүснэгт 6:	Бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлт.....	70
Хүснэгт 7:	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн маргаан шийдвэрлэлт	71
Хүснэгт 8:	Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа	72
Хүснэгт 9:	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн маргаан шийдвэрлэлт /2024/.....	73
Хүснэгт 10:	ЗХДЗШШ-ийн 2024 оны сонгуулиар шийдвэрлэсэн хэргүүд	74
Хүснэгт 11:	Нийслэлийн төвийн дүүргийн эрүүгийн шүүхэд шийдвэрлэгдсэн эрүү, зөрчлийн хэргүүдийн тоон мэдээлэл.....	78
Хүснэгт 12:	ТЕГ-т гаргасан гомдол мэдээллийн шийдвэрлэлт.....	80
Хүснэгт 13:	ТЕГ-т гаргасан гомдлын ангилал	81
Хүснэгт 14:	ХХЗХ-ны сонгуулийн үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон мэдээлэл	83
Хүснэгт 15:	Татварын ерөнхий газрын улсын байцаагчаас шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан зөрчлийн мэдээлэл (УИХ 2024).....	88

Хүснэгт 16: Татварын улсын байцаагчийн зөрчлийн шийдвэрлэлт (УИХ 2024).....	88
Хүснэгт 17: Монополын эсрэг газрын 2020–2024 оны сонгуулиудад цахим орчинд илрүүлсэн зөрчил, гомдол, шийдвэрлэлт.....	89
Хүснэгт 18: Монополын эсрэг байгууллага өөрөө илрүүлсэн болон дүгнэлт гаргасан үзүүлэлт.....	90

ДИАГРАММЫН ЖАГСААЛТ

Диаграмм 1: Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлсэн өргөдөл гомдлын хураангуй	64
Диаграмм 2: СЕХ-ны 2020 оны УИХ-ын сонгуулиар шийдвэрлэсэн гомдол (гомдол гаргагчийн төрлөөр)	65
Диаграмм 3: СЕХ-ны 2024 оны УИХ болон орон нутгийн сонгуулиар шийдвэрлэсэн нийт гомдол (гомдол гаргагчийн төрлөөр)	65
Диаграмм 4: Зардлын дансны эцсийн тайлан ирүүлээгүй нэр дэвшигчидтэй холбоотой хэрэг (2024).....	86
Диаграмм 5: Зардлын зарцуулалтын явцын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчидтэй холбоотой хэрэг (2024).....	87
Диаграмм 6: Монополын эсрэг газрын 2020–2024 оны сонгуулиудын өргөдөл гомдлын шийдвэрлэлт	90

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНСДИТХСтХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тухай хууль
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага
ЗГ	Засгийн газар
ЗХДЗШШ	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИХСтХ	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын их хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй нийгэм форумаас сонгуулийн ил тод байдал, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн судалгаа, мониторинг, нөлөөллийн ажлыг тууштай дэмжин, энэ хүрээнд сонгуулийн байгууллага, Улсын Их Хурал, судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж ирлээ. Энэ удаад Виндекс өмгөөллийн ХХН-ийн Б. Баялагмаа, Д. Батпүрэв тэргүүтэй залуу судлаачдын гүйцэтгэсэн «Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох нь» судалгааны тайланг Та бүхэнд хүргэж байна.

Сонгох, сонгогдох эрхийг баталгаатай хангах нэг чухал нөхцөл нь сонгуулийн маргааныг ил тод, шударгаар шийдвэрлэх явдал билээ. Сонгуулийн процесс нь хуульд заасан тодорхой цаг хугацаанд явагддаг онцлогтой тул сонгуультай холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, буруутай этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг энэхүү онцлогт нийцүүлэн зохицуулах шаардлага урган гардаг.

Монгол Улсад сонгуулийн эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд дээрх зорилгыг хангахад чиглэсэн зарим оролдлого хийгдсэн ч маргаан шийдвэрлэгдэхгүй байсаар сонгууль дуусах, нэгэнт сонгуулийн үр дүн гарсан бол гомдол, мэдээлэл гаргагчийн хэрэг хянан шийдвэрлүүлэх идэвх оролцоо буурах, зөрчигдсөн эрх сэргээх боломжгүй болох гэх мэт асуудал гарсаар байна. Судлаачдын зүгээс энэ мэт тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийн, бусад ардчилсан улсын сайн туршлагыг судлан харьцуулсны зэрэгцээ эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн тодорхой зөвлөмж боловсруулж танилцуулсан нь сонгуулийн эрх зүйн шинэчлэлийг тойрсон яриа хэлэлцүүлэгт хувь нэмэр болно гэж найдаж байна.

Нээлттэй нийгэм форумын Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Ардчилсан тогтолцоонд шилжин ардчилсан, чөлөөт сонгуулиар төрийн эрх барих төлөөллийн байгууллага болох УИХ-аа сонгон байгуулж эхэлснээс хойш даруй 30 гаруй жил өнгөрч, 9 удаагийн сонгууль зохион байгуулагдаад байна. Гэвч сонгуулийн үйл ажиллагаа, улс төрийн нам, улс төрч, парламентад итгэх олон нийтийн итгэл сул, сонгуульд байгууллага, албан тушаалтны легитим шинж хангалтгүй хэвээр байгаагийн нэг шалтгаан нь сонгуулийн үеийн шударга бус үйлдэл, шийдвэр, үйл ажиллагаа сонгогчдын нүдэнд ил байх, зарим тохиолдолд иргэд, сонгогчид хууль бус үйл ажиллагааны оролцогч, гэрч нь болж байдагтай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, сонгогчдын нүдний өмнө өрнөж буй шударга бус өрсөлдөөн, зөрчилтэй үйлдлүүд нь сонгогч иргэд, олон нийтийн ардчилсан сонгууль түүний үр дүнд, итгэх итгэл, үнэмшилд сөрөг нөлөө үзүүлсээр ирсэн.

Сонгуулийн оновчтой, шударга тогтолцоог сонгох, улс төрийн нам, нэр дэвшигчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн ил тод байдлыг хангах зэрэг олон асуудал нь сонгуулийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй боловч сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, үүссэн зөрчил маргааныг зүй ёсны, шударга процессоор үр нөлөөтэйгөөр шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хууль ёсны, шударга сонгууль явуулах хууль зүйн баталгаануудын нэг болдог.

Нөгөө талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан сонгох, сонгогдох эрхийн баталгааг төрөөс хангах үндсэн арга механизмуудын нэг нь сонгуулийн үеийн хэрэг маргааныг шударгаар, үр дүнтэй, шуурхай шийдвэрлэх хууль зүйн орчныг бүрдүүлэх явдал мөн. Монгол Улсын хувьд сонгууль болгоныг угтан хууль зүйн орчны, өөрчлөлт, шинэчлэл, сайжруулалт хийхийг зорьж ирсэн боловч сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн

орчин болон зохион байгуулалт төдийлөн хангалттай боловсронгуй болоогүй, сайн жишигт хүрээгүй, институци хоорондын зохицуулалт сул хэвээр байна. Энэхүү нөхцөл байдал нийгэм олон нийтийн итгэлцэл, сонгуулийн легитим чанарт сөргөөр нөлөөлөх хандлагатай болсныг сүүлийн үеийн судалгаа, ажиглалтын тайлангууд харуулж байна.¹

Судлаачдын зүгээс дээрх нөхцөл байдлын суурь шалтгааныг маргаан шийдвэрлэх зарим харьяалал, зохион байгуулалт нь оновчгүй, процессын зохицуулалтууд нь сонгуулийн хууль тогтоомж буюу материаллаг хэм хэмжээтэй нийцдэггүйн зэрэгцээ, иргэд, олон нийтийн мэдээлэл авах, хяналт тавих, гомдол гаргах сэдэл боломж нөхцөл хангалтгүй, маргаан шийдвэрлэх тогтолцоо, үйл ажиллагааны ил тод байдал, хөндлөнгийн хяналт сул зэргээс үүдэлтэй байж болзошгүй гэх боломжит таамаглалд тулгуурлан энэхүү судалгааг хийлээ.

Эдгээр асуудлын шалтгааныг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зорилгын хүрээнд сонгуулийн маргаан шийдвэрлэх үндэс, эрх зүйн орчныг шинжлэх, институцийн зохион байгуулалт, харилцан хамаарал зэрэгт дүн шинжилгээ хийх, хууль зүйн зохицуулалт, практик хэрэгжилтэд үнэлгээ өгөх, олон улсын нийтлэг жишигтэй харьцуулах зэргээр судлахыг зорьлоо. Ингэхдээ өмнө үйлчилж байсан сонгуулийн хууль тогтоомжууд дахь маргаан шийдвэрлэх зохицуулалтын онцлогийг товч тодруулаад судалгааны шууд ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн дүн шинжилгээ, практик судалгааны хүрээг 2019-2025 оныг хамруулан тогтоосон болно.

1 АИХЭГ. Улсын Их Хурлын Сонгууль. АИХЭГ-ын Сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан. 2024. 23-24 дэх тал, Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. 2025. 86-98 дахь тал гэх мэт

НЭГ. СОНГУУЛИЙН МАРГААН, ТҮҮНИЙ ОНЦЛОГ ШИНЖ

1.1. Сонгуулийн маргааны онцлог, төрөл, ангилал

Хүний эрхийн олон улсын болон үндэсний баримт бичгүүдэд тусгагдан баталгаажсан сонгуулийн эрх, эрх чөлөөг хамгаалах, сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нэгэн чухал хууль зүйн баталгаа нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа билээ. Энэ агуулгаараа сонгуулийн маргааныг сонгуулийн онцлог, зарчим, мөн чанартай уялдуулан сайтар гүнзгий ойлгох нь маргаан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтад үндэслэл бүхий үнэлэлт, дүгнэлт өгөх суурь нөхцөл болох юм.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс “сонгуулийн маргаан”-ыг сонгуулийн үйл явцтай холбогдох аливаа маргаан, саад бэрхшээл, шаардлага, санал зөрөлдөөн гэж тодорхойлсон² нь тус ойлголтын хүрээг харуулж байна. Өргөн утгаараа сонгох, сонгогдох эрхээ эдлэх явцад үүсэх аливаа зөрчилдөөнийг ойлгох боловч эдгээр нь үүсэх хэлбэр, оролцогч, үр дагавар зэргээр шалтгаалан өөр өөр агуулга, цар хүрээтэй байдаг. Үүнд, сонгогч, нэр дэвшигчийн сонгуулийн эрхийн эсрэг зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдээс эхлээд засгийн эрхийн төлөөх зохион байгуулалттай хууль бус үйл ажиллагаа хүртэл хамаарч болохоос гадна сонгуулийн

² IDEA, Electoral Justice: An overview of the International IDEA Handbook, 2010, 36 дах тал, <https://www.idea.int/sites/default/files/publications/chapters/electoral-justice-handbook/electoral-justice-handbook-overview.pdf>

байгууллагуудын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой асуудлууд ч томоохон байр суурийг эзэлдэг.

Өөрөөр хэлбэл, сонгуулийн хууль тогтоомж нь бүхэлдээ сонгуулийн эрх, эрх чөлөөг хангах хамгаалах, сонгуулийн үйл ажиллагааг зүй ёсоор явуулахад зориулагддаг бол сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаа, зохион байгуулалтын тогтолцооны эцсийн зорилго нь эдгээр хууль тогтоомжийн биелэлтийг сахин хамгаалах иргэний сонгуулийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэхэд оршдог билээ.

Товчхондоо сонгуулийн маргаан нь зөвхөн санал өгөх өдөр эсхүл сонгуулийн үр дүнтэй холбоотой гомдлоор хязгаарлагдахгүй бөгөөд сонгуулийн явцад үүсэж болох бүхий л төрлийн маргааныг хамарна. Иймд сонгуулийн маргаан нь сонгуулийн процессын янз бүрийн шатанд үүсэж болохыг³ анхаарч үе шат тус бүрд тохирсон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оновчтой журам тогтоохыг зорих нь чухал юм.

Сонгуулийн маргааны төрөл, ангилал:

Сонгуулийн маргааны төрөл, ангиллууд нь сонгуулийн маргааныг танин мэдэх, агуулга, шинж чанар, цар хүрээг системтэйгээр тодорхойлон ойлгоход дэмжлэг болохоос гадна маргаан шийдвэрлэх харьяалал, журмыг оновчтой тогтооход ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх асуудлыг хөндсөн ном, судалгааны бүтээл, гарын авлага зэрэгт сонгуулийн үе шат, харьяалал, агуулга зэргээс нь хамааруулан олон янзаар ангилж авч үзжээ. Тухайлбал,

- I. Сонгуулийн тогтолцооны олон улсын сангаас 2011 онд боловсруулсан “Сонгуулийн маргааныг ойлгох, хянан шийдвэрлэх, зохицуулах зааварчилгаа”-нд сонгуулийн маргаан, гомдлууд гарч болох доорх гол чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

³ European Commission for Democracy through Law (Venice Commission), Report on Election Dispute Resolution, 2020, 4 дэх тал. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdf=CDL-AD\(2020\)025-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdf=CDL-AD(2020)025-e)

- Сонгогчийн бүртгэлтэй холбоотой маргаан
- Нэр дэвшигчийн бүртгэл үйл ажиллагаатай холбоотой маргаан
- Доод шатны сонгуулийн түр байгууллагыг томилохтой холбоотой маргаан
- Сонгуулийн үеийн зүй бус нөлөөлөл, дарамт зэрэгтэй холбоотой хэрэг, зөрчил
- Сонгуулийн сурталчилгааны зөрчил
- Санал хураалт болон тооллогын үйл ажиллагаа дахь зөрчил
- Сонгуулийн үр дүн, суудал хуваарилалтай холбоотой маргаан

Энэхүү ангилал нь гомдол хянан шийдвэрлэх ямар тогтолцоотой байхаас үл хамааран гарч болох нийтлэг асуудлуудыг багцлан сонгуулийн зохион байгуулалтын үе шатанд тулгуурлан тодорхойлсноороо онцлогтой гэж үздэг. Түүнчлэн тус ангилал нь маргаан шийдвэрлэх харьяаллыг оновчтой тогтоох онолын үндэслэлүүдийн нэг байх боломжтой юм.

II. Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгээр 2014 онд боловсруулсан “Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” судалгаанд сонгуулийн хууль тогтоомжуудын хүрээнд сонгуулийн маргааныг эрх зүйн үр дагавраар нь дараах байдлаар төрөлжүүлэн ангилжээ.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаанд сонгуулийн байгууллагуудын дотоод зохион байгуулалт, сонгууль зохион байгуулах талаар сонгуулийн байгууллагаас гаргаж байгаа гадагшаа чиглэсэн шийдвэр, үйл ажиллагаа, сонгуулийн байгууллагын албан тушаалтны сахилга баттай холбоотой үүссэн маргааныг хамааруулна.
Сонгох эрхтэй холбоотойгоор үүсэх маргаан	Сонгуулийн тухай хуулиудад зааснаар энэ төрлийн маргаанд сонгогчийн бүртгэлийн талаарх маргаан буюу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилтийг бүртгэхгүй байх зэрэг зөрчилтэй холбогдон үүссэн маргаан хамаарч байна.

Сонгогдох эрхтэй холбоотойгоор үүсэх маргаан	Сонгуулийн хуулиудад зааснаар энэ төрлийн маргаанд нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотойгоор үүсэх маргаан, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах, нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүний эрхийг хязгаарлахтай холбогдон үүсэх маргаан хамаарахаар байна. Түүнчлэн энэ төрлийн маргаанд нам, эвслийн бүртгэлтэй холбогдсон маргаан, цаашлаад хууль нам, эвслийг сонгуульд оролцох эрхийг нь хязгаарлахтай холбогдсон маргаан мөн хамаардаг.
Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх маргаан	Үүнд сонгуулийн мөрийн хөтөлбөрт аливаа төрлийн мөнгө, эд хөрөнгө олгох, хувь хишиг хүртээх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр амлалт тусгах, хуулиар хориглосон этгээдээс хандив авах, сонгуулийн сурталчилгааны үеэр хуульд хориглосон үйлдэл явуулах зэрэг зөрчил, ажиллагаатай холбоотойгоор үүссэн маргаан хамаарахаар байна. Энэ төрлийн маргааны онцлог нь өрсөлдөгч нам, эсвэл, нэр дэвшигчийн идэвхтэй гомдол саналын үндсэн дээр үүсэж, шийдвэрлэгдэх ба эрхзүйн үр дагавар нь хууль зөрчсөн нэр дэвшигч болон нам, эвсэл нь захиргааны хариуцлагаас гадна нэрийн жагсаалтаас хасагдах хүртэл хариуцлага хүлээдэгт оршино.
Санал авах, санал хураалтын дүнг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх маргаан	Энэ төрлийн маргаанд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажиллагааг явуулах, санал, саналын хуудсыг хүчингүйд тооцох, санал хураалтын дүнг гаргаж, нэр дэвшигчийн үнэмлэх олгох, дахин сонгуультай холбогдсон зөрчил маргаан хамаарна.
Сонгууль ажиглахтай холбогдсон маргаан	Энэ төрлийн маргаан нь нэг талаас ажиглагчийн үйл ажиллагаатай холбоотой боловч нөгөө талаас ажиглагчийн шаардсанаар сонгуулийн үйл явцад гарсан сонгууль зохион байгуулалттай холбогдсон маргаан ч хамаарч болно.
Сонгуулийн сурталчилгааны явцад сонгуулийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээж байгаа мэдээ, үйл баримттай холбоотой маргаан	Энэ төрлийн маргаан нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв мэдээлэл гарсан эсэх, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийг гүтгэсэн, доромжилсон мэдээлэл гарсантай холбогдуулан үүсэх маргааны ойлгож болно. Маргааны үр дагаварт сонгогч сонголтоо хийхэд бодит мэдээлэл авах боломж гарах ба нам, эвсэл, нэр дэвшигчийн албаны болон хувийн нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад оршино.

Дээрх ангиллыг 2014 оны үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан сонгуулийн хууль тогтоомж, Монгол Улсын сонгуулийн маргааны практикт тулгуурлан эрхзүйн үр дагавар болон маргааны шинжийг үндсэн шалгуур болгон хийжээ. Тус ангилал нь Монгол Улсын хувьд сонгуулийн үе шат бүрд үүсэж болох маргааны цар хүрээ, гарч болох эрсдэл, үүсэж болох үр дагаврыг бүхэлд нь харуулахыг зорьсон байна.

III. Судлаач Д.Бат-Эрдэнэ “Сонгуулийн процессын эрх зүй” илтгэлдээ сонгуулийн маргааныг хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үндэсний суурь тогтолцоотой уялдуулан дараах байдлаар ангилан танилцуулжээ.

- Зохион байгуулалттай холбоотой маргаан (*сонгуулийн болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой захиргааны журмаар шийдвэрлэгдэж буй маргаан*)
- Зөрчлийн хэрэг (*Зөрчлийн тухай хуульд заасан сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчил холбогдох маргаан*)
- Эрүүгийн хэрэг (*Эрүүгийн хуульд заасан сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдэд холбогдох маргаан*)
- Захиргааны хэрэг (*Бүх шатны сонгуулийн байгууллагын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой захиргаан хэргийн шүүхэд үүссэн маргаан*)
- Үндсэн хуулийн цэцийн маргаан (*Сонгуулийн төв байгууллагын сонгуулийн дүнг өргөн барьсан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх болон Сонгуулийн хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаан*)

Энэхүү ангилал нь Монгол Улсын өнөөгийн сонгуулийн маргаан шийдвэрлэж буй тогтолцооны үндсэн бүтэц, хууль тогтоомжийн системчлэлд тулгуурласан нь харьцангуй ойлгомжтой байхын зэрэгцээ Монгол Улсын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж буй тогтолцооны шинж, онцлогийг тодорхой харуулжээ.

IV. Харин судалгааны багийн зүгээс Монгол Улсын сонгуулийн үйл ажиллагааны үе шат, хууль зүйн үр дагавар, сонгуулийн үйл ажиллагааны онцлогоос хамааруулан дараах байдлаар ангилах боломжтой гэж үзэж байна.

Сонгуулийн өмнөх үеийн маргаан: /Нэр дэвшигчээр бүртгэхээс өмнөх/	Сонгуулийн үеийн маргаан: /Нэр дэвшигчээр бүртгэгдсэнээс сонгуулийн дүн гарах хүртэл/	Сонгуулийн дараах маргаан: / Сонгуулийн дүн гарснаас хойш/
- Сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой Үндсэн хуулийн цэцийн маргаан - Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлтэй холбоотой маргаан - Улс төрийн намын үйл ажиллагаа, бүртгэлтэй холбоотой маргаан - Сонгуулийн жилд тавигдах хориглолт хязгаарлалтын зөрчсөнтэй холбоотой маргаан - Сонгуулийн хэсэг, тойрог байгуулахтай холбоотой маргаан - Сонгуулийн бэлтгэл ажилтай холбоотой сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой маргаан гэх мэт	- Нэр дэвшигчээр бүртгэх, татгалзахтай холбоотой маргаан - Санал хураалт, санал тоолох процесстэй холбоотой маргаан - Сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилтай холбоотой маргаан - Сонгуулийн үйл ажиллагааны явцад хориглосон үйл ажиллагаа, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой бусад маргаан	- Сонгуулийн жилд болон сонгуулийн үеэр гаргасан хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой маргаан - Санхүүжилт, зардлын тайлан, сурталчилгааны тайлан зэрэг тайлагнал, хууль тогтоомжийн биелэлттэй холбоотой маргаан

Энэхүү ангилалыг хийхдээ өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн агуулга, маргаан шийдвэрлэх ажиллагааны практик дүн шинжилгээнд тулгуурлан үүсэж болох бүхий л сонгуулийн маргааныг өргөн хүрээнд багтаан маргааны цаг хугацаа, үр дагаврын шалгуурыг давхар авч үзсэнээрээ онцлогтой юм.

Түүнчлэн тус ангилал нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны “үр дүнтэй” байх зарчмыг хэрэгжүүлэх буюу маргаан үүссэн үе шат бүрд тохирсон хугацаа, журмыг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагыг онолын хувьд дэмжих нөхцөл болно.

Тухайлбал, Монгол Улсын сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үүсэж буй дийлэнх хүндрэл, бэрхшээл нь цаг хугацааны хувьд сонгуулийн үеийн буюу нэр дэвшигчээр бүртгэгдсэнээс хойш сонгуулийн дүн гарах хүртэлх богино цаг хугацаанд хамаарч байгаа нь энэхүү үе шатанд үүсэж буй маргаан шийдвэрлэх ажиллагаанд илүү анхаарал хандуулах, гүнзгий судлах шаардлагатайг илтгэдэг.

1.2. Сонгуулийн үндсэн зарчмууд болон маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын үндэс

Сонгуулийн үндсэн зарчмуудыг маргаан шийдвэрлэх ажиллагаанд харгалзан үзэх нь

Сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь маргаан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүнг үнэлэх шалгууруудын чухал суурь болох ба зарим тохиолдолд бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Иймээс сонгуулийн зарчмууд, тэдгээрийн агуулга мөн чанарыг бүрэн, үнэн зөвөөр танин мэдэх, тодорхойлох нь сонгуулийн маргаан, түүнийг шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг гүнзгий түвшинд ойлгох, хэрэгжилтийн үнэлгээ хийж дүгнэлт өгөх, зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой билээ.

Нөгөө талаар, сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаа болон бусад төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны гол ялгаа нь сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд болон сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой шууд холбоотой ч гэж үзэж болно.

Сонгуулийн үйл ажиллагааны зарчмуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гучин нэгдүгээр

зүйлийн 3 дахь хэсэгт “нийтээрээ⁴, чөлөөтэй⁵, нууц⁶, шууд⁷” байх хэмээн тусган баталгаажуулсан бөгөөд эдгээр зарчмууд болон түүний агуулга, хэрэглээ нь хүний эрхийн олон улсын суурь баримт бичгүүд болох Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ)⁸, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)⁹ зэргийн холбогдох заалтууд тэдгээрийн тайлбараас¹⁰ шууд урган гардаг.

Эдгээр зарчим нь сонгуулийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүхий л шатанд хэрэгжих бөгөөд **сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын үндэс нь болдог**. Энэ ч утгаараа сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтууд тус зарчмуудын мөн чанарыг харгалзан үзсэн,

⁴ Энэхүү зарчим нь хүн бүр сонгуульд санал өгөх болон нэр дэвших эрхтэй байх агуулгыг илэрхийлэх бөгөөд энэхүү агуулгын хүрээнд тухайн эрхээ эдлэхэд тавигдах тодорхой нөхцөл, шаардлагын стандарт хүрээ, хязгаар ч хамаарна.

⁵ Уг зарчим нь өргөн хүрээнд сонгогч нь нам, нэр дэвшигчийн талаарх мэдээлэл цуглуулах өөрийн санал бодлыг чөлөөтэй бүрдүүлэх буюу аливаа зүй бус нөлөөллөөс ангид байх, төрийн байгууллага сонгуулийн үйл ажиллагааг төвийг сахих үндсэн агуулгатай.

⁶ Тус зарчим нь сонгогчийн саналаа нууцлах эрхийн баталгаа бөгөөд сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд саналын нууцлал зөрчигдсөн бол саналын хуудсыг хүчингүй болгох үндэслэл болох учиртай.

⁷ Энэхүү зарчим нь төлөөллийн ардчиллын шууд илэрхийлэл бөгөөд хууль тогтоох байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төлөөллийг шууд санал өгөх замаар сонгон байгуулах тодорхой агуулгатай.

⁸ ХЭТТ-ын 21-р зүйлийн 1 дэх хэсэг “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцох эрхтэй”, 3 дахь хэсэг “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно”

⁹ ИБУТЭТОУП-ын 25 дугаар зүйлийн (b) хэсэг “Иргэн бүр сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрх, боломжийг эдэлнэ”

¹⁰ Office of the High Commissioner for Human Rights, General Comment No.25: The right to participate in public affairs, voting rights and the right of equal access to public service (Art.25): 12/07/96. CCPR/C/21/Rev.1/Add.7, General Comment No.25. (General Comments) <https://www.equalrightstrust.org/ertdocumentbank/general%20comment%2025.pdf> – дэлгэрүүлэн үзнэ үү.

агуулга, шаардлагад нийцсэн байвал зохистой. Өөрөөр хэлбэл, маргаан шийдвэрлэх процесст сонгуулийн үйл ажиллагааны онцлогийг тохиромжтойгоор шингээсэн тохиолдолд сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны оновчтой зохицуулалт болж чадах билээ.

Нөгөөтээгүүр, сонгуулийн эрх, эрх чөлөөг үр дүнтэй хангах, хамгаалах, сонгуулийн зарчмуудыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд маргаан хянан шийдвэрлэх тогтолцоог дотоодын хууль тогтоомжийн хүрээнд олон улсын нийтлэг хэм хэмжээ, стандартад нийцүүлэн оновчтой бүрдүүлсэн байх явдал мөн.

Тиймээс сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт, хэм хэмжээ нь нэг талаас хүний сонгуулийн үндсэн эрхийн бодитой хамгаалалт бий болгох, нөгөө талаас сонгуулийн үйл ажиллагааны онцлог, зарчимд нийцсэн үр дүнтэй процесс бий болгох зорилгод чиглэж байдаг.

Тус зорилгод нийцэх эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэхийн тулд сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо, хууль тогтоомжид тавигдах нийтлэг шаардлага, суурь зарчим буюу зохицуулалтын үндсийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх хэм хэмжээ ба тогтолцоонд тавигдах нийтлэг шаардлага буюу зохицуулалтын үндэс

Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хамаарах тусгайлсан зохицуулалтуудын гол үндэс нь бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адил Монгол Улсын Үндсэн хууль¹¹, ХЭТТ¹², ИБУТЭТОУП¹³ зэрэг суурь баримт бичгүүдээр баталгаажуулсан “эрх зүйн хамгаалалт эдлэх” буюу шүүх, эрх бүхий байгууллагад хандах эрх билээ.

Үүний зэрэгцээ сонгуулийн үйл ажиллагааны явцад үүсдэг маргааны онцлогоос шалтгаалан сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтууд тодорхой зарчим, нийтлэг стандартуудад нийцсэн байхыг зөвлөдөг. Эдгээр зарчим, стандартууд нь ихэвчлэн олон улсын байгууллагуудын тайлбар, зөвлөмж, гарын авлага болон бусад баримт бичгүүдийн хүрээнд тодорхойлогдсон бөгөөд нэг талаараа маргаан шийдвэрлэх зохицуулалтуудын үндэс буюу суурь зарчим, нөгөө талаараа маргаан шийдвэрлэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг үнэлэх шалгуур болон хэрэглэгдэж байна.

Үүнд, НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№25, §25, 1996), Олон улсын парламентын холбооны “Чөлөөт, шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтийн тунхаг”, Европын Аюулгүй

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... шударга шүүхээр шүүлгэх ... шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй”

¹² ХЭТТ-ын 7 дугаар зүйл “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”, 8 дугаар зүйл “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”

¹³ ИБУТЭТОУП-ын 2 дугаар зүйлийн (3) дах хэсгийн (а) энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах, (б) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх, (с) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах”

Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-аас эрхлэн гаргасан “Сонгуулийн маргаан шийдвэрлэх аргачилсан зөвлөмжүүд”, Венецийн комиссын 2002 оны 51-р хуралдаанаар баталсан “Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын кодекс”, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (АИХЭА)-аас боловсруулсан “Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны гарын авлага”, Сонгуулийн тогтолцооны олон улсын сангаас боловсруулсан “Сонгуулийн маргааныг ойлгох, хянан шийдвэрлэх, зохицуулах зааварчилгаа”, Ардчилал, Сонгуульд туслах олон улсын хүрээлэнгээс боловсруулсан “Зүй ёсны сонгууль гарын авлага” зэрэг баримт бичгүүдийн холбогдох хэсгүүд хамаарч байна. Эдгээрийг судалгааны багийн зүгээс агуулга, ач холбогдол, дотоодын зохицуулалтын онцлог зэрэгт тулгуурлан нэгтгэж доорх зарчмуудыг онцолж байна.¹⁴

Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоо болон зохицуулалтын суурь зарчмууд:

- (1) Сонгуулийн маргааныг шийдвэрлэх процесс тодорхой бөгөөд хүртээмжтэй байх;
- (2) Маргааныг хараат бусаар бие даан шийдвэрлэх хууль зүйн баталгаа, бүрэн эрх олгогдсон байх;
- (3) Гомдол, нэхэмжлэл гаргах, давж заалдах, процесст оролцох эрхийг хангалттай өргөн хүрээнд олгосон байх;
- (4) Гомдол маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, үр дүнтэй байх;
- (5) Гомдол, маргааныг ил тод, шударгаар шийдвэрлэх тогтолцоо, хууль зүйн нөхцөл хангагдсан байх;
- (6) Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үр нөлөөтэй байх;

Дээрх зарчим нь улс бүрийн дотоодын хууль тогтоомж, сонгуулийн тогтолцоо, төрийн байгуулалтын онцлог зэргээс хамааран хэрэгжилт нь харилцан адилгүй байх боловч дийлэнх тохиолдолд эдгээр зарчмыг бодитоор хэрэгжүүлэх нь маргаан шийдвэрлэх тогтолцоонд томоохон эерэг нөлөө үзүүлдэг ажээ.

¹⁴ Дээр дурдсан үндсэн эх сурвалжуудаас авсан түүврийг Хавсралт № 4-өөс танилцах боломжтой.

Нөгөөтэйгүүр бүх улс оронд сонгуулийн маргааныг шийдвэрлэхэд яг тохирох ганц загвар гэж байхгүй. Ямар загвараар явах нь ардчиллын түвшнээс басхүү хамаардаг.¹⁵ Өөрөөр хэлбэл, зарим улс орнуудын хувьд (Скандинавын орнууд зэрэг) улс төрийн соёлын түвшин нь ямар ч хатуу дүрэм журмаас илүүтэй зохицуулдаг бол ийм уламжлал хараахан тогтоогүй, ардчилалд шинээр шилжсэн орнууд сонгуулийн маргааныг шийдвэрлэх сайн механизмыг тогтоож боловсронгуй хууль тогтоомжтой болох шаардлага зүй ёсоор тавигддаг байна. Тиймээс сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд удирдлага болгох олон улсын жишиг стандарт болон дээр дурдагдсан сонгуулийн болон маргаан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим, зохицуулалтуудыг өөрийн орны онцлогт нийцүүлэн оновчтой загвар зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

¹⁵ Office for Democratic Institutions and Human Rights, Resolving Election Disputes in the OSCE Area: Towards a Standard Election Dispute Monitoring System, 2000, 5 дах тал. <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

2.1. Монгол Улсын хууль тогтоомж дахь сонгуулийн маргаан шийдвэрлэх зохицуулалт

Үндэсний хууль тогтоомж дахь сонгуулийн маргаан шийдвэрлэх зохицуулалт нь тухайн улсын сонгууль, ардчилсан төлөөллийн байгууллагаа бүрдүүлэх ажиллагааны шударга байдлын үндсэн хэмжүүрийн нэг болдог. Энэ утгаараа маргаан шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, үр нөлөөг нь дээшлүүлэх нь тухайн сонгуулийн үр дүн, хүлээн зөвшөөрөгдөх байдалд шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Тиймээс энэхүү хэсэгт 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойших сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн зохицуулж ирсэн болон өдгөө ямар зохицуулалт үйлчилж буйг ерөнхий байдлаар харуулахыг зорив.

2.1.1. 2019 оноос өмнөх сонгуулийн маргаан шийдвэрлэх зохицуулалтын онцлог, өөрчлөлт, шинэчлэл

Монгол Улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн зохицуулалт, онцлогийг тодорхойлохын тулд ардчилсан сонгуулийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил, өөрчлөлт, шинэчлэлийн талаар товч авч үзэх зайлшгүй шаардлагатай билээ.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжин шинэ Үндсэн хуулийн дагуу сонгууль явуулж эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар сонгуулийн хууль тогтоомжийг¹⁶ таван удаа шинэчлэн найруулж өөрчилсөн байна. Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд УИХ-ын 9, Ерөнхийлөгчийн 8, орон нутгийн 8 сонгуулийг зохион байгуулжээ. УИХ, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийн хууль тогтоомжийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтууд нь ижил, төстэй хуульчлагдан хэрэглэгдэж ирсэн байх тул зохицуулалтын түүхэн хөгжлийн онцлогийг тодруулах зорилгоор 1992 оноос 2015 он хүртэлх УИХ-ын сонгуулийн тухай хуулиуд болон холбогдох хуулиудын маргаан шийдвэрлэх зохицуулалтуудын агуулга, хүрээг харгалзан процессын онцлог, дээд шатны байгууллагад гаргасан гомдлыг шийдвэрлэх хугацаа, нэрсийн жагсаалттай холбоотой гомдол шийдвэрлэх журам гэсэн үзүүлэлтүүдээр харьцуулж үзлээ.¹⁷

Тус харьцуулалтын үр дүнгээс үзэхэд Монгол Улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо 1992-2015 оныг хүртэл шатахисан, илүү нарийвчилсан зохицуулалттай болсон боловч ил тод байдал, шуурхай шийдвэрлэлтийн зарчим ихэнхдээ бүрэн хангагдаж чадахгүй байсан гэж дүгнэх үндэслэлтэй байна. Харин 2015 онд батлагдсан сонгуулийн нэтгэсэн хуульд гомдол маргаан хянан шалгах олон шатлал бүхий нарийвчилсан бүтэц зохион байгуулалтыг бий болсон боловч энэ нь бодит нөхцөлд хэрэглэхэд ээдрээ төвөгтэй, сонгууль тус бүрийн онцлог, ялгаатай нөхцөл байдалд зарим талаар нийцэхгүй байсан нь сонгууль бүр тусдаа бие даасан хуультай байх өөрчлөлтийг дахин хийх үндэслэл болжээ.

¹⁶ УИХ-ын сонгуулийн хуулиуд (1992, 2005, 2011, 2015, 2019), Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулиуд (1996, 2007, 2012, 2015, 2020), Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиуд (1993, 2012, 2015, 2020)

¹⁷ Харьцуулалтыг хавсралт №6-аас үзнэ үү.

2.1.2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үйлчилж буй хүчин төгөлдөр хууль тогтоомжийн зохицуулалтууд

Сонгуулийн маргааныг шийдвэрлэх зохицуулалт нь ардчилсан төрийн тогтолцоо, иргэдийн үндсэн эрхийг хэрэгжүүлэх, сонгуулийн шударга, ил тод байдлыг хангах чухал арга хэрэгслүүдийн нэг бөгөөд Үндсэн хууль бусад органик болон салбарын хуулиудад тодорхой тусгагдсан байдаг. Эдгээр хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтын агуулга, хүрээ, уялдаа холбоо, эрх зүйн орчныг бүрэн тодорхойлох нь сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үр нөлөө, бодит нөхцөл байдал, хийдэл, дутагдлыг тогтооход чухал ач холбогдолтой билээ.

Монгол Улсад сонгуулийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт дараах гол хууль зүйн эх сурвалжуудад доорх байдлаар тусгагдсан байна:

1. Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь ард нийтийн санал асуулга, УИХ, түүний гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулна” гэж заасан. Энэ заалт нь Үндсэн хуулийн цэцэд зөвхөн сонгуулийн тодорхой төрлүүдийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуультай нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргах бүрэн эрх олгож буй зохицуулалт юм. Энэхүү зохицуулалтаар улс төр, нийгмийн хүрээг хамарсан томоохон маргаан, нийтээрээ эргэлзээ төрүүлж болзошгүй сонгуулийн асуудлыг Үндсэн хуулийн хяналтын байгууллагын хяналтын хүрээнд багтааснаараа ач холбогдолтой.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтаар Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг баталгаажуулан тусгаж цэцийн бүрэн эрхийг процессын хуулийн хүрээнд тодорхойлсон.

2. Сонгуулийн тухай хуулиуд

Монгол Улсад сонгуулийн харилцаа нь төрийн тогтолцоо дахь ард түмний төлөөллийн байгууллагыг бүрдүүлэх ажиллагаанд шууд холбогдох тул эдгээр харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой тогтоож, зөрчигдсөн тохиолдолд шийдвэрлэх оновчтой механизмыг тусгайлсан хуулиар бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг. Уг шаардлагын дагуу Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиудын холбогдох зохицуулалтуудын хүрээнд сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим, харилцаа тодорхойлогдож байна.

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар дээрх гурван өөр сонгуулийн харилцааг 1 хуулиар зохицуулсан нь 2016 оны сонгуулийг зохион байгуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх тухайд буюу хууль хэрэглээний олон төрлийн хүндрэл үүсэж байсныг¹⁸ харгалзан цаашид тус бүрд нь бие даасан хуулиар зохицуулах болжээ. Гэвч маргаан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах зохицуулалт, хэм хэмжээ нь ихээхэн төстэй байгаа нь маргаан шийдвэрлэх чиг үүрэгтэй байгууллагуудын хувьд хэрэглээний давуу тал болж байна.

3. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль

Энэ хууль нь санал авах, тоолох, дамжуулах, хураангуйлах ажиллагааг технологийн дэвшилтэт хэлбэрээр гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 болон 10.3.5-д зааснаар, автоматжуулсан системтэй холбоотой гомдол, маргааныг сонгуулийн хороод өөрийн бүрэн эрхийн хүрээнд хянан шийдвэрлэх эрхтэй байхаар тусгажээ.

4. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль

Энэ хуульд Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх, бүтэц, хяналтын механизм тодорхой тусгагдсан. Хуулийн 7.3.4 болон 7.4.3

¹⁸ 2019 оны Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга. 1 дэх тал

дахь заалтуудаар Сонгуулийн ерөнхий хороо нь харьяа доод шатны сонгуулийн байгууллагуудын шийдвэрийг гомдлын дагуу хянах, хүчингүй болгох ерөнхий бүрэн эрхийг олгосон. Энэ нь захиргааны дээд шатны байгууллагын хувиар доод шатны байгууллагуудын үйл ажиллагаанд тавьж буй хяналтын илэрхийлэл бөгөөд ингэснээр гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд буюу захиргааны байгууллагын шаталсан бүтэц тогтолцооныхоо дотор эцсийн шийдвэрийг гаргах механизм тогтоосон байна.

5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

2016 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс буюу 2016 оны сонгуулиас хойш мөрдөгдөж эхэлсэн тус хуулиар УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн талаарх маргааныг Захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр тогтоож хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай хугацаа журмыг тусган хуульчилсан.

6. Эрүүгийн болон зөрчлийн хуулийн зохицуулалт

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.6–14.9-р зүйлд сонгуультай холбоотой тодорхой үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцон 1-5 жил хүртэл хорих, эрх хасах, торгууль ногдуулах ял шийтгэхээр тусгасан.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тодорхой үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт тусгасан. Энэхүү зохицуулалтууд одоогийн хууль тогтоомж дахь сонгуулийн зүй ёсны, шударга байдлыг хангах хамгаалах үндсэн арга хэрэгсэл болж байна.

7. Сонгуулийн ерөнхий хорооны баталсан журам, тогтоолууд

СЕХ-ны дараах дүрэм, журамд маргаан шийдвэрлэхтэй холбоотой тодорхой зохицуулалтууд тусгагдсан байна:

- Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 13,А/57 дугаар хамтарсан тогтоол/тушаалын хавсралтаар батлагдсан “Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журам”

- Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгууль ажиглах нийтлэг журам”
- Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”
- Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”
- Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”
- Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 201 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам (Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль)”
- Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 202 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”

Монгол Улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, салбарын хуулиуд болон Сонгуулийн ерөнхий хорооны баталсан журам, тогтоолуудаар нарийвчлан зохицуулагдсан байх бөгөөд олон шатлалтай, харилцан уялдаатай бүтэц тогтолцоонд тулгуурлаж байна.

Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэцийн хяналтын онцгой бүрэн эрхийг, сонгуулийн тухай тусгай хуулиудад СЕХ болон шат шатны сонгуулийн хороодын маргаан шийдвэрлэх чиг үүргийг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар маргаан шийдвэрлэх эрх бүхий этгээд


болон шүүхийн харьяалал, хугацаа, журмыг тодорхой тусгасан нь эрх зүйн тогтолцооны үндсэн суурь болж байна.

Салбарын гол хуулиуд болох Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн хуулиудын зарчим, үндсэн агуулга, маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтууд нь нэн төстэй байх учир **судалгааны ихэнх хэсэгт сонгуулийн хууль тогтоомжийн зохицуулалтыг хэрэглэх, дүгнэлт, дүн шинжилгээ хийхдээ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийг жишиг болгон ашигласан болно.**

2.2. Сонгуулийн маргаан шийдвэрлэж буй байгууллагуудын эрх хэмжээ, зохион байгуулалт

Сонгуулийн маргаан шийдвэрлэх бүрэн эрх, чиг үүрэг бүхий байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааны талаар Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Сонгуулийн тухай хуулиуд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, СЕХ болон бусад эрх бүхий байгууллагуудаас хамтран баталсан дүрэм журмуудын хүрээнд зохицуулагдаж байна. Энэхүү хэсэгт тусгасан маргаан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, эрх хэмжээг одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид тулгуурлан тодорхойллоо. Энэхүү хэсгээр Монгол Улсын сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн орчныг байгууллагын бүтэц, эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалт, бодит хэрэгжилтийн үүднээс шинжилж, уялдаа холбоог сайжруулах, илүү тогтвортой хариуцлагатай механизм төлөвшүүлэх чиглэлээр санал дэвшүүлэх үндэслэл, нөхцөл бий эсэхийг тодруулахыг зорилоо.

Схем. 1: Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны ерөнхий зураглал



Товчлол: “ХХЗХ” -Харилцаа холбооны зохицуулах хороо, “ТЭГ” -Тагнуулын ерөнхий газар, “УБЕГ” -Улсын бүртгэлийн ерөнхий газар, “СЭХ” -Сонгуулийн ерөнхий хороо, “УДШ” -Улсын дээд шүүх, “ҮЦХ” -Үндсэн хуулийн цэц

Үндсэн хуулийн цэц (ҮХЦ):

Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх тогтолцоонд Үндсэн хуулийн цэц нь сонгуулийн санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр оролцдог. Харин цэцийн практикт тус агуулга бүхий маргаанаас илүүтэй сонгуулийн хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэх тохиолдол илүү түгээмэл байна.

Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ):

СЕХ нь Монгол Улсад сонгуулийг зохион байгуулах, удирдан чиглүүлэх төв байгууллага бөгөөд сонгуулийн явцад гарсан маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй. Энэ хүрээнд зөрчил, гомдол маргааныг хянан шийдвэрлэх, сонгуулийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

- Сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, хяналт тавих;
- Доод шатны сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг хянах, хүчингүй болгох;
- Нам, эвсэл, нэр дэвшигч бүртгэх эсэхийг шийдэх;
- Тухайн нэр дэвшигчийн бүртгэлээс хасах, маргааныг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;
- Шаардлагатай гэж үзвэл сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн дагуу тухайн гомдол, мэдээллийг шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, зөрчлийг арилгах асуудлаар эрх бүхий байгууллагад хугацаатай шаардлага хүргүүлэх.

Зохион байгуулалтын хэлбэр: СЕХ нь 9 гишүүнтэй байнгын байгууллага бөгөөд Нарийн бичгийн дарга, Ажлын албатай. Дэргэдээ сурталчилгааны тэнцвэрт байдлыг хангах, ирүүлсэн гомдол хянаж дүгнэлт гарах чиг үүрэг бүхий хараат бус хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулна.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо:

Аймаг нийслэлийн хороод нь СЕХ-ны удирдлагад ажиллаж, тухайн сонгуулийн тойрогт сонгуулийг бэлтгэх, зохион байгуулах, дүнг нэгтгэх үүрэгтэй. Харин маргаан шийдвэрлэх хүрээнд доод шатны сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг хянах, хүчингүй болгох болон нэр дэвшигчдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, анхан шатны хариуг өгөх үүрэгтэй ажиллаж байна.

Зохион байгуулалтын хэлбэр: Аймаг, нийслэл, дүүргийн түвшинд байгуулагддаг бөгөөд СЕХ-ны шийдвэрийг хэрэгжүүлэх сонгуулийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулах үүрэг бүхий байнгын бус бүтэцтэй.

Сум, дүүргийн сонгуулийн хороо:

Харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий сум, дүүргийн сонгуулийн хороо нь бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үүргийг давхар гүйцэтгэж байна.

Зохион байгуулалтын хэлбэр: Сум, дүүргийн түвшинд байгуулагддаг бөгөөд СЕХ, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны үүрэг даалгавар, шийдвэр хэрэгжүүлэх сонгуулийн үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулах үүрэг бүхий байнгын бус бүтэцтэй.

Хэсгийн хороо:

Санал тоолох, дүн гаргахтай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэхгүй ч зөрчил маргаан шийдвэрлэх ажиллагаанд шууд бус хэлбэрээр оролцож болно.

Зохион байгуулалтын хэлбэр: Сум, дүүргийн түвшинд байгуулагддаг бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд хамаарна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ):

Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх бүрэн эрхийн хүрээнд сонгогч болон түүний гэр бүлийн гишүүнээс ирсэн сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх, гомдлын дагуу оруулсан өөрчлөлтийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Зохион байгуулалтын хэлбэр: Улсын бүртгэлийн нэгж эсхүл хороод дээрх улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Харилцаа холбооны зохицуулах хороо:

Хороо нь сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой гомдлын дагуу тагнуул, цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн санал, албан бичгийг үндэслэн зөрчил гаргасан цахим хуудас болон цахим хуудасны хандалтыг түр хаах, хязгаарлах болон радио телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж өөрийн харьяалан шийдвэрлэх зөрчлийг илрүүлсэн, гомдол ирүүлсэн бол зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэйгээр оролцож байна.

Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх байгууллагууд:

Гэмт хэргийн гомдол мэдээлэл

- Эрүүгийн хэргийн шүүх
- Цагдаагийн байгууллага
- Тагнуулын байгууллага

Зөрчлийн гомдол мэдээлэл

- Эрүүгийн хэргийн шүүх
- Тагнуулын ерөнхий газар
- Цагдаагийн газар
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө/Монополын эсрэг газар
- Монголбанкны хянан шалгагч
- Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
- Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
- Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч
- Татварын улсын байцаагч

Шүүх эрх мэдлийн байгууллага:

Шүүх эрх мэдлийн байгууллагууд нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үндсэн чиг үүргийн хүрээнд сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байсаар ирсэн. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй процессын хуулиуд болон сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд шүүхүүд өөрсдийн харьяаллын дагуу дараах хэрэг маргаануудыг хянан шийдвэрлэж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ийн сонгуулийн талаарх сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох маргаан
- Сонгуулийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эрх бүхий албан тушаалтны шийдвэрт гаргасан захиргааны шүүхийн харьяалан шийдвэрлэх гомдол

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх

- УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар СЕХ-ны шийдвэрт холбогдох маргааныг анхан шатны журмаар
- Бусад анхан шатанд шийдвэрлэсэн сонгуулийн маргаантай холбоотой шийдвэрт гаргасан давж заалдах гомдол

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

- Сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох эрүүгийн хэрэг
- Сонгуулийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эрх бүхий албан тушаалтны шийдвэрт гаргасан эрүүгийн шүүхийн харьяалан шийдвэрлэх гомдол

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

- Сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох эрүүгийн хэргийн шийдвэрт гаргасан давж заалдах гомдол эсэргүүцэл
- Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол

Улсын дээд шүүх

- УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар СЕХ-ны шийдвэрт холбогдох маргааныг давж заалдах журмаар
- Эрүүгийн шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргээс бусад сонгуулийн маргаанд хяналтын журмаар гаргасан гомдол

Хэсгийн дүгнэлт:

Монгол Улсын өнөөгийн сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцоо, тэдгээрийн бүтэц зохион байгуулалт, эрх хэмжээний онцлог нь сонгуулийн шат шатны байгууллагууд зөвхөн сонгуулийн зохион байгуулалтын асуудлаарх гомдол маргааныг хянан шийдвэрлэх бөгөөд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг шалган тогтоох, хариуцлага хүлээлгэхэд оролцохгүй байх, тусгай чиг үүргийг хууль хяналтын байгууллага, албан тушаалтнуудаар шийдвэрлүүлэх зарчмыг тогтоосонд оршиж байна. Тодруулбал, сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааг зөрчил, маргаан шийдвэрлэх бүтэц, үндсэн бааз суурь, зохион байгуулалт, нийтлэг журмуудад тулгуурлан сонгуулийн үйл ажиллагааны зарим онцлогийг шингээн зохион байгуулсан байна.¹⁹

Энэхүү тогтолцооны давуу тал нь гомдол маргааныг хянан шийдвэрлэх харьяаллыг нарийн тогтоож мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудад хариуцуулснаар маргаан шийдвэрлэх харьцангуй тодорхой төрийн эрх мэдлийн бүх салбарыг хамарсан цогц механизмыг бүрдүүлсэнд оршиж байна. Харин сул тал нь чиг үүргийн давхцал, хяналт шийдвэрийн олон шатлал, байгууллагуудын эрх хэмжээний зааг зарим тохиолдолд тодорхой бус байгаа²⁰ нь маргаан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөө, хурд, нэг мөр байдлыг алдагдуулах эрсдэл үүсгэж болзошгүй байна.

¹⁹ Хэрэг маргаан хянан шийдвэрлэх үндсэн бүтэц тогтолцоонд тулгуурлан тодорхойлсон сонгуулийн хэрэг маргааны төрлүүд болон тэдгээрийг хянан шийдвэрлэх субъект, ерөнхий журмыг Хавсралт №7-д үзүүлсэн Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зураглалаас үзнэ үү.

²⁰ Судалгааны тайлангийн дараагийн хэсэгт энэ талаар дэлгэрүүлэн авч үзэх болно.

2.3. Эрх зүйн зохицуулалт, тогтолцооны хүрээнд хийсэн шинжилгээ

Энэхүү судалгааны 3.1.2-т тусгагдсан хууль тогтоомж, тэдгээрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааны бодит нөхцөл байдалд тулгуурлан энэхүү шинжилгээг хийж гүйцэтгэв.

Тус шинжилгээ буюу хууль тогтоомжийн зохицуулалтын үнэлгээг хийхдээ 2 дугаар бүлэгт тусгагдсан сонгуулийн маргаан шийдвэрлэх хэм хэмжээ ба тогтолцоонд тавигдах олон улсын нийтлэг шаардлага, зарчмуудад тулгуурлан шалгуур үзүүлэлтүүдээ тогтоосон бөгөөд Монгол Улсад хэрэгжиж буй сонгуулийн маргаан шийдвэрлэх зохицуулалтууд, түүний хэрэгжилтэд бодитоор дүгнэлт өгөхийг зорьсон болно.

1. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх харьяалал, хил зааг тодорхой эсэх

Сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянах харьяаллын асуудал олон жилийн хугацаанд маргаантай явж ирсэн бөгөөд 2015 онд батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд захиргааны хэргийн шүүхийн болон Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг зааглан хуульчилснаар сүүлийн жилүүдэд тус маргаан зөвхөн онолын түвшинд өрнөх болжээ.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол маргааныг шийдвэрлэх харьяаллыг Сонгуулийн хуулийн хүрээнд тусгайлан зохицуулах болсноос гадна 2019 онд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Сонгуулийн хуулийг зөрчих 39 төрлийн зөрчлийг 9 эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шийдвэрлэхээр хуульчилснаар харьяаллын асуудал харьцангуй тодорхой болсон гэж үзэж болно.

Гэвч зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын маргаан шийдвэрлэлтийн тоон мэдээллээс²¹ үзэхэд харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдол өндөр хувийг эзэлж байгаа

²¹ Кейс судалгаа хэсгээс үзнэ үү.

нь гомдол гаргагчид гомдол шийдвэрлэх харьяаллын талаарх ойлголт, зохицуулалт хангалттай тодорхой биш байгааг илтгэж байна. Эдгээр нь дараах шалтгаан, нөхцөлөөс үүдэлтэй байж болзошгүй байна.

- Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх процессын зохицуулалт агуулсан 10 орчим хууль, 10 гаруй дүрэм журам мөрдөгдөж байх бөгөөд эдгээрийн уялдаа холбоо, зааг ялгааг мэргэжлийн хуульч, мэргэшсэн ажилтан биш тохиолдолд тэр бүр оновчтой зөв хэрэглэхэд хүндрэлтэй нөхцөл болж байна.
- СЕХ-ны зарим журмаар²² зөрчлүүдийн шинж байдлаар нь багцлан зөрчил шалгах хэд хэдэн субъектийг нэг дор заасан, зарим тохиолдолд тухайн төрлийн зөрчил шалгах чиг үүрэггүй субъектийг дурдсан²³ нь төөрөгдөл үүсгэж байж болзошгүй.
- Хууль тогтоомжид өөрчлөлт оруулахдаа уялдаа холбоог хангаагүйгээс үүдэлтэй Сонгуулийн хууль болон Зөрчлийн хуулийн зохицуулалтуудын агуулга зөрчилдсөнөөс зарим зохицуулалт зөрчилд тооцогдох боломжгүй болсон²⁴, Сонгуулийн хуулиар хориглоогүй боловч Зөрчлийн хуулиар зөрчилд тооцсон²⁵ зэрэг нь маргаан шийдвэрлэх харьяаллын талаар ойлгомжгүй нөхцөлийг үүсгэсэн байна.

²² Сонгууль ажиглах нийтлэг журмын 4.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журмын 5.1, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын 6.1, Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмын 5.1 гэх мэт

²³ Тухайлбал, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын 6.1-д “Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг тагнуулын байгууллагад гаргах”-аар заасан нь ойлгомжгүй байна.

²⁴ Жишээлбэл, УИХСтХ-ийн 48.5 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг “Сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж субъектын хүрээг өргөтгөн тусгасан боловч Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад” гэх агуулга хэвээр байна.

²⁵ Тухайлбал, 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр МУИХСтХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн зарим агуулгыг Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцүүлээгүйгээс зөрчил мөн эсэх болон зөрчлийг шалгах харьяаллын талаар тодорхой нөхцөл үүсэж байсан талаар 2024 оны сонгуулийн үеэр ажиллаж байсан зарим хуульчдаас хэлэв.

2. Маргааныг хараат бусаар бие даан шийдвэрлэх хууль зүйн баталгаа, бүрэн эрх олгогдсон эсэх:

Сонгуулийг зохион байгуулж явуулах бүрэн эрхийг СЕХ эдлэх²⁶ бөгөөд үүнтэй холбоотойгоор сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих²⁷, гомдол маргааныг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх²⁸ чиг үүргийг мөн хэрэгжүүлж байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Хороо үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулна”, 3.8 дахь хэсэгт “Хороо, түүний гишүүн хууль ёсны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэж заасан.

Гэвч СЕХ-ны 9 гишүүний тавыг нь УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг нь Ерөнхийлөгч, хоёрыг нь Дээд шүүхээс санал болгон томилж байгаагаас үүдэн олон нийтийн зүгээс УИХ-ын харьяа буюу эрх баригч намаас хамааралтай байгууллага гэж дүгнэх²⁹ нь бий. Мөн бодит байдалд ЦЕГ, УБЕГ газар зэрэг ЗГ-ын харьяа байгууллагуудын удирдлага, төрийн өндөр албан тушаалтнуудын ойрын хүрээллээс томилогдож байгаа нь төвийг сахих боломжийг алдагдуулж байна гэх шүүмжлэл ч бий. Энэхүү хардлага, шүүмж өмнөх сонгуулиудын үед ч байсаар ирсэн бөгөөд ардчилсан сонгуулийн эхний жилүүдэд сонгуулийн ажилд улс төрийн намууд, тэдгээрийн удирдлагууд өөрт үл хамаарах асуудалд оролцож, нэр дэвшигчдээ ялуулахын тулд элдэв арга хэрэглэж Сонгуулийн ерөнхий хороонд дарамт шахалт үзүүлэх явдал байнга тохиолддог³⁰ байсан талаар өгүүлдэг.

Сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлын талаар Венецийн комиссын “Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын кодекс”-ийн 3.1.с, d, e-д сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүнд

²⁶ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг

²⁷ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт

²⁸ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт

²⁹ <https://www.unuudur.mn/a/258746> - “СЕХ-ыг хэн хянах вэ” сүүлд хандсан: 2025.08.06

³⁰ III.Сүхбаатар. “Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон”. Улаанбаатар. 2022 он. 201 дэх тал

парламентад суудалтай намууд эсхүл тодорхой хувийн санал авсан намуудаас сонгуулийн асуудлаар мэргэшсэн этгээдийн санал болгох хувилбарыг тусгасан³¹ бол зарим судлаачид улс төрийн харьяаллаас илүү мэдлэг чадвар, мэргэшил, ёс зүйд нь анхаарах ёстой³² гэж үздэг. Нөгөө талаар нэр дэвшүүлэх процесс, томилгоог ил тод, олон нийтийн санал, оролцоог хангах байдлаар явуулах нь хамгаас чухал болохыг анхаарах шаардлагатай.

СЕХ-оос гадна одоогийн хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн үеийн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий 9 субъектийн хараат бус байдлын асуудал давхар хөндөгдөнө. Эдгээрээс шүүх байгууллагын хараат бус байдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулсан гэж үзэж болох ч сүүлийн үеийн ОУ-ын байгууллага, ажиглагчдын зүгээс шүүхийн хараат бус байдалд олон нийтийн итгэл алдарч буй талаар³³ анхааруулах болсон. Харин бусад зөрчил шалган шийдвэрлэх чиг үүрэг бүхий 8 субъектийн³⁴ хувьд хэдийгээр тус бүрийн эрх зүйн байдлыг тогтоосон хууль тогтоомжийн хүрээнд хараат бусаар ажиллах зарчмын зохицуулалтууд тусгагдсан боловч 6 нь яам, Засгийн газрын агентлаг, тэдгээрийн албан хаагч, 1 нь УИХ-аас удирдлага нь томилогдон ажлаа тайлагнадаг байгууллагын албан хаагч, 1 нь Ерөнхий сайдаас дарга, гишүүдийг нь томилдог байгууллагын албан хаагч байгаа нь сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааны хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

³¹ Хүний эрхийн үндэсний комиссоос 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр улс төрийн 22 намын төлөөлөлтэй хийсэн уулзалтаар сонгуулийн хороог олон талын төлөөлөл бүхий тэнцвэртэй байгуулах талаар санал илэрхийлж мөн зарим намаас уг хүсэлтийг бичгээр илэрхийлсэн талаар Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлд дурдагджээ.

³² Антонио Спинэлли. “Сонгуулийн удирдлагын байгууллагын хараат бус байдлыг хангах загвар”. Сонгуулийн боловсрол. Онол арга зүйн сэтгүүл Дугаар 2025/1. 21 дэх тал

³³ Монгол Улсад Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын талаар НҮБ-ын Тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалт, 20231115-eom-mongolia-sr-ijl-en.pdf

³⁴ Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн байгууллага, Монополын эсрэг газар, Монголбанкны хянан шалгагч, Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, Татварын улсын байцаагч

Сонгуулийн маргаан шийдвэрлэх үр нөлөө бүхий оновчтой тогтолцоо нь шийдвэр гаргах эрх мэдлийн үр дүнтэй байдалд тулгуурладаг. Сонгуулийн удирдах байгууллагууд, шүүхүүд болон сонгуулийг баталгаажуулах, үр дүнг зарлах үүрэг бүхий бусад холбогдох байгууллагууд нь улс төрийн эмзэг ярвигтай тохиолдлуудад ч шийдвэр гаргах шаардлагатай бөгөөд үүнд ялангуяа сонгуулийг хэсэгчлэн эсвэл бүрэн цуцлах асуудал багтдаг.³⁵ Гэтэл дээрх нөхцөл байдлаас үүдэлтэйгээр нэр, нөлөө бүхий нэр дэвшигч, улс төрчтэй холбоотой хэрэг зөрчил үүсгэхээс зайлсхийх, хаацайлах хандлага маргаан шийдвэрлэх байгууллагуудын албан хаагчдын дунд ажиглагддаг болохыг сонгуулийн үеийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос авсан асуулга судалгаанаас харагдаж байна.

3. Гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг хангалттай өргөн хүрээнд олгосон эсэх

Аливаа хувь хүн, хуулийн этгээд захиргааны эсхүл шүүхийн журмаар сонгуулийн хуулийн заалт, сонгуулийн үйл ажиллагааны талаарх шийдвэрт гомдол гаргаж маргаанаа хянан шийдвэрлүүлэх боломжтой байх явдал нь хамгийн шилдэг зүй ёсны сонгуулийн болон сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны практик³⁶ гэж үздэг бөгөөд тус шалгуурыг хангаж буй эсэх нь тухайн улсын сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өгөх үнэлгээний нэг чухал хэсэг болдог.

Монгол Улсын тухайд сонгуулийн байгууллагуудаас гаргасан захиргааны актын шинжтэй шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу “... иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл” гомдол гаргах эрхтэй бөгөөд зөвхөн субъектив эрх нь хөндөгдсөн этгээд гомдол,

³⁵ EUROPEAN COMMISSION FOR DEMOCRACY THROUGH LAW (VENICE COMMISSION). “REPORT ON ELECTION DISPUTE RESOLUTION”. 2020. 6 дах тал.

³⁶ Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн. “Зүй ёсны сонгууль гарын авлага”. Булс Графикс компани, Швед улс. 2010. 39 дэх тал

улмаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үүсдэг. Өөрөөр хэлбэл, одоогийн хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн байгууллагаас гаргасан захиргааны шийдвэртэй холбоотой гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн субьектив эрхийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэж болно. Цаашид сонгуулийн хороодын зарим нийтийн ашиг сонирхлыг хөндсөн шинжтэй захиргааны акт болон хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдэд объектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг нээх шаардлагатай эсэхийг нарийвчлан судлах нь зүйтэй.

Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн зөрчилтэй холбогдуулан гомдол гаргах эрхийн асуудлыг тусгайлан зохицуулаагүй боловч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн нийтлэг зохицуулалтын³⁷ хүрээнд зөрчлийн талаар мэдсэн этгээд гомдол гаргах боломжтой. Гэвч практикт сонгуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч, улс төрийн нам, нэр дэвшигч, тэдгээрийн төлөөлөгч, сонгуулийн ажилтан, хуульч зэрэг субьект ихэвчлэн гомдол гаргадаг байна.

Дээрх нийтлэг зохицуулалтаас гадна зарим тодорхой асуудлаар гомдол гаргах эрхийг тусгайлсан субьектэд олгосон тохиолдлууд бий. Тухайлбал, МУИХСтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “... сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо ... гаргана” гэж заажээ. Мөн Сонгууль ажиглах нийтлэг журмын 4.5-д зааснаар “ажиглагч нь ... хууль тогтоомж зөрчсөн шинжтэй үйлдлийн талаар бүх шатны сонгуулийн хороод болон цагдаагийн байгууллагад гомдол гаргаж болно” гэх зэргээр тодорхой субьектийн эрх, үүргийг тодруулах байдлаар заасан зохицуулалтууд цөөнгүй байна.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох журмуудаар гомдол гаргагч субьектийн талаар нарийвчлан заасан ч процесст оролцох, мэдээлэл олж авах, нотлох баримт цуглуулах зэрэг идэвхтэй процессын эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь зөрчил

³⁷ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт “хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн”

шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн үйлдэл, үйл ажиллагаанаас хэт хараат байдлыг үүсгэж байна.

4. Зөрчлийн талаар гомдол гаргах процесс тодорхой, хүртээмжтэй эсэх;

Дээрх хэсэгт дурдсан зөрчил, хууль бус үйлдлийн талаар гомдол гаргах эрхийг харьцангуй өргөн хүрээнд олгосон гэж үзэж болох хэдий ч иргэд, сонгогчийн хувиар гомдол гаргах процесс хялбар бус, харьяалал хангалттай тодорхой биш байгаа зэргээс иргэд, сонгогчид сонгуулийн үйл ажиллагааны хяналтыг үр дүнтэй бодитоор хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Түүнчлэн, иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн талаарх гомдол, маргааныг шалгаж шийдвэрлэх хугацаа ялгаатай, хууль тогтоомжийн нэгдмэл хэрэглээний асуудлууд байгааг³⁸ ч холбогдох судалгаанууд харуулж байна.

Зарим тулгамдсан асуудалд сонгогчийн хяналт, идэвх, оролцоог нэмэгдүүлэх татан оролцуулах зорилготой тодорхой арга механизмуудыг ашиглахаар оролдож буй нь сайшаалтай байна. Тухайлбал, МУИХСтХ-ийн 81 дүгээр зүйлд *81.7. Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй*” гэх зохицуулалтыг тусгасан. Гэсэн хэдий ч иргэнийг урамшуулах механизм нь нэр дэвшигчийн хүсэл зорилгоос шууд хамаарах учир бодитоор хэрэгжихэд хүндрэлтэй, тухайн мөнгө тараасан хууль бус үйлдлийг шүүхээс тогтоогдсон байх урьдчилсан шаардлага тавигддаг зэргээс хамаарч практикт хэрэгжүүлэх бодит боломж хомс юм. Харин 2011 оны Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.29 дэх хэсэгт урамшууллыг СЕХ-оос олгож гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зохицуулалттай байсан нь одоогийнхоос илүү бодит үр нөлөөтэй байж болох юм.

³⁸ Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025. 87 дахь тал

2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр мөнгө тараасныг баримтаар илчилсэн Увс аймгийн Тариалан сумын нэр бүхий иргэдэд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн (2011 оны) 35 дугаар зүйлийн 35.29-д заасны дагуу тухайн сонгогчид тараасан мөнгөн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал болох 13 сая төгрөгийг СЕХ-оос олгож байжээ.³⁹

Олон нийтийн дунд тогтсон нийтлэг ойлголт, хууль тогтоомжийн зарим тусгайлсан зохицуулалтын нөлөөгөөр сонгуулийн үеэр эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд л гомдол гаргадаг гэх өрөөсгөл ойлголтоос үүдэлтэйгээр иргэд, олон нийтийн зүгээс зөрчилтэй асуудлаар өргөдөл, гомдол гаргах замаар сонгуулийн үйл ажиллагаанд идэвхтэй, бодитой хяналт хэрэгжүүлэх сэдэл сонирхол, хууль зүйн хөшүүрэг бага, нөгөө талаар процессын эрхийг хууль тогтоомжид тодорхой тусгаагүй, гомдол гарган шийдвэрлүүлэх ажиллагаа хүндрэлтэй зэрэг зохион байгуулалтын шинжтэй нөхцөл шалтгаануудын улмаас иргэд, олон нийтийн зүгээс гомдол гарган шийдвэрлүүлэх замаар сонгуулийн үйл ажиллагаанд тавих хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байсаар байна.

5. Гомдол маргааныг хянан шийдвэрлэх хугацааны зохицуулалтууд шуурхай, үр дүнтэй байх зарчмыг хангаж байгаа эсэх;

Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд нь иргэний сонгогдох эрхийг бүрэн хангах зорилгоор тухайн гомдол, маргааныг сонгуулийн үйл явц дуусахаас өмнө шуурхай, шударга, хүртээмжтэй байдлаар хянан шийдвэрлэхээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай⁴⁰ талаар цөөнгүй эх сурвалжид дурдсан байх бөгөөд энэхүү асуудал нь сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны өмнө тулгарч буй нэн тэргүүний сорилтуудын нэг юм.

МУИХСтХ-д сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааныг сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь нэг талаар сонгуулийн

³⁹ <https://www.gec.gov.mn/blog/714>

⁴⁰ Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025. 94 дэх тал

маргаан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацааны хязгаарлалт мэт боловч нөгөө талаас сонгуулиас хойших 5-6 сарын хугацаанд багтаан маргааныг шийдвэрлэж болох мэт агуулгатай байгаа нь сонгуулийн үр дүнд нөлөө үзүүлж болзошгүй болон нэр дэвшигчийг хасах зэрэг үр дагавартай ноцтой зөрчлүүдийн хувьд хууль зүйн хязгаарлалт гэхээс илүү боломж, хийдэл болох талтай байна. Нөгөө талаар сонгуулийн хуульд заасан хугацааны ерөнхий зохицуулалт нь маргаан шийдвэрлэх процесст нэг мөр хэрэгжих дагаж мөрдөх зохицуулалт, процессын баталгаа болж чадахгүй байгаа нь кейс судалгаан дахь маргаан хянан шийдвэрлэсэн хугацааны үзүүлэлтээс харагдаж байна.

Сонгуулийн процессын онцлогтой холбоотойгоор зарим зөрчлийн хэргийн хувьд хянан шийдвэрлэх ердийн журмыг⁴¹ хэрэглэх нь төдийлөн тохиромжтой бус, үр дүн багатай байхаас гадна сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хариуцлага хүлээлгэх, зөрчлийн үр дагаврыг арилгуулах зорилтыг хангаж чадахгүйд хүргэж байна.

Тодруулбал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэр дэвшигчийг нэрсийн жагсаалтаас хасах үр дагавар бүхий гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой гомдлыг Эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр заасан байх бөгөөд тухайн зөрчлүүдийн хувьд сонгуулийн санал хураалтаас өмнө шийдвэрлэгдэж байж хууль зүйн бодит үр дагаврыг үүсгэхээр байх атал бидний судалгаагаар энэ төрлийн бүхий л гомдол зөрчил шалгах ажиллагааны шатанд буюу цагдаагийн байгууллагын ажиллагааны шатанд байсаар сонгуулийн хугацаа дуусаж байна. Энэ нь МУИХСтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэгт заасан нэр дэвшигчийг хасах зургаан үндэслэлд хамаарах гэмт хэрэг, зөрчлийн гурав нь нэр дэвшигчийн үнэмлэх авснаас хойших үйлдэлд хамаарах (дунджаар 25 хоног), хоёр нь сонгуулийн сурталчилгааны хугацааны үйлдэлд хамаарах (дунджаар 14 хоног) нэг нь сонгуулийн жил эхэлснээс хойших хугацаанд хамаарахаар

⁴¹ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тооцсон зөрчил шалган шийдвэрлэх ерөнхий хугацаа: Гомдол шалгах (5 хоног) + Хэрэг бүртгэлт үндсэн хугацаа (14 хоног) + Удирдах албан тушаалтан (14 хоног) + Прокурор (30 хоног) = 65 хоног

байх буюу тухайн үйлдэл, үйл ажиллагаа нь зөрчилд тооцогдох цаг хугацаа богино байхаас гадна тухайн зөрчил, гэмт хэргийг цагдаагийн байгууллага ердийн журмаар шалган тогтоож шүүхээр шийдвэрлэхээр⁴² байгаа нь бодит нөхцөлд нэр дэвшигчийг хасах зөрчил, гэмт хэрэг санал хураалтаас өмнө тогтоогдох боломж маш хязгаарлагдмал буюу боломжгүй гэж дүгнэж ч болохоор байна.

Сонгуулийн маргаануудаас захиргааны шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны хувьд тусгай журам тогтоож⁴³, шүүх ч маргааныг шуурхай шийдвэрлэхийг зорьж буй нь маргаан шийдвэрлэх ажиллагаа дахь сайн туршлага дэвшлүүдийн нэг мөн. Гэсэн хэдий ч сонгуулийн сурталчилгааны богино хугацаатай нийцэхгүй, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бүрэн хангаж чадахгүй байна⁴⁴ гэх дүгнэлтийг Хүний эрхийн үндэсний комисс хийжээ. Мөн судлаач Д.Энхцэцэг 2024 оны УИХ-ын сонгуулиар Захиргааны хэргийн шүүхэд хандсан зарим нэр дэвшигчид үнэмлэхээ сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа дуусах дөхсөн үед авсан бөгөөд эдгээр нэр дэвшигчдийн хувьд сурталчилгаа явуулах боломж үндсэндээ байсангүй⁴⁵ гэх ижил агуулга бүхий дүгнэлтийг хийсэн байв.

⁴² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлүүд буюу нэр дэвшигчээс хасах зөрчлүүдийг тусгай журмын дагуу цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж эрүүгийн хэргийн шүүх шийдвэрлэхээр заасан.

⁴³ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112.1.Дараах төрлийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ:
112.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргаан;
112.2.Энэ хуулийн 112.1.3-т заасан маргааныг шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно.
112.7.Энэ хуулийн 112.1.3, 112.4.1, 112.4.2-т заасан маргааны нэхэмжлэлийг хариуцагч гардан авснаас хойш долоо хоногийн дотор хариу тайлбар болон нотлох баримтаа шүүхэд ирүүлнэ.

⁴⁴ Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025 он. 94 дэх тал

⁴⁵ Д.Энхцэцэг. “Ерөнхий тойм. Чөлөөт шударга сонгуулийн зарчмуудыг хөндсөн зарим асуудал”. Улаанбаатар. 2024 он. 8 дахь тал

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үеэр сонгуультай холбоотой үүссэн гурван ч захиргааны хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатаар сонгуулийн санал авах өдрийн өмнөх өдөр буюу 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн шийдвэрлэжээ. Шүүхийн эцсийн шийдвэрээр Л.Н, Д.А, Н.Б нарыг нэр дэвшигчээр бүртгэж, нэр дэвшигчийн үнэмлэх олгохыг хариуцагч СЕХ-нд тус тус даалгаж шийдвэрлэсэн. Гэвч сонгуулийн санал авах өдрийн өмнөх өдөр гарсан тэрхүү шийдвэр нь бичгээр албажиж гараагүй тул СЕХ-оос биелүүлэх боломжгүй тухай хариу өгсөн тухай зарим нэхэмжлэгч, тэдний өмгөөлөгчид мэдэгдсэн ба улмаар шүүхийн шийдвэр хэрэгжилгүйгээр сонгууль болж өнгөрсөн байна.⁴⁶

Эдгээрээс үзэхэд захиргааны хэргийн шүүхийн маргаан шийдвэрлэх зохицуулалтын тухайд ахиц дэвшил байгаа хэдий ч сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацааг сонгуулийн цагалбартай уялдуулан сонгох, сонгогдох эрхийг хангахуйц байдлаар зохицуулах,⁴⁷ шаардлагатай тохиолдолд шүүхийн зохион байгуулалт, хүний нөөцийн зохицуулалтын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх боломжтой.

Шүүхийн тухай хуульд оруулсан 2024 оны 6 сарын 5-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийн дагуу шүүхүүд шүүх таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах хууль зүйн боломж нээгдсэн боловч шүүхээр шийдвэрлэж буй сонгуулийн хэрэг маргааны тоон мэдээллээс үзэхэд хараахан дагнасан шүүх, танхим байгуулах хангалттай үндэслэл нөхцөл бүрдээгүй гэж үзэж болох юм. Гэвч сонгуулийн хэрэг маргааны онцлог, шуурхай хянан шийдвэрлэх зүй ёсны шаардлага зэргээс хамааруулан авч үзвэл дээр дурдсанчлан шүүхийн зарим тодорхой зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага байгааг үгүйсгэх аргагүй байна. Тухайлбал, энд тухайн салбараар мэргэшсэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан бэлдэх, мэргэшсэн шүүгчдийг тодорхой хугацаагаар тусгайлан ажиллуулах зэрэг зохицуулалтын арга хэмжээ байх боломжтой

⁴⁶ Д.Энхцэцэг, “Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт болон бусад анхаарал татсан асуудал”. 2020 он

⁴⁷ Д.Энхцэцэг. “Ерөнхий тойм. Чөлөөт шударга сонгуулийн зарчмуудыг хөндсөн зарим асуудал”. Улаанбаатар. 2024 он. 8 дахь тал

боловч Шүүхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын тус хэлбэрийг хуульчлан зөвшөөрөөгүй байна.

Хүснэгт 1: Маргаан шийдвэрлэх ерөнхий хугацаа

Маргааны төрөл	Хянан шийдвэрлэх байгууллага	Хугацаа	Хуулийн үндэслэл
Нэрийн жагсаалттай холбоотой гомдол	УБЕГ	30 хоног	Сонгуулийн хуульд тодорхой тусгаагүй бөгөөд Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтан гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх хуулийн дагуу шийдвэрлэж байна ⁴⁸
Сонгуулийн зохион байгуулалттай холбоотой гомдол	Дээд шатны сонгуулийн хороо	3 хоног	МУИХСтХ-ийн 19.21
Сонгуулийн хороодын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой шүүхэд гаргасан нэхэмжлэл	Захиргааны хэргийн шүүх	30 хоног + 10 хоног	ЗХШХШтХ-ийн 112.2
Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаар эрх бүхий этгээдэд гаргасан гомдол	Эрх бүхий этгээд, эрүүгийн хэргийн шүүх	14-65+ хоног	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл	Эрүүгийн хэргийн шүүх	60 < хоног	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу

⁴⁸ Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 08 дугаар сарын 1-ний өдрийн 1/9358 дугаартай албан бичигт дурдагдсан.

6. Гомдол, маргааныг ил тод, шударгаар шийдвэрлэх тогтолцоо, хууль зүйн нөхцөл хангагдсан эсэх

Сонгуулийн өргөдөл гомдол хүлээж авсан байгууллагууд гомдол, маргааныг хүлээж авахаас татгалзсан үндэслэл, шийдвэрлэлтээ гомдол гаргагч болон олон нийтэд мэдээлэх хэрэгцээтэй байна.⁴⁹ Гомдол маргааныг хараат бусаар, шударгаар шийдвэрлэх үндсэн урьдчилсан нөхцөлүүдийн нэг нь маргаан шийдвэрлэх ил тод байдал, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх явдал бөгөөд энэ нь гомдол маргааныг хянан шийдвэрлэж буй эрх бүхий этгээдийн шийдвэр, үйл ажиллагааны хараат бус байдалд ч эергээр нөлөөлөх боломжтой юм.

Энэхүү зарчмын хүрээнд 2024 оны УИХ-ын сонгуулийн үеэр Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан зөвлөмждөө сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах буюу санал гаргахаас бусад сонгуулийн үйл явц ил тод байх нь олон нийтийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх, үл ойлголцол, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх талаар тусгайлан заасан нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой байв.

Харин сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж буй хууль тогтоомжид маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг⁵⁰ хангах зарчим, агуулга хангалттай тодорхой тусгагдаагүй, ил тод байдлын хэрэгжилт ч хангалтгүй байгаа нь маргаан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал хангагдаагүй гэж дүгнэх үндэслэл болж байна.

⁴⁹ Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025. 92 дахь тал

⁵⁰ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад олж мэдсэн хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авна” гэсэн заалтын хүрээнд хязгаарлагдана.

7. Эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрт гомдол гаргах, давж заалдах эрх, боломжит хугацаа олгогдсон эсэх

Сонгуулийн үйл ажиллагааны цаг хугацааны хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор маргааныг хурдан хугацаанд үр дүнтэй шуурхай шийдвэрлэх боломжийг дэлхий нийтэд цаг ямагт эрэлхийлж ирсэн байдаг. Гэвч энэхүү оролдлого нь шүүхэд хандах, давж заалдах эрхийг хязгаарлах замаар хэрэгжих ёсгүйг үндэсний болон олон улсын суурь шинжтэй хууль зүйн баримт бичгүүдийн хүрээнд баталгаажуулжээ.

Монгол Улсын хувьд МУИХСтХ-д 2007 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд зарим төрлийн сонгуулийн маргааныг сонгуулийн байгууллага “эцэслэн” шийдвэрлэх агуулга бүхий зохицуулалтыг тусгасан тохиолдолд гарч байсан бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 01 дүгээр тогтоолоор ” ...сонгуулийн байгууллага ”эцэслэн” шийдвэрлэж байхаар заасан нь тухайн асуудлаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх сонгогч, сонгогдогчийн эрхийг зөрчихөд хүргэж байна” гэж дүгнэн хүчингүй болгож байв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2011.01.05-ны өдрийн 01-р тогтоолоор “2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.” гэсэн заалтын “...эцэслэн...” гэсэн нь шүүхэд хандах үндсэн эрхийг хязгаарласан байна.” гэж үзсэн. Ийнхүү сонгуулийн маргааныг ямар нэгэн шалтгаанаар шүүхээс гадуур эцэслэн шийдвэрлэх агуулга, зохицуулалтыг Үндсэн хуулийн хэмжээнд хүлээн зөвшөөрөөгүй болохыг баталгаажуулсан байна.

Үүнээс хойших сонгуулийн маргаан шийдвэрлэх хууль тогтоомжид шүүхэд хандах эрхийг шууд хязгаарласан агуулга зохицуулалт тусгагдаагүй боловч гомдол гаргах эрхийг тодорхой хэмжээнд хумих агуулга бүхий зохицуулалтууд байсаар байна. Тухайлбал, эрүүгийн хэргийн шүүх зөрчил шалган шийдвэрлэх

хуулийн дагуу сонгуулийн зөрчлийг давж заалдах шатанд эцэслэн шийдвэрлэж байна. Мөн МУИХСтХ-ийн 81 дүгээр зүйлийн 81.5 дахь хэсэгт “Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй” гэж тусгасан нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны онцлогтой холбоотой⁵¹ нөгөө талаас процессын үр нөлөөг нэмэгдүүлэх, хугацааг богиносгох зорилгыг агуулж байж болох боловч гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг богиносгох буюу гомдол гаргагчийн процессын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хэрэгжүүлэх нь оновчтой зохицуулалт болж чадахгүй гэж үзэж байна.

8. Маргаан хянан шийдвэрлэх процессын хууль тогтоомжийн зохицуулалтууд нь тодорхой эсэх

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Сонгуулийн хуулийн зохицуулалтыг хэрэглэх эсэх асуудал одоо ч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. МУИХСтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт “Зөрчил болон гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчид холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх дараах ажиллагаа явуулахыг хориглоно” гээд 35.2.1-д “эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, саатуулах, албадан саатуулах, цагдан хорих” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020.11.23-ны өдрийн 11-р дүгнэлтээр « «МУИХСтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтад "... баривчлах, ... цагдан хорих;» гэсэн нь Үндсэн хуулийг зөрчөөгүй» гэж дүгнэсэн. Ингэхдээ цэц дүгнэлтийн үндэслэх хэсэгт «... нарийвчлан зохицуулсан төрөлжсөн хуультай уялдуулах, холбогдох журмыг тусгайлан тогтоох, хууль зөрчсөн тохиолдолд гарах үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулах» шаардлагатай болохыг тусгайлан дурджээ. Гэвч холбогдох хуулиудад энэ талаарх нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

⁵¹ Д.Бат-Эрдэнэ, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал, 2022, Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/1493>

Гэвч 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үеэр нэр дэвшигчдийг цагдан хорьсон тохиолдол гарсан бөгөөд тус асуудлаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр тайлбар мэдэгдэлдээ “... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болох тохиолдол”-уудыг хуульчлан заасан. Хуульд зааснаар эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан, хэрэг нь шүүхэд шилжсэн шүүгдэгч УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн, эсхүл УИХ-ын гишүүн байхаас үл хамаарч бусдаас давуу эрх эдлэх тухай огт тусгагдаагүй байна” гэж дурджээ.

Дээрхээс дүгнэхэд сонгуулийн үеийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг дан материаллаг хуульд тусгаад орхих нь процессын баталгааг хангаж чадахгүй нөхцөлийг үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

9. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үр нөлөөтэй байх зарчим хангагдсан эсэх

Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаа, гарсан шийдвэр нь үр дүнтэй байхын тулд нэгдүгээрт, шийтгэл, хууль зүйн хариуцлага, үр дагавар нь гэм буруу, зөрчил, хууль бус шийдвэр, үйлдлийн шинж байдалд тохирсон буюу үр нөлөөтэй байх, хоёрдугаарт, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчил, хууль бус үйлдлийн үр дагаврыг арилгах, залруулах хууль зүйн боломжийг бүрдүүлсэн байх ерөнхий шаардлагууд тавигдана.

Эхний шаардлагын хүрээнд иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг сэргээх, гэм хорыг арилгуулах, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай⁵² бөгөөд шийтгэлийн төрөл хэмжээ нь сонгуулийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагаа, зан үйлд нөлөө үзүүлэх боломжтой байхаас гадна бодит нөхцөлд тохирсон байх нь чухал.

⁵² Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025 он. 96 дахь тал

Иргэний сонгогдох эрх зөрчигдсөнийг шүүхийн шийдвэрээр тогтоосон тохиолдолд, уг зөрчлийг төр эсвэл эрх бүхий албан тушаалтан арилгах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй⁵³ мөн нам, нэр дэвшигчдийн гаргаж буй зөрчлүүдтэй холбоотой гомдлыг сонгуулийн хугацаанд шийдвэрлэлгүй орхигдуулах, хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зэрэг⁵⁴ зориуд шинжтэй эс үйлдэхүй гаргах тохиолдлууд үүсэж буй талаар санал шүүмжлэлүүд бий. Эдгээр нь байгууллага, албан хаагчийн үйлдэл, үйл ажиллагаанаас гадна гомдол маргаан, хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөц, ажлын ачаалал буюу тогтолцоо, зохион байгуулалт, хууль эрх зүйн орчин нөхцөлөөс хамаарч байна.

Хамгийн тодорхой нэг жишээ гэвэл Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын дүн гарсны дараа зөрчигдсөн эрхийг сэргээх шийдвэр гарсан тохиолдолд хэрхэх талаар хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй. Тухайлбал, Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлд нэр дэвшигчийг тодорхой зөрчлүүдийн улмаас хасах зохицуулалт тусгагдсан хэдий ч сонгууль явагдаж дууссаны дараа буюу УИХ-ын гишүүнээр сонгогдсон тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэх* эгүүлэн татах хууль зүйн боломжгүй байгаа нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үр нөлөөг бууруулж байна.

*2024 онд шинэчлэн батлагдсан Монгол улсын Их хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д «Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, баривчлах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар **Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах**, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.» гэж заасны улмаас сонгуулийн үед гаргасан зөрчилд нь холбогдуулан Эрүүгийн хэргийн шүүхээс зөрчлийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болсон байна.

⁵³ Хүний эрхийн үндэсний комисс. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл”. Улаанбаатар. 2025 он. 94 дэх тал

⁵⁴ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлд дурдсанаар УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс Цагдаагийн байгууллагад гаргасан 1263 ширхэг гомдлоос 88 ширхгийн буюу 7 орчим хувийг нь шийдвэрлэжээ.

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн 2018.11.14-ний 14-р дүгнэлтээр «2015 оны Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт "Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно." гэж заасан нь МУҮХ-ийн 14.1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэснийг зөрчсөн байна» гэж үзсэн. Тодруулбал, Сонгуулийн дүнд байгуулагддаг Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд нь хүлээлгэх хариуцлагыг илтэд ялгавартайгаар, тухайлбал Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшин сонгогдож тангараг өргөн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Улсын Их Хурлын гишүүнд хүлээлгэх энэ төрлийн хариуцлагыг хуульчлаагүй нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан гэж үзсэн. Энэхүү зохицуулалтын агуулга 2019 онд батлагдсан АНСДИТХСтХ-д «шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол» гэх агуулгаар дахин тусгагдсан. Гэвч МУИХСтХ-д мөн л тухайн агуулга бүхий зохицуулалтыг тусгалгүй орхисон байна.

2.3.1. Зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал ба эрх бүхий байгууллагуудын бүрэн эрх, чиг үүргийн шинжилгээ

Сонгуулийн үйл ажиллагааг шударгаар хууль ёсны дагуу явуулах иргэний сонгох, сонгогдох эрхийн баталгааг хангах хууль зүйн үндсэн арга механизм нь сонгуулийн хууль тогтоомжууд, түүний хэрэгжилтийг хангах явдал бөгөөд хууль бус үйлдэл, үйл ажиллагаа бүрийг таслан зогсоох, шударга, үр нөлөөтэй хариуцлага ногдуулахыг эрмэлзэх нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх тогтолцооны нэн тэргүүний зорилтуудын нэг мөн. Монгол Улсын хувьд сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль бус үйлдэл, үйл ажиллагаатай тэмцэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх гол механизм нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэгч эрх бүхий этгээд байна. Тиймээс энд зарим төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал, чиг үүргийн уялдаа холбоо муу байгаа нь зөрчлийг шуурхай, бүрэн илрүүлэх, үр нөлөөтэй хариуцлага хүлээлгэхэд сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулахыг зорив.

Тус шинжилгээнээс⁵⁵ харахад зарим зөрчлүүдийн харьяалал нь тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг үйл ажиллагаатай холбоогүй байх, зөрчлийг өөрийн үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд шалган тогтоох боломж хязгаарлагдмал байх, хяналт тавих болон хянан шалгах байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг бүрэн хангаагүй зэргээс зөрчлийг шуурхай, бүрэн илрүүлэх, үр нөлөөтэй хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломж нөхцөл хязгаарлагдаж байна.

Тухайлбал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1-д “хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг илрүүлсэн” тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах үндэслэл болох бөгөөд дээрх сонгуулийн зөрчлүүдийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд илрүүлэх хууль зүйн болон бодит боломжгүй байгаа нь сонгуулийн зөрчлүүдийг бүрэн илрүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэв. Нөгөө талаар нэгэнт зөрчил шалгах шийдвэрлэх байгууллагын зүгээс хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх, илрүүлэх хууль зүйн боломж бага байгаа нөхцөлд иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих, өргөдөл гомдол өргөн хүрээнд гаргах хууль зүйн болон техникийн нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.

2.3.2. Шинжилгээний дүгнэлт болон үүссэн асуудлууд

Дээрх хэсэгт хийсэн маргаан шийдвэрлэх хууль тогтоомж болон тогтолцооны шинжилгээнээс дараах гол дүгнэлтүүд гарч байна. Үүнд,

Эрх зүйн суурь зарчмын нийцэл

Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын баримт бичгүүдэд туссан сонгуулийн эрхийн үндсэн зарчим (шууд, чөлөөт, нууц санал өгөх, шударгаар шийдвэрлүүлэх, хяналт тавих эрх гэх мэт) дотоодын хууль тогтоомжид харьцангуй тодорхой тусгагдсан байна. Гэвч хэрэгжилтийн түвшинд эдгээр зарчим тогтвортой бүрэн хангагдахгүй, зөрчил үүсэх тохиолдол элбэг байна.

⁵⁵ Шинжилгээний дэлгэрэнгүйг Хавсралт №5-аас харна уу.

Зөрчил, маргааныг шийдвэрлэх харьяалал, хил зааг харьцангуй тодорхой боловч бүрэн ойлгомжгүй

2015 оноос эхлэн СЕХ-ны шийдвэртэй холбоотой Захиргааны хэргийн шүүх ба Үндсэн хуулийн цэцийн харьяаллын асуудлыг хууль зүйн хувьд шийдвэрлэсэн нь захиргааны хэрэг маргааны хувьд дэвшил болжээ. Харин сонгуулийн үеийн хууль бус үйлдэл, зөрчилтэй холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх харьяаллын талаар олон нийтийн ойлголт сул, олон хууль тогтоомжийн уялдаа холбоо муу, хууль тогтоомж тогтвортой бус, процесс нарийн төвөгтэй байгаагаас иргэдийн хувьд гомдол гаргахаас төвөгшөөх, төөрөгдөлд орох, буруу харьяаллаар гомдол гаргаж цаг хугацаа алдах зэрэг асуудлууд эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэргүүдэд түгээмэл байсаар байна.

Хараат бус байдал сул

Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-ны бүтэц, томилгооны процесс олон улсын жишгийн дагуу хараат бус байдлыг хангах зохицуулалттай боловч бодит байдал дээр улс төрийн нөлөөлөл, томилгооны улс төржилтөөс бүрэн ангид байж чаддаггүй. Мөн зөрчил шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын дийлэнх нь Засгийн газрын харьяа агентлаг, удирдлага нь улс төрийн албан тушаалтнаас томилогддог тул хараат бус, бие даасан байдлын баталгаа сул байгаагаас зарим төрлийн гомдлыг шалгах шийдвэрлэхээс зайлсхийх, хаацайлах хандлага ажиглагдаж байна.

Маргаан шийдвэрлэх ажиллагааны оролцооны эрх хангалттай өргөн хүрээтэй биш

Одоогийн зохицуулалтаар захиргааны хэрэгт гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн эрх нь шууд зөрчигдсөн этгээдээр хязгаарлаж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах өргөн хүрээтэй хяналтын боломж олгогдоогүй. Мөн иргэдийн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах, хяналт тавих идэвх сул, процессын эрх хангалтгүй (нотлох баримт цуглуулах, мэдээлэл авах боломж хязгаарлагдмал) тул сонгуулийн үйл ажиллагаа дахь иргэд, олон нийтийн хяналт үр дүн муутай байна.

Шуурхай шийдвэрлэх зорилт хангагдахгүй байна

Сонгуулийн зохион байгуулалтын онцлогоос шалтгаалан гомдол, маргааныг богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байдаг. Энэхүү зарчмыг сүүлийн жилүүдэд Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаа, маргаан шийдвэрлэх хууль тогтоомждоо нэвтрүүлснээр бодит үр дүн гарч байгаа хэдий ч сонгуулийн эрхийг хэлбэрийн төдий сэргээсэн, маргаан удаан хугацаанд сунжирсан талаарх шүүмжлэлүүд тасрахгүй байна. Харин сонгуулийн үеийн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа сунжрах, хууль зүйн үр дагавраа алдах улмаар шийдвэрлэлгүй орхигдох, хэрэгсэхгүй болох тохиолдол элбэг байна. Ялангуяа нэр дэвшигчийг хасах үр дагавар бүхий зөрчлийг одоогийн процессоор сонгуулийн зохион байгуулалтын үндсэн хугацаанд нь шийдвэрлэх бодит боломж бараг үгүй байгаа нь зөрчлийн үр дагаврыг арилгах, хариуцлагын үр нөлөөг нэмэгдүүлэх саад учруулж байна.

УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээс хасах үр дагавар бүхий зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа бодит үр нөлөөгүй байгаа нь дараах шалтгаантай байна:

- Зөрчил шалган шийдвэрлэх ердийн хугацаа журам үйлчилдэг
- Тусгай журмаар буюу цагдаагийн эрх бүхий албан хаагч хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж (*зарим зөрчлүүдийн хувьд Төрийн аудитын байгууллага, ХХЗХ зэрэг чиг үүргийн байгууллагууд шалган тогтоож цагдаагийн байгууллагад шилжүүлэх*) эрүүгийн хэргийн шүүх шийтгэл ногдуулах эсэхийг шийдвэрлэхээр байгаа нь процессын удаашралд хүргэдэг.
- Цагдаагийн байгууллага, төрийн эрх бүхий бусад байгууллага тухайн төрлийн зөрчлүүдтэй холбоотой ажиллагаа явуулах, хэрэг бүртгэл нээх, шилжүүлэхээс болгоомжлох, зайлсхийх хандлага давамгайлдаг. Мөн шийтгэлийг шүүх ногдуулах боловч хэргийг хэрэг бүртгэлийн шатанд хэрэгсэхгүй болгох эрх цагдаагийн байгууллагад олгогдсон нь хэргийг шүүх хянах, хараат бусаар шийдвэрлэх хууль зүйн нөхцөлийг хангахгүй байна.⁵⁶

⁵⁶ Практик судалгааны хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

- Нэгэнт сонгогдсон гишүүнийг тухайн зөрчилд хариуцлага хүлээлгэх, эгүүлэн татах хууль зүйн боломжгүй.

Сонгуулийн харилцаа, сонгуулийн маргаанд оролцогч байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн уялдаа хангалтгүй байна

Монгол Улс зөрчил, гомдол маргааныг хянан шийдвэрлэх үндсэн тогтолцоог бүхэлд нь хамарсан сонгуулийн маргаан шийдвэрлэх томоохон бүтэц зохион байгуулалтыг бий болгосон. Тодруулбал, сонгуулийн үйл ажиллагааны үндсэн оролцогч болох СЕХ, УБЕГ, Захиргааны хэргийн шүүх зэргээс гадна сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах гол чиг үүргийг зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдүүд хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор салбар бүрийн хяналт, шалгалтын субъектуудыг хамарсан өргөн хүрээтэй механизм үүссэн.

Энэхүү тогтолцоо нь маргаан шийдвэрлэх нөөцийн хуваарилалт, хүртээмж, чиг үүргийн зохион байгуулалт, харьцангуй бие даасан бүтэц зэрэг давуу талыг бий болгосон хэдий ч олон салбар, байгууллага, үйл ажиллагааны дүрэм журам дамнасан зохион байгуулалт, процессын нарийвчилсан тохируулга, тусгайлсан зохицуулалт хийгээгүйн улмаас маргаан шийдвэрлэх ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдал, зөрчлийн илрүүлэлт, шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнд шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байна.

Хүний эрх чөлөөг хязгаарлах зохицуулалтыг хуулиас гадуур тогтоосон

Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах, цахим орчин ашиглан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлэх шуурхай таслан зогсоох зорилгоор СЕХ-оос цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад хяналт тавихтай холбоотой хэдэн хэдэн журам баталж 2024 оны сонгуулиар мөрдүүлж ажилласан байна. Эдгээр журамд цахим орчинд хяналт тавих цахим хуудсыг хаах, хязгаарлах асуудлуудыг тусгахдаа хуульд заасан хүрээ хязгаараас хэтрүүлэн **шийдвэрт дурдсан контентыг устгах, цагдаа, тагнуулын байгууллагаас гадна ШӨХТГ-аас тус шийдвэрийг гаргаж болох** зэрэг

зохицуулалт туссан нь Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон хэм хэмжээний актад тавигдах шаардлагад нийцэхгүй байна. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй асуудлыг тодорхойлсон. Үүнд, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах,⁵⁷ Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа⁵⁸ хамаарахаар заасан бөгөөд дээрх журмуудын хүрээнд зохицуулагдсан харилцаа нь хүний үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, хэвлэн нийтлэх эрхүүдийг хөндөх магадлалтай тул журмаар зохицуулах нь хуулийн зөрчил үүсгэхээр байна.

Нөгөөтээгүүр СЕХ-ны тус журмуудад маргаан шийдвэрлэх процессын шинжтэй зохицуулалтууд тусгагдсан нь Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу явуулах зарчимтай зөрчилдөж байна. Иймд уг төрлийн зөрчлийг харьяалан шийдвэрлэх журам, хугацааг сонгуулийн бусад зөрчил шийдвэрлэх хугацаа, процессын хамт цогцоор нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны үе шат, хугацаатай уялдуулан авч үзэх шаардлага үүсэж байна.

Олон улсын жишиг, зөвлөмжийн нийцэл дутмаг байна

ЕАБХАБ, Венецийн комиссын санал болгосон үр нөлөөтэй, богино хугацаанд шийдвэрлэх, ил тод, хүртээмжтэй, хэлбэрийн бус процессын шаардлагууд Монголын хууль тогтоомж, практикт бүрэн тусгагдаагүй. Илүү хялбаршуулсан журам, иргэдэд зориулсан ойлгомжтой энгийн тодорхой арга хэлбэрүүд, цахим системийн хэрэглээ зэрэг механизмууд дутмаг байна.

⁵⁷ Хууль тогтоомжийн тухай хуулийн 271.2.1

⁵⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 271.2.2

2.4. Маргаан шийдвэрлэх ажиллагаа дахь олон нийтийн оролцоо ба ил тод байдал

Өмнөх бүлгүүдэд судлагдсан, дурдагдсан нөхцөл байдлуудаас сонгуулийн маргааныг үр дүнтэй, шуурхай, шударгаар шийдвэрлэхэд олон тооны хууль зүйн зохицуулалт, маргаан шийдвэрлэх том бүтэц орон тооноос илүүтэй оновчтой, иргэдэд ойр, энгийн ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод механизмыг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Иймээс энэ хэсэгт маргаан шийдвэрлэх ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангаж буй эсэхэд дүгнэлт өгөхийг зорилоо.

Сонгуулийн хуулиудад зааснаар иргэн сонгуультай холбоотойгоор мэдээлэл, өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргаж болохоор хуульчилсан бөгөөд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг ямар үндэслэлээр, хэнд хандан гаргаж байгаагаас хамааран хууль, журамд ялгаатай зохицуулалт тусгагдсаныг Хавсралт №2-т түүвэрлэн авч үзсэн.

Түүврээс үзвэл өргөдөл, гомдол, мэдээлэл, нэхэмжлэл гаргах боломжийг нээсэн хэдий ч тэдгээрийн шийдвэрлэлтийн явц, ил тод байдалтай холбоотой тухайлсан зохицуулалт тусгаагүй байна. Сонгуулийн хуулиудад зааснаар Сонгуулийн хороод, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссын хувьд гомдол гаргагчид хариуг бичгээр өгөх дараах зохицуулалт тусгагдсан. Тодруулбал,

- Өргөдөл, гомдлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх,
- Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх;
- Өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;
- Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт: зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш гурван хоногийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг бичгээр мэдэгдэнэ.

Дээрхээс гадна Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журамд⁵⁹ “Цахим орчны цахим үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргааныг **хэрхэн шийдвэрлэсэн талаарх** тайланг сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргаж, олон нийтэд нээлтэй мэдээлнэ.” гэжээ. Харин бусад байгууллага, албан тушаалтны хувьд гомдлыг зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын дагуу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон өөрийн үйл ажиллагаа, процессыг тухайлан зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан хуульд тухайлан хугацаа заасан бол тухайн хугацаанд, ийнхүү хугацаа заагаагүй бол тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэхээр⁶⁰ заажээ. Гэхдээ ийнхүү гомдол, маргааныг шийдвэрлэхдээ хэрхэн шийдвэрлэснийг тайлагнах, мэдээлэх үүргийг хүлээлгээгүй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны холбогдох журмуудад өргөдөл, гомдлыг хаана, хэнд гаргах, гомдол маргааныг хэн шийдвэрлэх талаар дурдсан бөгөөд захиргааны шүүх, үндсэн хуулийн цэцэд хандан шийдвэрлүүлэхээс бусад гомдол, маргааныг зөрчил шалган шийдвэрлэх харьяалал, процессын дагуу шийдвэрлэж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д Сонгуулийн тухай хуулийг зөрчсөн зарим зөрчилд тусгай журам баримтлан хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахаар заасан боловч энэ нь шийтгэл ногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэхээр хуульд заасан зарим зөрчилд холбогдох тусгайлсан процессыг зохицуулснаас бус сонгуулийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн зохицуулалтууд, тэр тусмаа гомдол, маргааныг шийдвэрлэх үйл явц дахь иргэдийн оролцоо, мэдээллээр хангагдах, ил тод байдлыг хангахтай холбоотой тухайлсан зохицуулалт агуулаагүй байна. Тэрчлэн зөвхөн сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан журмуудад хяналт тавих, өргөдөл гомдол хүлээн авч, шийдвэрлэх этгээдийг нэрлэн заасан бөгөөд тэдгээрийн

⁵⁹ Сонгуулийн ерөнхий хороо, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам, 2024.09.09, 201, 7.4 дэх хэсэг.

⁶⁰ МУЕСтХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1, МУИХСтХ, АНСДИТХСтХ-ийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэг

олон нийт болон хяналт тавих эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах үүргийг журамласан нь хэлбэрийн төдий шинжтэй, үндсэн зорилгодоо нийцэхгүй байна.

Мөн 2024 оны сонгуулийн дараа зарим төрийн бус байгууллага “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам”-ын дагуу сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаарх өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй танилцах, хянах хүсэлт гаргахад цагдаагийн байгууллагаас мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол гарсан талаар зарим судалгаанд⁶¹ дурдагдсан нь бодит нөхцөлийг тодорхой харуулжээ.

2.5. Практик судалгаа: 2020, 2021, 2024 оны сонгуультай холбоотой зөрчил, маргаан, түүнийг хянан шийдвэрлэсэн үйл ажиллагааны мэдээлэл шинжилгээ

Судалгааны хүрээнд сонгуулийн маргаан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагуудаас тухайн байгууллагад УИХ болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020, 2024 оны сонгууль, Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн үеэр ирүүлсэн гомдол, үүссэн маргааны төрөл, тоо, шийдвэрлэлтийн мэдээллийг гаргуулан авсан⁶² бөгөөд тус статистик мэдээллүүд болон бусад судалгааны эх сурвалжид дурдагдсан мэдээллүүдийг энэхүү хэсэгт нэгтгэн шинжилгээ хийлээ.

⁶¹ Д.Энхцэцэг. “Ерөнхий тойм. Чөлөөт шударга сонгуулийн зарчмуудыг хөндсөн зарим асуудал”. Улаанбаатар. 2024 он. 18 дахь тал

⁶² Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдүүдээс судалгааны ажлын хүрээнд мэдээлэл ирүүлсэн бөгөөд Эрүүгийн шүүхийн хувьд Нийслэлийн төвийн бүсийн 6 дүүргийн шүүхээс мэдээлэл авсан болно.

1. Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)⁶³ (Сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой маргаан)

Хүснэгт 2: Улсын бүртгэлийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэл

	Өргөдөл гомдлын төрөл	2020	2021	2024	Тайлбар, дүгнэлт
1	Сонгогчдоос ирсэн гомдол (нэрийн жагсаалт, хаяг, овог нэр зөрүү гэх мэт)	9,100			Нийт хаягийн зөрүүтэй холбоотой 9,100 гомдол байгаа ба үүний 80 хувь нь “тухайн хаягт оршин суугчдын тоо зөрүүтэй” гэх агуулгатай байгаа нь сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагааны томоохон сорилт нь хаягийн нарийвчилсан бүртгэл болохыг харуулж байна.
2	Нэг хаягт олон иргэн бүртгэгдсэн тухай гомдол	-	-	-	Одоогоор цахим мэдээллийн санд 3,226 хаягт 42,082 иргэн буюу дунджаар нэг хаягт 10-аас дээш иргэн бүртгэгдсэн байгаа нь гомдол маргаан гарах суурь шалтгаан болж байгаагаас гадна сонгуулийн үйл ажиллагааны зохион байгуулалтын томоохон эрсдэл гэж үзэхээр байна.
3	Гадаадад 60+ хоног зорчсоноор “түр хасав” тэмдэглэгээ тавигдсантай холбоотой гомдол	1,891			2020 оны орон нутаг, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 1,891 иргэнд “түр хасав” тэмдэглэгээ тавьснаас 1844 иргэний “түр хасав” тэмдэглэгээ сэргэсэн бол 2024 онд 3,071 иргэний “түр хасав” тэмдэглэгээ сэргээсэн байна.
4	Бусад гомдол (нам, эвсэл, иргэдийн хүсэлт)	5 иргэн 1 нам	-	10 иргэн (СЕХ)	ИТБАТГӨГШТХ-ийн дагуу хариу өгсөн. СЕХ-оос 10 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн мэдээллийг шалгуулсан.

⁶³ Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 1/9358 дугаартай албан бичигт тулгуурлан бэлтгэв.

Дүн шинжилгээ:

УБЕГ-ын иргэний бүртгэлийн асуудал нь сонгууль бүрийн томоохон маргааны нэг байсаар ирсэн. Суурь шалтгаан нь хаягийн бүртгэлийн тогтолцоо, шилжилт хөдөлгөөний үйл ажиллагааны дутагдал, мөн иргэний бүртгэлийн болон хүн ам өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн зөрүүтэй байдал зэргээс хамаардаг бөгөөд 2024 оны сонгуулийн үеэр гадаадад зорчсон иргэдийн “түр хасав” тэмдэглэгээнээс үүдэлтэй маргаан ихээхэн анхаарал татсан билээ. Иргэний бүртгэлийн зөрчил нь иргэний сонгох эрх, сонгуулийн үйл ажиллагааны шударга байдал, сонгуулийн үр дүнд шууд нөлөө үзүүлдэг учир бүртгэлийн үйл ажиллагаа болон гомдол хүсэлтийг шийдвэрлэх тогтолцоо шуурхай, ил тод, боловсронгуй байх зайлшгүй шаардлагатай.

Зарим тохиолдолд нэрийн жагсаалттай холбоотой өргөдөл гомдлыг СЕХ-оор дамжуулан гаргаж байгаа нь процессын давхардал үүсгэж байгаагаас гадна маргаан шийдвэрлэх хугацаа уртсах нөхцөл болж байна.


2019 оноос сонгуулийн хуулиас өмнө нэрсийн жагсаалттай холбоотой гомдол шийдвэрлэх журмыг хуульдаа тусгаж ирсэн бол 2019 оны хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд гомдол гаргах журам тогтоосон боловч бүртгэлийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гомдол гаргах шийдвэрлэх асуудлаар тусгайлсан журам тогтоогоогүй тул өргөдөл гомдлууд бүртгэлийн байгууллагын тогтолцооны хүрээнд шийдвэрлэгдэж байна.

Маргаан үүсэж буй нийтлэг тохиолдлуудаас дүгнэхэд хаягийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, гадаад улсад зорчих хөдөлгөөн зэрэг үйл ажиллагаанд автоматжуулсан, realtime уялдаа бүхий систем нэвтрүүлсэн тохиолдолд дийлэнх өргөдөл гомдол агуулгын хүрээнд шийдвэрлэгдэх боломжтойгоос гадна гомдол маргааныг үр дүнтэй шуурхай шийдвэрлэх техникийн боломжийг бүрдүүлэхээр байна.

2. Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)⁶⁴: (Доод шатны сонгуулийн байгууллагын шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол, сонгуулийн үйл ажиллагаанд холбогдох нийтлэг гомдлууд)

А. Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал:

Диаграмм 1: Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлсэн өргөдөл гомдлын хураангуй



Тэмдэглэл: Шийдвэрлэлт дунджаар 80–88%, шилжүүлэлт 12–23%–ийн хооронд хэлбэлзэж байна. 2021 онд хамгийн өндөр шийдвэрлэлттэй (87.8%), 2020 онд хамгийн их шилжүүлэлттэй (22.6%) байна. Шилжүүлэлтийн хувь хэмжээ нь буруу харьяалаар гаргасан гомдлын шууд бус үзүүлэлт болох тул шилжүүлэлтийн хувь хэмжээ харьцангуй өндөр байсаар байгаа нь гомдол гаргах харьяаллын талаарх мэдлэг ойлголт хангалттай биш байгааг илтгэж байна.


⁶⁴ Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 3/345 дугаартай албан бичигт тулгуурлан бэлтгэв.

Б. Гомдол гаргагч:

Диаграмм 2: СЕХ-ны 2020 оны УИХ-ын сонгуулиар шийдвэрлэсэн гомдол (гомдол гаргагчийн төрлөөр)



Диаграмм 3: СЕХ-ны 2024 оны УИХ болон орон нутгийн сонгуулиар шийдвэрлэсэн нийт гомдол (гомдол гаргагчийн төрлөөр)



Төрөл	Нийт	Шилжүүлсэн	Шийдвэрлэсэн	Шилжүүлсэн %	Шийдвэрлэлт %
Иргэн	139	33	106	23.7%	76.3%
Хуулийн этгээд	150	21	129	14.0%	86.0%

Тэмдэглэл: 2024 оны үзүүлэлтээс харахад иргэдийн гомдлыг шилжүүлэх тохиолдол илүү өндөр хувьтай байгаа нь иргэдэд зориулсан хууль зүйн мэдээлэл, тайлбар үйлчилгээ сул байж болзошгүйг харуулж байна.

В. Шилжүүлсэн өргөдлийн чиглэл (харьяаллын байгууллага)

Хүснэгт 3: Шилжүүлсэн өргөдөл гомдлын дүн

Он	Аймгийн хороо	УБЕГ	Цагдаагийн байгууллага	АТГ	Нийт шилжүүлсэн
2020	12	8	52	0	72
2021	2	6	4	0	12
2024	3	3	47	1	54

Тэмдэглэл: 2020 онд шилжүүлэлтийн 72.2% нь, 2024 онд 87.0% нь буюу дийлэнх хэсгийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байгаа нь цагдаагийн байгууллагын харьяалан шийдвэрлэх зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийн талаарх гомдол мэдээллийг СЕХ-д гаргах тохиолдол түгээмэл байгааг илтгэж байна.

Г. Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой шийдвэр

Хүснэгт 4: Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэсэн үзүүлэлт

Сонгууль	Нийт хүсэлт	Татгалзсан	Татгалзсан %
2020 УИХ (ээлжит)	626	20	3.19%
2020 УИХ (нөхөн/дахин)	108	6	5.56%
2024 УИХ (ээлжит)	1399	62 ⁶⁵	4.43%
2024 Аймаг/нийслэл/сум/дүүргийн ИТХ	17,386	108	0.62%

Тэмдэглэл: УИХ-ийн сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах шийдвэрийн хувь хэмжээ өссөн (2020 онд 3.19%, 2024 онд 4.43%) хандлагатай байна. Гэтэл нэр дэвшигчдээс шүүхэд хандан шийдвэрлүүлэх тохиолдолд харьцангуй бага байна. Жишээлбэл, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан 62 шийдвэрээс 9 шийдвэрт холбогдох нэр дэвшигч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байх бөгөөд 5 нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.⁶⁶

⁶⁵ Татгалзсан шийдвэрүүдээс 9 шийдвэрт холбогдуулан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаснаас 5 нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна. (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 204 дугаартай албан бичгийн хавсралт мэдээлэл)

⁶⁶ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 204 дугаартай албан бичгийн хавсралтад дурдсан мэдээлэл

Нөгөө талаас татгалзсан шийдвэрүүдтэй маргахгүй байгаа нь СЕХ-ны шийдвэр хууль зүйн үндэслэлтэй байгаатай холбоотой байж болно. Аль ч тохиолдолд СЕХ-ны хувьд нэр дэвшигчид тавигдах шаардлагатай холбоотой маргаан үүсэж болзошгүй нөхцөл байдлаас сэргийлж хууль тогтоомжийн зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэглэхтэй холбоотой шаардлагатай арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлэх⁶⁷ нь сонгуулийн үеэр бүртгэлтэй холбоотой маргаан⁶⁸ үүсэх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Дүн шинжилгээ: СЕХ-д гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт дунджаар 80-аас дээш хувьтай байгаа нь харьцангуй тогтвортой өндөр үзүүлэлт хэдий ч гаргасан өргөдөл гомдлыг шилжүүлж буй үзүүлэлтээс харахад СЕХ-д гаргасан нийт өргөдөл гомдлын ¼ орчмыг буруу харьяаллаар гаргаж байгааг илтгэх бөгөөд энэ нь гомдол маргааны шийдвэрлэлтийн хугацаа, үр дүнд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлж байгааг үгүйсгэх аргагүй. Гэвч тухайн үзүүлэлтийг бодитоор үнэлэхийн тулд шилжүүлсэн хугацааг тусгайлан харгалзан үзэх шаардлагатайг дурдах нь зүйтэй юм.

⁶⁷ Хууль тогтоомжийн хэрэглээний талаар тайлбар гаргуулах, нэр дэвшигчийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг урьдчилан ил тод, эргэлзээгүй нарийвчлан тогтоон нээлттэй мэдээлэх гэх мэт

⁶⁸ Тухайлбал, 2024 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч Н.Номтойбаяр нь “авлига, албан тушаалын хэргээр ял шийтгүүлсэн” гэж үзэх эсэх талаарх маргаан өргөн хүрээнд өрнөж байв. <https://itoim.mn/a/2024/06/03/politic/btm>

3. Цагдаагийн байгууллага⁶⁹ (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5, 14.6, 14.7, 14.8-р зүйлүүдэд заасан гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9, 11, 12, 13, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчлүүд)

Тоон мэдээллийн шинжилгээ

А. Бүртгэгдсэн нийт гомдол мэдээллийн судалгаа

Хүснэгт 5: Бүртгэгдсэн гомдол мэдээллийн шийдвэрлэлт

Сонгуулийн төрөл	Он	Бүртгэсэн нийт гомдол, мэдээлэл	Үүнээс:		Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн	Зөрчлийн хэрэг үүсгэсэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан
			гэмт хэргийн шинжтэй	зөрчлийн шинжтэй					
Улсын Их Хурлын сонгууль	2020	2,565	182	2,387	15	213	112	131	2,098
	2024	1,263	474	789	29	56	44	362	772
Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль	2020	1,045	71	974	7	72	53	53	860
	2024	1,177	411	766	23	79	32	375	726
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	2021	79	7	71	1	12	6	7	53

Гомдлын динамик үзүүлэлт: 2020 оны УИХ-ын сонгуулиар хамгийн олон буюу 2,565 гомдол бүртгэгдсэн бол 2024 онд энэ тоо 1,263 болж 50 орчим хувиар буурсан байна. Харин орон нутгийн сонгуулийн гомдол эсрэгээрээ 2020 онд 1,045 байсан бол 2024 онд 1,177 болж өсжээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр цагдаагийн байгууллагад гаргасан нийт гомдол 79 байсан нь харьцангуй цөөн тооны үзүүлэлт байна.

⁶⁹ ЦЕГ-ын Инновац хөгжлийн албаны 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 10г/2012 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

Гомдлын шинж, төрөл: 2020 оны УИХ-ын сонгуулийн гомдлын дийлэнх (93%) нь зөрчлийн шинжтэй байсан бол 2024 онд гэмт хэргийн шинжтэй гомдлын хувь огцом өсөж (474 буюу 37.5%) зөрчлийн шинжтэй гомдлын тоо эрс буурсан. Орон нутгийн сонгуулийн хувьд мөн 2024 онд гэмт хэргийн шинжтэй гомдлын эзлэх хувь мэдэгдэхүйц нэмэгдсэн. Тодруулбал, гэмт хэргийн шинжтэй гомдлын нийт гомдолд эзлэх хувь 2020, 2024 оны сонгуулийн үед УИХ-ын сонгуулийн хувьд 5.3 дахин, орон нутгийн сонгуулийн хувьд 5.1 дахин нэмэгдсэн бол зөрчлийн шинжтэй гомдлын нийт гомдолд эзлэх хувь 2020 онд 93 хувь орчим байсан бол 2024 онд 65 хувь хүртэл буурчээ. Энэ нь 2024 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр⁷⁰ тагнуулын байгууллагын харьяалалд байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5 (Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх), 14.6 (Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх), 14.7 (Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах), 14.8 (Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах)-д заасан гэмт хэргүүдийг цагдаагийн байгууллагын харьяалалд шилжүүлсэнтэй шууд холбоотой байна.

Гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлт: 2020-2024 онд гэмт хэргийн шинжтэй гомдлын тоо огцом өссөн (182 - 474, 71 - 411) байх боловч хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгах хувь хэмжээ буурсан байна. Энэ гэмт хэргийн шинжтэй үйлдлийн тоо өсөж байгаа мэт харагдавч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах буюу хэрэг бүртгэлт нээх тохиолдол улам бүр багасаж байгааг харуулна. Харин зөрчлийн шинжтэй гомдлын дийлэнхэд (2020 онд 88–90% орчим, 2024 онд бүр ч илүү буюу 95–98%-д) зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. 2024 онд зөрчлийн шинжтэй гомдлын тоо буурсан боловч татгалзсан хувь өссөн байгаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хүлээлт, итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байгаа учир нөхцөл шалтгааныг нарийвчлан судалж татгалзлын хувь хэмжээг бууруулахад чиглэсэн арга зүй, зохион байгуулалт, хууль тогтоомжид

⁷⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хууль.

өөрчлөлт оруулах замаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Б. Бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа

Хүснэгт 6: Бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлт

№	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (ЭХ-ийн тусгай ангийн 14-р бүлэг ⁷¹)	Шийдвэрлэлт			
		Хэрэг бүртгэлтийг хэрэгсэхгүй болгох санал	Шүүхэд шилжүүлэх санал	Нэгтгэсэн	Ажиллагаанд шалгагдаж байгаа
2020	22	21	0	0	1
2021	2	2	0	0	0
2024	52	29	5	2	16
Нийт	76	52	5	2	17

Тэмдэглэл: 2020, 2021 онуудад бүртгэгдсэн хэргийн дийлэнхийг нь (95–100%) цагдаагийн байгууллагаас “хэрэгсэхгүй болгох санал” гаргасан. Харин 2024 оны хувьд бүртгэгдсэн гэмт хэргүүдийн 55.8 хувь нь хэрэгсэхгүй, 9.6 хувь нь шүүхэд шилжсэн, 3.8 хувийг нэгтгэсэн ба 30.8 хувь нь шалгагдаж байгаа үзүүлэлттэй байгаагаас харвал бодит мөрдөн шалгах ажиллагаа эрс идэвхэжсэн гэж дүгнэж болох боловч энэхүү нөхцөл байдалд гэмт хэргийн тоо 22 - 52 болж 2.4 дахин өссөн үзүүлэлт нөлөөлж байгааг анхаарах нь зүйтэй.

Кейс: УИХ-ын сонгуулийн хоёрдугаар тойрог буюу Увс, Ховд, Говь-Алтай, Завхан аймагт Ардчилсан намаас нэр дэвшиж, УИХ-ын гишүүнээр сонгогдоод буй Б.Түвшин, О.Амгаланбаатар нарын сонгуулийн сурталчилгааны ажилд оролцсон гурван иргэнийг “сонгогчийг мөнгөөр татаж, санал худалдан авсан” гэх гэмт хэрэгт холбогдуулан хэргийг шалгаж дууссан байна. Тэднийг Эрүүгийн хуулийн 14.5 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зүйл ангиар буруутган шалгаж, улмаар прокуророос тус зүйл ангиар яллах дүгнэлт үйлдэн, хэргийг Завхан аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлжээ. Тус хэргийн хувьд сонгуулийн сурталчилгаанд ажилласан иргэдийг яллагдагчаар татсан байх боловч холбогдох УИХ-ын гишүүдийг захиалагч, хатгагч зэрэг хамтран оролцогчоор татаагүй нь хууль хэрэглээний эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

⁷¹ Энэхүү бүлэгт зөвхөн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргээс гадна хүний хувийн болон улсын төрийн эрхийн эсрэг зарим гэмт хэргүүд багтаж байгааг анхаарна уу.

4. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх
(Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотой сонгуулийн хороодын шийдвэртэй холбоотой гаргасан нэхэмжлэл, Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан сонгуулийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн шийтгэлийн хуудастай холбоотой гаргасан гомдол)

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2019-2025 оны хооронд Сонгуулийн ерөнхий хороо, Нийслэлийн сонгуулийн хороо, дүүргийн сонгуулийн хороонд холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй хэргүүдийг дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Эдгээрийн ихэнх нь нийслэлийн орон нутгийн сонгуульд холбогдох сонгуулийн хороодын шийдвэртэй холбоотой маргаанууд байна.

А. Нэхэмжлэл шийдвэрлэлт

Хүснэгт 7: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн маргаан шийдвэрлэлт

	Шийдвэрлэлтийн төрөл	Тоо
	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан	13
1	54.1.1 – харьяаллын бус	1
	54.1.2 – тухайн шүүхийн харьяаллын бус	2
	54.1.3 – урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй	1
	54.1.5 – нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд	6
	54.1.8 – хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн	3
2	Бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг буцаасан (53.4)	8
3	Нэхэмжлэгч 2 удаа шүүх хуралдаанд ирээгүй үндэслэлээр нэхэмжлэлийг буцаасан (91.3)	1
4	Хэргийн хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзсан (109.2)	1
5	Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон (66)	5
6	Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн	11
	Нийт	39

Б. Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэргийг хянан шийдвэрлэсэн хугацаа

Хүснэгт 8: Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа

№	Шийдвэрийн дугаар	Шийдвэрлэсэн хугацаа /хоногоор/
1	128/ШШ2024/0763	7
2	128/ШШ2024/0762	10
3	128/ШШ2024/0752	8
4	128/ШШ2024/0777	17
5	128/ШШ2024/0938	125
6	128/ШШ2024/0461	29
7	128/ШШ2024/0090	221
8	128/ШШ2020/0629	13
9	128/ШШ2024/0170	132
10	128/ШШ2021/0221	182
11	128/ШШ2019/0682	163
Дундаж хугацаа		82 хоног

Тэмдэглэл: Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхэд харьяалан шийдвэрлэх сонгуулийн хороодын шийдвэртэй холбоотой 39 нэхэмжлэлийн хүрээнд авч үзэхэд 11 (28.2%) хэргийг шүүхийн шийдвэрээр хянан шийдвэрлэсэн. Нэхэмжлэлийн 33.3 хувийг хүлээн авахаас татгалзсан, 23 хувийг буцаасан зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захирамжаар шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн хэргүүдийн хувьд 7–17 хоногт шийдвэрлэсэн тохиолдол байхад, 125–221 хоног үргэлжилсэн хэргүүд ч байх бөгөөд дундаж хугацаа нь 82 хоног байгаагаас үзэхэд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд сонгуулийн маргааны онцлог болох шуурхай шийдвэрлэх байдал хангагдахгүй байгаа нь харагдаж байна.

Эдгээр нь нэхэмжлэгчид буюу сонгуулийн харилцаанд оролцогчдын эрх зүйн мэдлэг дутмаг, харилцан адилгүй байгааг харуулж байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх хугацааны үзүүлэлт нь нэг талаас шүүхийн ачааллыг бууруулах нөгөө талаас сонгуулийн маргаан шүүхэд шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

Судалгааны хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэгдсэн сонгуулийн хууль тогтоомж зөрчих

зөрчилд шийтгэл ногдуулсан шийтгэлийн хуудастай холбоотой шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж үзэхэд нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн шийтгэлийн хуудастай холбоотой нэг хэрэг (зардлын тайлан хүргүүлээгүй), татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудастай холбоотой хоёр (шаардлага хангаагүй хандив хүлээн авсан, дансны дугаар УАГ-т хүргүүлээгүй) хэргийн шүүхийн шийдвэр олдсон бөгөөд нэг хэрэгт гомдлын шаардлага хангагдаж, хоёр хэрэгт гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин сонгуулийн үед буюу санал хураалтаас өмнө Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэгдсэн зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр шүүхийн шийдвэрийн цахим сангаас олдоогүй болно.

5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх⁷²: (УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар СЕХ-ны шийдвэрт холбогдох маргаан)

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс тодорхой шалтгааны улмаас зөвхөн 2024 оны УИХ-ын сонгуультай холбоотой маргааны мэдээллийг ирүүлсэн бөгөөд тус мэдээлэлд тулгуурлан энэхүү шинжилгээг хийв.

А. Нэхэмжлэлийн шийдвэрлэлтийн ерөнхий статистик

Хүснэгт 9: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн маргаан шийдвэрлэлт /2024/

Шийдвэрийн төрөл	Тоо	Хувь (%)
Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан	7	43.7%
Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	3	18.8%
Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан	6	37.5%
Нийт	16	100%

Тэмдэглэл: Тус нэхэмжлэлийн шаардлагууд нь ихэвчлэн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулах агуулгатай байсан бөгөөд нэхэмжлэлийн нэлээд өндөр хувь (43.7%) хангагдсан үзүүлэлтээс дүгнэхэд нам, нэр дэвшигчийн сонгогдох эрхийг хангах хамгаалахад бодитой нөлөө үзүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

⁷² Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 204 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

Б. Шийдвэрлэсэн хэргүүдийн тойм

Хүснэгт 10: ЗХДЗШШ-ийн 2024 оны сонгуулиар шийдвэрлэсэн хэргүүд

Нэхэмжлэл гаргасан огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Шийдвэрлэсэн огноо	Шийдвэрлэсэн байдал
1 5/6/2024	Хөгжлийн хөтөлбөр нам	Сонгуулийн ерөнхий хороо	Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024.04.30-ны өдрийн 50 дугаар тогтоолыг хүчингүй болуулах, Хөгжлийн хөтөлбөр намыг 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцуулахаар бүртгэхийг даалгуулах	5/28/2024	Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон
2 5/6/2024	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	Монголын ногоон нам, Монголын Үндэсний ардчилсан нам, Уламжлалын нэгдэл нам, Бүгд найрамдах нам, Ард түмний олонхын засаглал нам	Нэр бүхий намууд Сонгуулийн тухай хуулийн 26.2-г сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж тамга тэмдэг даран баталгаажуулна, 2. Сонгуулийн тухай хуулийн 26.3.9-д заасан шаардлагатай холбоотойгоор намын даргын УДШ-ийн лавлагаа, тамга тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа авна	5/13/2024	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан

Нэхэмжлэл гаргасан огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	ШИЙДВЭРЛЭСЭН ОГНОО	ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ
3 5/6/2024	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	Үнэн ба зөв нам нарын 10 нам	Нэр бүхий намууд Сонгуулийн тухай хуулийн 26.2-т сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж тамга тэмдэг даран баталгаажуулна, 2. Сонгуулийн тухай хуулийн 26.3.9-д заасан шаардлагагай холбоотойгоор намын даргын УДШ-ийн лавлагаа, тамга тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа авна	6/12/2024	Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон
4 5/6/2024	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	Эрх чөлөөний эвсэл нам	Нэр бүхий намууд Сонгуулийн тухай хуулийн 26.2-т сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж тамга тэмдэг даран баталгаажуулна, 2. Сонгуулийн тухай хуулийн 26.3.9-д заасан шаардлагагай холбоотойгоор намын даргын УДШ-ийн лавлагаа, тамга тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа авна	5/13/2024	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан

Нэхэмжлэл гаргасан огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Шийдвэрлэсэн огноо	Шийдвэрлэсэн байдал
5 5/7/2024	Монгол шинэтгэл нам	Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний Аудитын газар	Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024.04.30-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, Монгол шинэтгэлт намыг 2024 оны УИХ-ын сонгуульд оролцох нам, эвслийн жагсаалтад бүртгэх, батламж олгохыг Сонгуулийн Ерөнхий хороонд даалгах	5/15/2024	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан
6 5/31/2024	Б.Хурц	Сонгуулийн ерөнхий хороо	Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны хурлын 2020 оны 5 сарын 20-ны өдрийн 9 дүгээр тогтоол, түүний хавсралтад бичигдсэн нэр дэвшигчид болон Б.Хурцыг 2024 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхгүй байгаа эс үйлдэхүй байгаа СЕХ-ны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, нэр дэвшигчээр бүртгэхийг даалгах	6/7/2024	Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон

Нэхэмжлэл гаргасан огноо	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	ШИЙДВЭРЛЭСЭН ОГНОО	ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ
7 6/13/2024	Д.Жаргалсайхан	Сонгуулийн ерөнхий хороо	УИХ-ын 5-р тойрогт АН-аас тус намын дүрэмд заасан УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх журмыг зөрчиж нэр дэвшүүлсэн Н.Одонгуа, Л.Одбаяр нарыг СЕХ-оос бүртгэсэн бүртгэлийг хүчингүйд тооцуулах	6/13/2024	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан

Тэмдэглэл: Маргаан шийдвэрлэсэн хугацааны үзүүлэлтийн хувьд 2024 оны УИХ-ын сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх харьцангуй богино хугацаанд буюу 0-37 хоногийн хугацаанд эдгээрээс 12 хэргийг 10-аас доош хоногт, нийт хэргийн хувьд дунджаар 10 хоногт шийдвэрлэсэн байгаа нь сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны гол онцлог болох шуурхай шийдвэрлэх зорилтыг хангаж ажилласан байгаа нь маргаан шийдвэрлэх ажиллагааны хувьд дэвшил гэж үзэж байна.

6. Эрүүгийн хэргийн шүүх⁷³: (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9-р зүйлүүдэд заасан гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4-д заасан зөрчил)

Энэхүү судалгааны хүрээнд Нийслэлийн төвийн бүсийн зургаан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс мэдээлэл гаргуулан авч ашигласан болно.

А. Шүүхүүдийн шийдвэрлэлтийн мэдээлэл:

Хүснэгт 11: Нийслэлийн төвийн дүүргийн эрүүгийн шүүхэд шийдвэрлэгдсэн эрүү, зөрчлийн хэргүүдийн тоон мэдээлэл

Шүүх	Огноо	Шийдвэрийн дугаар	Зөрчил	Шийдвэрлэлтийн тоо
БГД, ХУД, СХД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020.09.23	2020/ЗШ/1369	Зөрчлийн тухай хуулийн 17.1, 18.2	1
	2024.10.15	2024/ЗШ/2673	Зөрчлийн тухай хуулийн 17.1, 18.2	1
	2024.10.31	2024/ЗШ/2142	Зөрчлийн тухай хуулийн 17.1, 18.2	1
Нийт (БГД, ХУД, СХД)				3 хэрэг
БЗД, СБД, ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020–2024	–	–	0 хэрэг

Дүгнэлт: Хамгийн олон сонгогч төвлөрсөн сонгуулийн үйл ажиллагааны томоохон төв болох нийслэлийн төвийн зургаан дүүргийн хэмжээнд Ерөнхийлөгчийн нэг, УИХ-ын хоёр, орон нутгийн

⁷³ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 922 дугаартай албан бичиг, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газраас ирүүлсэн 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1136 дугаартай албан бичгүүдэд үндэслэв.

хоёр сонгууль явагдахад сонгуультай холбоотой эрүүгийн шүүхийн харьяалан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг байхгүй, зөрчлийн гурван хэрэг хянан шийдвэрлэсэн байгаа нь зургаан дүүргийн хэмжээнд нийт цагдаа, тагнуулын байгууллагад хандаж гаргаж буй олон мянган гомдолтой харьцуулахад маш бага үзүүлэлт юм. Үүний суурь шалтгаан нь цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллагын статистикаас харьцангуй тодорхой харагдаж байгаа бөгөөд нийт гомдлын 88-98 хувьд зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн, зөрчлийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдлууд ихэвчлэн шүүхэд шилжихээс өмнө хэрэгсэхгүй болж байгаатай шууд холбоотой юм.

Гэтэл нэр дэвшигчээс хасах үр дагавар бүхий зөрчлийн шийтгэлийг зөвхөн Эрүүгийн хэргийн шүүх гаргахаар хуульчилсан байгаа бөгөөд бодит нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэхэд нэр дэвшигчийг хасах хууль зүйн нөхцөл байдал үүсэх боломжгүй нь илэрхий байна. Судалгааны хүрээнд авагдсан шүүхийн гурван шийтгэлийн хуудаснаас үзэхэд сонгууль дууссанаас хойш 3-4 сарын дараа шийдэгдсэн байгаа нь шийтгэлийн хуудсыг үр нөлөөгүй болгож байна.

7. Тагнуулын ерөнхий газар⁷⁴: (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.9 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 35, 36 дахь хэсэгт заасан зөрчил)

А. ТЕГ-т бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн ерөнхий нэгтгэл

Хүснэгт 12: ТЕГ-т гаргасан гомдол мэдээллийн шийдвэрлэлт

№	Сонгууль	Гомдол мэдээлэл				Хэрэг бүртгэлтийн хэрэг		
		Хүлээн авсан	Хэрэг нээсэн	Татгалзсан	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Нийт	Хаасан	Эрүүгийн хэрэг үүсгэсэн
1	2020 оны УИХ-ын сонгууль	204	14	177	13	14	14	-
2	2020 оны ИТХ-ын сонгууль	60	19	48	3	19	18	1
3	2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль	13	1	11	1	1	1	-
4	2024 оны УИХ-ын сонгууль	17	2	-	15	1	1	-
5	2024 оны ИТХ-ын сонгууль	4	-	-	4	-	-	-

⁷⁴ Тагнуулын ерөнхий газрын 2025 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 09/967 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

Б. Гомдлын агуулгын ангилал

Хүснэгт 13: ТЕГ-т гаргасан гомдлын ангилал

Он, сонгуулийн төрөл	Хүлээн авсан гомдол	Зүйлчлэлийн ангилал (тоо, %)
2020, УИХ	204	ЭХТА 13.14 – 3 (1.5%), ЭХТА 14.5 – 67 (32.8%), ЭХТА 14.8 – 9 (4.4%), бусад – 125 (61.3%)
2020, ИТХ	60	ЭХТА 14.5 – 44 (73.3%), ЭХТА 14.8 – 11 (18.3%), ЭХТА 14.9 – 5 (8.3%)
2021, Ерөнхийлөгч	13	ЭХТА 14.5 – 10 (76.9%), ЭХТА 14.8 – 1 (7.7%), ЭХТА 14.9 – 1 (7.7%), ЭХТА 13.5 – 1 (7.7%)
2024, УИХ	17	ЭХТА 14.5 – 2 (11.8%), ЭХТА 14.7 – 8 (47.1%), ЭХТА 14.8 – 4 (23.5%), Бусад – 3 (17.6%)
2024, ИТХ	4	ЭХТА 14.5 – 3 (75.0%), ЭХТА 14.8 – 1 (25.0%)
Нийт	298	ЭХТА 13.5 – 1 (0.3%), ЭХТА 13.14 – 3 (1.0%), ЭХТА 14.5 – 126 (42.3%), ЭХТА 14.7 – 8 (2.7%), ЭХТА 14.8 – 26 (8.7%), ЭХТА 14.9 – 6 (2.0%), Бусад – 128 (43.0%)

Тэмдэглэл: 2020 онтой харьцуулахад 2024 онд гомдлын тоо 12.5 дахин буурсан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалал өөрчлөгдсөнтэй шууд холбоотой байна. Үүнтэй холбоотойгоор 2024 оны УИХ, орон нутгийн сонгуулийн үеэр ТЕГ-т гаргасан нийт гомдлын 90 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ. Эндээс үзэхэд сонгуулийн жил буюу сонгууль болох хугацаанаас таван сарын өмнөх хуулийн өөрчлөлтийг мэдээгүйн улмаас буруу харьяаллаар гомдлоо гаргажээ.

2020 онд УИХ-ын сонгуультай холбоотой гомдлын 6.9 хувь (204-аас 14), ИТХ-ын сонгуулийн гомдлын 31.6 хувь (60-аас 19), 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нийт 13 гомдлоос 1 хэрэгт (7.7%) хэрэг бүртгэл нээсэн бол 2024 онд УИХ-ын сонгуулийн үеэр 17 гомдлоос хоёрт нь хэрэг бүртгэлт (11.7%) нээсэн, харин ИТХ-д нэг ч хэрэг бүртгэлт нээгээгүй байна.

2020 оноос хойших нийт сонгуулийн хугацаанд 2020 оны ИТХ-ын сонгуультай холбоотой нэг гомдолд Эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.

Дүгнэлт: 2020 оны сонгуулийн үеэр нийт гэмт хэргийн шинжтэй 264 гомдлыг ТЕГ-т гаргасан байх бөгөөд хүний нөөцийн ачаалал,

байгууллагын тогтолцооны онцлог зэргээс хамаарч дийлэнх гэмт хэргийг шалган шийдвэрлэх харьяаллыг цагдаагийн байгууллагад шилжүүлжээ. Ингэж процессын хуулийн өөрчлөлтийг сонгуулийн хугацаа ойртсон үед хийснээс үүдэлтэйгээр гомдол гаргагчдад төөрөгдөл үүсгэх тохиолдол гарч байгааг цаашид анхаарах шаардлагатай байна. Тодруулбал, Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасан боловч сонгуулийн харилцаа тэр тусмаа сонгуулийн зөрчил, маргаан, түүний процессыг зохицуулсан хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулахад аливаа хязгаарлалтгүй байна.

Тус нэмэлт өөрчлөлтийг оруулсны дараа сонгуулийн хуулиуд, СЕХ-ны тодорхой журмуудад заасан ТЕГ-ын оролцоо чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтууд хэрэгжих боломжгүй болж хууль тогтоомжийн зөрчил үүсгэжээ. Тухайлбал, МУИХСтХ-ийн 47 дугаар зүйлийн 47.7, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын 6.1 дэх зохицуулалтуудад тагнуулын ерөнхий газар дурдагдсан нь хууль тогтоомжийн өөрчлөлтөөс өмнөх харьяалал, чиг үүрэгтэй холбоотой байна.

8. Харилцаа холбооны зохицуулах хороо:⁷⁵ (Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн санал, албан бичгийг үндэслэн цахим хуудас болон цахим хуудасны хандалтыг түр хаах, хязгаарлах асуудал, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 14, 37, 38, 39 дэх хэсэгт заасан зөрчил)

А. Эрх бүхий байгууллагын шийдвэр албан бичгийн дагуу авсан арга хэмжээний нэгдсэн үзүүлэлт

Хүснэгт 14: ХХЗХ-ны сонгуулийн үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон мэдээлэл

№	Сонгууль	ЭБ байгууллагын шийдвэр бүхий албан бичгийн тоо	Мета /Одоогийн/ компанид илгээсэн хүсэлтийн тоо	Мета компаниас ирсэн хариу / хувь хэмжээ	Шийдвэрлэсэн контентын тоо	
					Шийдвэрлэсэн тоо/хувь	Зөрчилгүй
1	2020 Монгол Улсын Их Хурлын сонгууль	325	325	284 /87%/	138 /42%/	146
2	2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын сонгууль	53	53	43 /81%/	32 /32%/	11
3	2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	536 /703 линк устгуулах/	536	294 /55%/	291 линк устгасан /54%/	3
4	2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгууль	277 /956 линк устгуулах/	277	267 /96%/	400 линк устгасан	-
5	2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын сонгууль	78 /182 линк устгуулах/	78	77 /99%/	28 линк устгасан /36%/	-

⁷⁵ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 06/1597 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

Дүн шинжилгээ: ХХЗХ нь МУИХСтХ-ийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт зааснаар тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дээрх арга хэмжээг авахаар хуульчилсан. Харин Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын 6.1, 6.3-т цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллагаас гадна Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хаах, хязгаарлах шийдвэр гаргахаар тусгаснаар хэм хэмжээний актын зохицуулалт нь хуулийн агуулгатай зөрчилдсөн буюу хуулиар цахим орчны мэдээллийг устгуулах шийдвэр хүргүүлэх эрх олгогдоогүй субъектэд журмаар тус эрхийг олгосон байна.

ХХЗХ-ны хувьд нэгэнт журмаар хүлээсэн үүрэг тул албан бичгээр ирүүлсэн шийдвэр бүрийг Мета компани (Фейсбүүк)-д уламжилдаг ажээ. 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр илгээсэн 325 хүсэлтээс 146-г зөрчилгүй гэж дүгнэн устгах арга хэмжээ аваагүй нь Фейсбүүк компанитай 2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль, 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд зөвхөн “Community Standards”-г зөрчсөн контентыг платформоор устгах чиглэлээр хамтран ажилласан тул дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн агуулгатай ч “Community Standards”-д нийцэж байсан тул устгагдаагүй гэж дүгнэж болохоор байна. Харин 2024 оны ээлжит сонгуулийн үеэр Мета компанийн зүгээс ХХЗХ-оос хүргүүлсэн хүсэлтийн 96-99 хувийг хүлээн авсан үзүүлэлттэй байгаа нь гадаад хамтын ажиллагаа, арга хэмжээний хүрээнд эрх бүхий байгууллагуудын шийдвэрийн биелэлт шууд хангагдаж буй эерэг үзүүлэлт боловч эрх бүхий байгууллагын зүгээс тус хүчтэй механизмыг аливаа хэлбэрээр зүй бусаар урвуулан ашиглахаас сэргийлэх, хяналт мониторингийн арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх нь зүйтэй.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс

санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно” гэж заасан. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хорооны саналд тавигдах шаардлага, түүний агуулгын талаар хууль, журамд тусгайлан заагаагүй нь цахим орчин дахь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдэх эрхийг хэтрүүлэн хязгаарлах эрсдэлийг бий болгосон⁷⁶ талаар судлаачид анхааруулдаг.

Нөгөөтээгүүр олон нийтийн цахим сүлжээг зөрчил, гэмт хэрэг, хууль бус ажиллагаанд ашиглахаас сэргийлэх зорилготой арга хэмжээний хүрээнд олгогдож буй эрх мэдлийг нөлөө бүхий нам, улс төрчдийг шударга бус өрсөлдөөний хэрэгсэл болгон ашиглахаас сэргийлэх зохистой механизмыг бүрдүүлэх шаардлагатай. Учир нь цахим сүлжээн дэх агуулга, нийтлэл нь хүний үг хэлэх, үзэл бодолтой байх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний салшгүй хэсэг байдаг тул хаах хязгаарлах арга хэмжээг хууль ёсны бөгөөд зохистой түвшинд байлгах, тусгай нарийн нөхцөлийг нарийвчлан тогтоох шаардлага зүй ёсоор тавигдана.⁷⁷

Иймээс сонгуулийн үеийн цахим орчны хяналт хязгаарлалтыг хэрэгжүүлэх буюу хаах, түр хязгаарлах арга хэмжээ авах эрх мэдэл, үндэслэл журмыг хэм хэмжээний актаар тэр тусмаа нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй хэмжээний актаар зохицуулах нь хүний эрхийн зөрчил үүсгэхээс гадна Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон “хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй, иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх”⁷⁸, тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд

⁷⁶ <https://www.polit.mn/a/104902> - “Л.Галбаатар: Мэдээллийн ил тод байдлыг хатуу хязгаарласан хэвээр байна” /сүүлд нэвтэрсэн: 2025.08.21/

⁷⁷ Тухайлбал, “БНСУ-ийн хувьд Сонгуулийн тухай хуулийн хүрээнд Интернэт дэх сонгуулийн мэдээллийн маргаан таслах комисс ажиллуулдаг бөгөөд сонгуулийн кампанит ажилтай холбоотой аливаа мэдээллийг хянан шийдвэрлэхдээ дараах нөхцөл байдлыг анхаарч үздэг байна. Үүнд: Мэдээлэл нийтлэгдсэн хугацаа; Хэрэглэгчийн тооноос үүдэлтэй интернэт хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөлөх байдал; Маргаан хянан шалгах шалгуурыг удаа дараа зөрчсөн эсэх зэрэг багтана” – Судлаач Б.Амарсанаа нарын гүйцэтгэсэн “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих эрх зүйн орчны судалгаа”-аас ашиглав.

⁷⁸ ЗЕХ-ийн 60.1.1

нийцсэн байх⁷⁹, хуулиар эрх олгосноос бусад тохиолдолд хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх⁸⁰ зэрэг шаардлагуудтай агуулгын хувьд зөрчилдөх магадлалтай байна.


9. Сангийн яам / Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч:

(Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил)

Судалгааны хүрээнд нийслэлийн есөн дүүргийн хэмжээнд 2024 оны сонгуультай холбоотой шалган шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн мэдээллийг авч ашигласан болно.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон үзүүлэлт:


Диаграмм 4: Зардлын дансны эцсийн тайлан ирүүлээгүй нэр дэвшигчидтэй холбоотой хэрэг (2024)



⁷⁹ ЗЕХ-ийн 60.1.2

⁸⁰ ЗЕХ-ийн 60.1.6

Диаграмм 5: Зардлын зарцуулалтын явцын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчидтэй холбоотой хэрэг (2024)



Дүн шинжилгээ: Эцсийн тайлангийн зөрчлийн 88.2 хувь, явцын тайлангийн зөрчлийн 86.4 хувь нь хэрэгсэхгүй болсон байна. Тухайн төрлийн зөрчлийн талаар ҮАГ-аас тусгайлсан чиглэл, мэдээлэл хүргүүлж олон тооны нэр дэвшигчтэй холбоотой зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан нь нийгэмд багагүй шуугиан дэгдээсэн бөгөөд тухайн зөрчил болон хариуцлагын арга хэмжээ (10-20 сая төгрөгөөр торгох) тохироогүй талаарх шүүмжлэл ихээхэн өрнөсөн нь Зөрчлийн тухай хууль дахь сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчлийн хариуцлагын арга хэмжээг зохистой, бодитой, зөрчилд тохирсон болгоход анхаарах шаардлагатайг харуулж байна.

Нөгөөтээгүүр ийнхүү эрх бүхий байгууллагаас мэдээлэл хүргүүлэн ажиллаж байгаа нь сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч тайланг хүлээн авах болон зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүргийг хоёр тусдаа байгууллага хэрэгжүүлж байгаагийн улмаас зөрчлийг шалган тогтоох, хариуцлага хүлээлгэх механизм, уялдаа холбоо хангалтгүй, удаашралтай байна. Тиймээс тухайн төрлийн зөрчлийг шуурхай илрүүлэх, хариуцлага хүлээлгэх зохион байгуулалт, хууль зүйн арга хэмжээг авах нь зүйтэй байна.

10. Татварын ерөнхий газар: (Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил)

Судалгааны хүрээнд УИХ-ын 2024 оны сонгуультай холбоотой шалган шийдвэрлэсэн зөрчлийн мэдээллийг ирүүлсэн болно. Татварын ерөнхий газрын улсын байцаагч ҮАГ-аас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж байна.

Хүснэгт 15: Татварын ерөнхий газрын улсын байцаагчаас шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан зөрчлийн мэдээлэл (УИХ 2024)

Зөрчлийн шинж	Нам	Нэр дэвшигч
Сонгуулийн зардлын данс бүртгүүлээгүй	5	181
Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн (хуульд заасан шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй)	4	60
Нийт	9	241

Хүснэгт 16: Татварын улсын байцаагчийн зөрчлийн шийдвэрлэлт (УИХ 2024)

Зөрчлийн шинж	Ажиллагаанд байгаа	Шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн төрөл	
			Хариуцлага ногдуулсан	Татгалзсан, хэрэгсэхгүй болгосон
Данс бүртгүүлээгүй зөрчил	-	186	36	150
Шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлээгүй, улсын орлого болгоогүй	20	44	6	38
Нийт	20	230	42	188

Дүн шинжилгээ: ҮАГ-ын хяналтаар 9 нам, 241 нэр дэвшигчтэй холбоотой зөрчилтэй нөхцөл тогтоогдсон нь сонгуулийн зардлын ил тод байдал, хяналт хангалтгүй байгаа ерөнхий нөхцөл байдлыг харуулж байна. Үүнээс зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд

нь нийт 230 тохиолдол шийдвэрлэснээс 42-т (18%) хариуцлага ногдуулж, 188-г (82%) хэрэгсэхгүй болгосон байна. Өмнөх хэсэгт буюу нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн хэсэгт дурдагдсан тайланг хүлээн авах болон зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүргийг 2 тусдаа байгууллага хэрэгжүүлж байгаагийн улмаас зөрчлийг шалган тогтоох, хариуцлага хүлээлгэх механизм, уялдаа холбоо хангалтгүй, удаашралтай байгаа нөхцөл байдал мөн адил ажиглагдаж байна.


11. Монополын эсрэг газар⁸¹: (Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчил)

Хүснэгт 17: Монополын эсрэг газрын 2020–2024 оны сонгуулиудад цахим орчинд илрүүлсэн зөрчил, гомдол, шийдвэрлэлт

Сонгууль	Цахим орчинд илрүүлсэн зөрчил (тоо)	Улсын байцаагчийн дүгнэлт (тоо)	Өргөдөл, гомдол (тоо)	Гомдлын шийдвэрлэлт
АНСДИТХС-2020	36	36	5	Харьяаллын дагуу шилжүүлсэн – 3, Хүлээн авахаас татгалзсан – 1, Зөрчлийн тухай бүрд нь арилгуулсан – 1
АНСДИТХС-2024	79	79	3	Харьяаллын дагуу шилжүүлсэн – 3
МУИХС-2020	114	89	24	Зөрчлийн хэрэг нээсэн – 6 (бүгд хэрэгсэхгүй), Харьяаллын дагуу шилжүүлсэн – 17, Зөрчлийн тухай бүрд нь арилгуулсан – 1
МУИХС-2024	147	147	8	Зөрчлийн хэрэг нээсэн – 2, Харьяаллын дагуу шилжүүлсэн – 5, Хүлээн авахаас татгалзсан – 1
МУЕС-2021	520	539	0	Зөрчил илрүүлж, шилжүүлсэн – 1

⁸¹ Монополын эсрэг газрын 2025 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 01/1800 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

Диаграмм 6: Монополын эсрэг газрын 2020–2024 оны сонгуулиудын өргөдөл гомдлын шийдвэрлэлт



Хүснэгт 18: Монополын эсрэг байгууллага өөрөө илрүүлсэн болон дүгнэлт гаргасан үзүүлэлт

Сонгууль	Илрүүлсэн зөрчил (тоо)	Улсын байцаагчийн дүгнэлт (тоо)	Илрүүлсэнд эзлэх хувь (%)
АНСДИТХС-2020	36	36	100%
АНСДИТХС-2024	79	79	100%
МУИХС-2020	114	89	78%
МУИХС-2024	147	147	100%
МУЕС-2021	520	539	
Нийт	896	890	99.3%

Дүн шинжилгээ: Нийт сонгуулийн хэмжээнд 28 гомдлыг шилжүүлж шийдвэрлэсэн нь нийт гомдлын шийдвэрлэлтийн 63 хувийг эзэлж байгаа нь анхаарах татах гол үзүүлэлт байна. Өөрөөр хэлбэл, Монополын эсрэг байгууллагын шалган шийдвэрлэх гомдлын талаарх хууль зүйн ойлголт хангалтгүй байх ба харьяаллын төөрөгдөл, үүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх ажиллагаа удаашрах үзэгдэл түгээмэл байгааг харуулж байна.

УИХ-ын 2020 оны сонгуульд зургаа, 2024 онд хоёр гомдолд зөрчлийн хэрэг нээсэн боловч бүгд хэрэгсэхгүй болсон эсвэл шийдэгдээгүй байна.

Монополын эсрэг газар нь иргэдийн өргөдөл гомдлоос илүүтэй өөрсдийн хяналтаар зөрчлүүдийг давамгайл илрүүлдэг гэж үзэхээр байна. Ингэхдээ нийт 896 зөрчил илрүүлснээс 890 дээр нь улсын байцаагч дүгнэлт гаргасан байна. Үндсэндээ иргэдээс гаргасан өргөдөл гомдлын дагуу хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байхгүй, бүгд байгууллагын илрүүлсэн зөрчил байгаа нь иргэд, байгууллагуудаас Монополын эсрэг газарт гаргах гомдол, харьяалан шийдвэрлэх зөрчлийн талаарх ойлголт сул байгааг илтгэж байна.

Сонгуулийн маргааныг цэц хянан шийдвэрлэж буй нөхцөл байдал:

Монгол Улсын сонгуулийн хууль нь ээлжит сонгууль бүрд шинэчлэгдэж, өөрчлөгдөж ирсэнтэй холбоотойгоор тухайн сонгуулийн үйл ажиллагааг зохицуулах хуульд Үндсэн хуулийн зөрчил байгаа тохиолдолд өргөдөл, мэдээлэл гаргах, цэц хянан шийдвэрлэх боломж, хугацаа олгогдохгүй эсхүл зарим тохиолдолд зориуд сонгуулийн дараа шийдвэрлэж байж болзошгүй нөхцөл байдлууд цөөнгүй гарч байв.⁸² Тиймээс Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглосон зохицуулалт нь Үндсэн хуулийн зөрчил үүсэхээс сэргийлэх, үүссэн тохиолдолд арилгах боломжит хугацааг олгосноороо ач холбогдолтой байна.

Сонгуулийн ерөнхий хорооны сонгуулийн дүнг өргөн барьсан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн талаарх маргаан ховор тохиолдох⁸³ учир яг одоогийн хууль зүйн орчинд ҮХЦ сонгуулийн маргаан

⁸² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430499735542> - тайланг сурталчилгаанд тооцохгүй <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355750052221> - бие даан нэр дэвшигч 801 иргэний гарын үсгийг зуруулах гэх мэт

⁸³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9450> - СЕХ-оос сонгуулийн дүнг УИХ-д өргөн барьсан шийдвэрийн Д.Арвин гишүүнд холбогдох хэсэгт гаргасан мэдээлэл

шийдвэрлэх ажиллагаанд маш бага оролцоотой гэж дүгнэж болно. Гэвч сонгуулийн хууль тогтоомжийн зохицуулалт Үндсэн хууль зөрчсөн эсэх мэдээллээр дамжуулан сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд Үндсэн хуулийн цэцийн хяналт идэвхтэй хэрэгжсэн хэвээр байна.

ГУРАВ. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕССЫН САЙН ТУРШЛАГА

Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчилд хамаарах хариуцлагыг нэг мөр ойлгогдохоор хуульчлах, цаашлаад хариуцлага ногдуулах, маргааныг шийдвэрлэх процесс бүгдэд тэгш, шударга байх нөхцөлийг хууль тогтоомжоор хангасан байх нь чухал гэж үздэг.⁸⁴ Эдгээрээс гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх процесс, эрх бүхий байгууллагыг зааглаж заагаагүй, хууль тогтоомжийн зохицуулалт нь тодорхойгүй, ойлгомжгүйгээс нэг мөр дагаж мөрдөхөд хүндрэлтэй, мөн маргаан шийдвэрлэх байгууллага дотооддоо сургалт дутуу явуулснаас маргааныг үр дүнтэй шийдвэрлэж чадахгүйд хүрч байгаа тул холбогдох хууль тогтоомжийг сайжруулах шаардлага үүсэж байгаа талаар олон улсын сонгуулийн ажиглагчид онцолжээ.⁸⁵

Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаа нь сонгуулийн эрх бүхий этгээдийн шийдвэрт холбогдуулан гаргасан гомдолд, эсхүл сонгуульд нэр дэвшигч, намын үйлдэл, үйл ажиллагаа хууль зөрчсөн гэх гомдолд үндэслэнэ.

Зөрчилд холбогдох гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах эрх нь зөвхөн нэр дэвшигч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хязгаарлагдахгүй, саналаа өгч буй

⁸⁴ International Institute for Democracy and Electoral Assistance, International Electoral Standards Guidelines for reviewing the legal framework of elections, 2002, pp. 57

⁸⁵ Michael Krennerich, Report on Electoral Law and Electoral Administration in Europe, 2020, pp. 40

сонгогчид нээлттэй байх нь зүйтэй. Тиймээс улс орнууд сонгуулийн маргааныг ил тод, нээлттэй, шударга, үр дүнтэй шийдвэрлэх боломжит механизмуудыг хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, баруун Европын ихэнх улсуудад сонгуулийн эрх бүхий этгээдийн шийдвэрт холбогдуулан гаргасан гомдлыг хуульд заасан тусгай журмаар захиргааны байгууллага болон шүүхээр хянан шийдвэрлэдэг. Харин төв болон зүүн Европын ихэнх улсуудад сонгуультай холбогдох гомдлыг албан ёсны хараат бус сонгуулийн хороо болон ердийн шүүхүүд харьяалан шийдвэрлэхээр хуульчилсан. Европоос гадна, цөөн улсууд сонгуулийн маргааныг тухайлан шийдэх сонгуулийн шүүхийг байгуулах зохицуулалттай байна. Жишээлбэл, Их Британид сонгуулийн маргаан гарах тохиолдолд тусгай шүүх байгуулагддаг. Эдгээрээс тухайлсан туршлагыг “шилдэг” нь гэж онцлох боломжгүй боловч, сонгуулийн захиргааны байгууллагын гомдол шийдвэрлэх ажиллагааг шүүхээр шийдвэрлэхээс илүү богино хугацаанд, сонгогчдод илүү нээлттэй хэрэгжүүлж байна. Маргааныг эцэслэн шийдвэрлэх эрх хэмжээг захиргааны байгууллага бус шүүх хэрэгжүүлэх нь зүй ёсных бөгөөд үндсэн хуулиар хамгаалагдсан эрхүүд болон сонгуулийн үр дүн хүчинтэй эсэхэд хамаарах маргааныг заавал шүүхээр хянан шийдвэрлэх шаардлагатай юм.⁸⁶

Зөрчлийн шинж, хамрах хүрээ, үр дагавар зэргээс хамаарч сонгуулийн үр дүнг хүчингүй болгох эрх хэмжээг гомдол шийдвэрлэх байгууллагад олгох нь зүйтэй.⁸⁷

Сонгуулийн хуулийн зөрчлийг шалгах, хариуцлага хүлээлгэх, гомдол шийдвэрлэх ажиллагаа шударга, хурдан байх зэрэг нь чөлөөт бөгөөд шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтүүдэд багтдаг.⁸⁸

Дээрхээс товч дүгнэвэл, сонгуулийн гомдлыг шийдвэрлэх процесс үр дүнтэй байх эсэх нь хуулийн зохицуулалт тодорхой, ойлгомжтой байхаас шууд хамаарч байна. Тодруулбал, гомдлын төрөл, ямар гомдлыг хэн, ямар байгууллага эсхүл шүүхэд гаргах,

⁸⁶ Michael Krennerich, Report on Electoral Law and Electoral Administration in Europe, 2020, pp. 39

⁸⁷ Ibid.

⁸⁸ Michael Krennerich, Free and fair elections?, 2021, pp. 22

гомдол шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэг гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах журам, эцсийн шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн хангах зэрэг нь төөрөгдөл үүсгэхгүй тодорхой байх шаардлагатай. Гомдлын төрлөөс хамаарч шийдвэрлэх субъект нь захиргааны байгууллага, ердийн шүүх, эсхүл тусгайлсан шүүх байх ба бусад төрлийн хэрэг, маргаан, гомдлоос “сонгуулийн” гомдлын шийдвэрийг ялгаж, ил тод, нээлттэй мэдээлэх, хэрэгжилтийн тайланг цаг тухай бүр гаргадаг байх нь хууль тогтоомжийг цаашид сайжруулахад чухал хувь нэмэртэй юм.

Иймд харьцуулан судалсан улс орнуудын хувьд сонгуулийн гомдлыг шийдвэрлэх зохицуулалтын агуулга, ажиллагааны туршлагыг дараах агуулгаар авч үзэв.

3.1. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох олон улсын туршлага ба харьцуулалт: Мексик, Бүгд Найрамдах Солонгос, Эстони, АНУ (Калифорни)

Сонгогчдын нэрийн жагсаалтад холбогдох гомдол шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой маргааныг сонгуулийн сүүлийн өдөр хүртэл авч шийдвэрлэх нь иргэдийн сонгох эрхийн хэрэгжилтэд ач холбогдолтой гэж үздэг.⁸⁹ Гэхдээ улс орнууд санал өгөх болон санал тоолохтой холбогдох нэн яаралтай асуудлыг шийдвэрлэхэд анхаарал, цаг хугацаа, нөөц бололцоогоо зарцуулах зорилгоор⁹⁰ уг хугацааг санал авах өдрөөс өмнө тодорхой хугацаанд шийдвэрлэхээр зааж хязгаарладаг практик түгээмэл байна.

Тухайлбал, Монгол Улсад сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, буруу бүртгэгдсэн талаарх гомдлыг сонгогч өөрөө болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс бичгээр эсвэл цахимаар итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл

⁸⁹ European Commission for Democracy through Law (Venice Commission), Report on Election Dispute Resolution, Opinion No. 913/2018, (2020), p. 24, para. 88.

⁹⁰ Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа - Цуврал 6 (2022), 275 дахь тал.

улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргах эрхтэй.⁹¹ Гомдлыг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө бүрэн шийдвэрлэж, өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтийг бүртгэсэн байхаар зохицуулжээ.⁹² МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн нэлээд хувийг 60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон шалтгаанаар түр хасав нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн иргэдийн гомдол, мэдээлэл эзэлжээ. Агуулгын хувьд сүүлийн 5-10 жилийн хугацаанд гадаад улсад зорчоогүй, гадаад улсад зорчоод эргэж хилээр орж ирсэн, зарим иргэн хилээр огт зорчоогүй байхад нэмэлт тэмдэглэгээ хийсэн тухай гомдол, мэдээлэл гаргажээ.⁹³

⁹¹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 23 дугаар зүйлийн 23.1

⁹² Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 23 дугаар зүйлийн 23.2

⁹³ Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/3629 дугаар албан бичиг

Харьцуулсан судалгаанаас БНСУ-д⁹⁴ сонгогчийн нэрсийн жагсаалтад ороогүй, алдаатай бүртгэгдсэн, эрхгүй байхад бүртгэгдсэн талаарх гомдлыг сонгуулийн хороо хүлээн авч, үндэслэлтэй тохиолдолд нэн даруй засах, гомдлыг хангаагүй шийдвэрийг гомдол гаргагч хүлээн авсан бол дараагийн өдөрт нь багтаан шийдвэрт гомдол гаргаж, санал хураах өдрөөс 12 хоногийн өмнө сонгогчийн нэрийн жагсаалтыг эцэслэхээр хуульчилсан байна. Мексик Улсад⁹⁵ гомдлыг гаргаж буй субъект (гадаадад оршин суугч иргэн, иргэн, улс төрийн нам), гомдлын агуулгаас хамаарч сонгогчдын бүртгэлийн газар эсвэл сонгуулийн шүүх хүлээж авах бөгөөд сонгогчдын бүртгэлийн газрын шийдвэр гарснаас нь хойш 3 хоногийн дотор шүүхэд давж заалдах эрхтэй. Харин Эстони Улсад⁹⁶ сонгогч өөрийн мэдээллийг алдаатай гэж үзсэн тохиолдолд алдааг засуулах гомдлоо харьяа санал өгөх дүүргийн хороонд гаргах ба уг гомдлыг орон нутгийн захиргаа эсхүл хотын тамгын газар руу шилжүүлэх ба гомдлыг нэн даруй шийдвэрлэхээр

⁹⁴ Public Official Election Act. Article 41 (Objection and Decision) (1) An eligible voter may, upon finding an omitted or misspelled entry or an ineligible voter in the official list of eligible voters, file an objection orally or in writing with the head of the relevant Gu/Si/Gun during the inspection period.

⁹⁵ General Law on Electoral Institutions and Procedures (2024), art. 149(1) “The pertinent observations that citizens make regarding the nominal lists of voters will be communicated by the district boards to the Executive Directorate of the Federal Registry of Voters for the appropriate purposes.”; art. 150(1) “Political parties, in accordance with the provisions of paragraph 2 of article 148 of this Law, may submit to the Executive Directorate of the Federal Registry of Voters their observations on citizens improperly registered or excluded from the nominal lists, within a period of twenty calendar days from February 25 of each of the two years prior to the holding of the elections.” 150(4) “Political parties may challenge the report referred to in the preceding paragraph before the Electoral Tribunal. The challenge filed must demonstrate that the observations referred to in paragraph 1 of this article were presented in a timely manner, indicating specific and individualized facts and cases, which must be included in the observations originally formulated. If these requirements are not met, regardless of any other requirements established by the relevant law, the case will be dismissed as clearly inadmissible. The challenge must be filed before the General Council within three days following the day on which the report is made known to the political parties.”

⁹⁶ Riigikogu Election Act (2024), art. 24(1) “Where a voter finds that the data entered in the list of voters concerning themselves contain an error, they submit an application for correction of the error to the voting district committee which promptly forwards it to the rural municipality or city secretary.”

хуульчилсан. Эдгээр захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрт гаргасан гомдлыг захиргааны шүүх ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэж,⁹⁷ шийдвэрт үндэслэн нэн даруй мэдээллийг засах зохицуулалттай байна.

Дээрхээс дүгнэвэл, нэрсийн жагсаалттай холбоотой гомдлыг эцэслэн шийдвэрлэх эрхийг захиргааны байгууллага эсвэл шүүх хэрэгжүүлж байна. Гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг шийдвэрлэх эрх бүхий этгээдээс үл хамаарч ажлын эсвэл хуанлийн 3 хоног байхаар тодорхой хуульчилсан байх ба гомдол үндэслэлтэй тохиолдолд мэдээлэлд өөрчлөлт оруулах хугацааг “нэн даруй” гэж тодорхойлсон нь аль болох богино хугацааг баримталж буйг харуулж байна.

Нэр дэвшигч, улс төрийн намын бүртгэлд холбогдох гомдол шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт

Нэр дэвшигчийг оройтож бүртгэх нь түүний сонгуулийн сурталчилгааны хугацааг багасгах тул гомдол гаргах болон шийдвэрлэх хугацаа аль болох богино байх ёстой.⁹⁸ Мексик зэрэг улсууд шиг, нийгмийн олон бүлгээс сонгуульд нэр дэвших боломжийг дэмжих түр тусгай арга хэмжээг хуулиар тодорхойлох боломжтой.⁹⁹

Монгол Улсын хувьд улс төрийн нам, эвсэл¹⁰⁰ болон нэр дэвшигчийг¹⁰¹ бүртгэх, бүртгэхээс татгалзах шийдвэрийг Сонгуулийн

⁹⁷ Riigikogu Election Act (2024), art. 25(6) “The administrative court has to review the complaint and make a judgment within three working days after the date of receipt of the complaint.”

⁹⁸ European Commission for Democracy through Law (Venice Commission), Report on Election Dispute Resolution, Opinion No. 913/2018, (2020), p. 23, para. 88.

⁹⁹ Мөн тэнд, 96 дахь тал.

¹⁰⁰ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2. Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана. 28.4. Энэ хуулийн 28.3-т заасан шаардлагыг хангаагүй нам, эвслийг бүртгэхээс татгалзана.

¹⁰¹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1. Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгоно. 32.11. Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.

ерөнхий хороо гаргадаг. Нэр дэвшигчийн бүртгэлийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө¹⁰², улс төрийн нам, эвслийг бүртгэх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байх тодорхой хугацааг хуульд тусгаагүй байна. Эдгээр Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох гомдол, маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэхээр хуульчилжээ.¹⁰³ Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт маргаж, гомдлыг шүүхээс хангаж шийдвэрлэсэн ч шийдвэрийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой заагаагүйгээс хэрэгжилт удааширч, нэр дэвшигчийн үнэмлэхээ хожуу авснаас шалтгаалж сонгуулийн сурталчилгаа хийж чадаагүй тохиолдол гарсан байна.¹⁰⁴

¹⁰² Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.11.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.

¹⁰³ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

¹⁰⁴ Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний 24 дэх илтгэл (2025), 93 дахь тал.

Тохиолдол 1.2 Шүүх хуралдаан 2024.06.19-ний өдөр болж, миний нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр мөн өдөртөө бичгээр гарсан. СЕХ 2024.06.21-ний өдөр хуралдаад намайг бүртгэх шийдвэр гаргасан ч надад шийдвэр, үнэмлэхийг өгөхгүй байсан. СЕХ-той холбогдоход “гарын үсэг дутуу, дарга хуралтай байна” гэх зэргээр нэг даргаас хамааралтай мэт хариу өгч байсан. Би СЕХ-ны үүдэнд хүлээж байгаад 2024.06.24-ний өдрийн ажлын цаг дуусаж байхад буюу 18:00 цагийн үед нэр дэвшигчийн үнэмлэхээ авсан. Сурталчилгаа явуулж чадаагүй. (Үндэсний эвслээс жагсаалтаар нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Харьцуулсан судалгаанаас үзвэл, Мексик,¹⁰⁵ Эстони¹⁰⁶ улсуудад сонгуулийн хорооны шийдвэрт хуанлийн 3-4 хоногийн дотор сонгуулийн шүүх, улсын дээд шүүхэд гомдол гаргах, шүүхээс хугацааны хувьд даруй шийдвэрлэх зарчмыг баримтлах, ажлын 7 хоногоос¹⁰⁷ хэтрүүлэхгүй шийдвэрлэхээр зохицуулжээ. БНСУ¹⁰⁸ нэр дэвшигчийн бүртгэл хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор нэр дэвшигч, нэр дэвшүүлсэн нам гомдол гаргах эрхтэй ба улсын дээд шүүхээс яаралтай шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх хугацаа нь гомдлыг хүлээн авснаас хойш 180 хоногоос хэтрэхгүй¹⁰⁹ байхаар хуульчилжээ.

Мөн маргааныг шийдвэрлэж буй шатлалын хувьд сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд холбогдох гомдлыг

¹⁰⁵ General Law of the System of Means of Appeal in Electoral Matters (2023), art. 8(1) “The means of appeal provided for in this law must be submitted within four days from the day following the day on which the contested act or resolution is known, or has been notified in accordance with the applicable law, except for the exceptions expressly provided for in this ordinance.”

¹⁰⁶ Constitutional Review Court Procedure Act (2020), art. 38(1) “A complaint against an operation of the election’s organiser or an appeal against a decision or complaint against an operation of the electoral committee may be filed with the Supreme Court after the case has been disposed of by the National Electoral Committee. The complaint or appeal is filed with the Supreme Court through the National Electoral Committee within three days following communication of the Committee’s decision or performance of the operation by the Committee.”

¹⁰⁷ Constitutional Review Court Procedure Act (2020), art. 44(1) “Having received a complaint against an operation of the election’s organiser – or appeal against a decision, or complaint against an operation, of the electoral committee – the Court disposes of it without delay but not later than within seven business days following reception of the version that meets the requirements.”

¹⁰⁸ Public Official Election Act (2022), art. 223(1) “In a presidential election and a National Assembly election, a political party (limited to the party which has nominated a candidate) or candidate that has an objection to the validity of election may file a lawsuit with the Supreme Court against the elected candidate as a defendant for a reason that he or she falls under Article 52 (1) or (3) or 192 (1) through (3), and against the chairperson of the National Election Commission or the Speaker of the National Assembly who has decided on the elected candidate, in cases of the presidential election, and the chairperson of the constituency election commission concerned, in cases of a National Assembly election, as defendants respectively, for a reason that the decision made under Article 187 (1) and (2), 188 (1) through (4), 189, or 194 (4) is illegal, within 30 days from the date the elected candidate is decided.”

¹⁰⁹ Public Official Election Act (2022), Art. 225. Any petition or lawsuit on an election shall be decided or judged promptly in preference to other litigations, and in a lawsuit, the court which has accepted it shall settle it within 180 days after it is filed.

шийдвэрлэх процесс нь Мексик, Эстони, БНСУ-уудын хувьд давж заалдах шатыг оруулаад дээд тал нь 2 байгууллага шийдвэрлэж байгааг Хавсралт №8-аас харах боломжтой. Энэ нь маргааныг эцэслэн шийдвэрлэх хугацааг богино байхаар хуульчилсныг хэрэгжүүлэхэд илүү түлхэц болжээ.

Дээрхээс, нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн бүртгэлд холбогдох гомдол гаргах хугацаа, гомдлыг шийдвэрлэх, цаашлаад гомдол үндэслэлтэй гэж дүгнэсэн шүүхийн эцсийн шийдвэрийг хэрэгжүүлэх хугацааг боломжит богино хугацаагаар тогтоож хуульчлах нь сонгуулийн сурталчилгаанд эрх тэгш оролцох хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэх боломжтой юм.

Сонгуулийн сурталчилгааны зохицуулалтыг зөрчсөнтэй холбогдох гомдол шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт

Монгол Улсын хувьд сонгуулийн сурталчилгааны зохицуулалт зөрчсөнтэй холбогдох гомдлыг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч,¹¹⁰ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч,¹¹¹ харилцаа холбооны хяналтын улсын байцаагч¹¹² нар харьяалан шийдвэрлэх бөгөөд хугацааны хувьд ердийн журмыг баримтална.¹¹³ Тодруулбал, гомдол мэдээллийг хүлээн аваад ажлын 5 хоногт зөрчлийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэж, 14 хоногийн

¹¹⁰ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал, 6.8 цагдаагийн байгууллагын эрх алба хаагч Зөрчлийн тухай хуулийн ... 17.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9, 11, 12, 13, 15, 17, 20 дахь хэсэг ...

¹¹¹ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал, 6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ... 17.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг...

¹¹² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал, 6.50.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ... 17.1 дүгээр зүйлийн 14, 37, 38, 39 дэх хэсэгт заасан зөрчил;

¹¹³ Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, 5.Энэ бүлэгт заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг энэ хуулийн 6.8 дугаар зүйлд заасан хугацаанд явуулна.

хугацаанд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан 14 хоногоор, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж,¹¹⁴ шийтгэл ногдуулсан шийдвэрт гомдлыг шийдвэрлэсэн харьяаллаас хамаарч хяналтын улсын байцаагч нарын гаргасан шийдвэрт захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан дарааллын дагуу дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан эсхүл захиргааны хэргийн шүүхэд шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор,¹¹⁵ цагдаагийн эрх бүхий албан хаагчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор эрүүгийн хэргийн шүүхэд¹¹⁶ тус тус гомдол гаргаж шийдвэрлүүлнэ. Гомдлыг хүлээн авч, эцэслэн шалган шийдвэрлэх хугацаа нь дээрх хуулийн зохицуулалтын дагуу сунгалт хийхгүйгээр тооцоход захиргааны хэргийн шүүх бол хуанлийн 118 хоног, эрүүгийн хэргийн шүүх бол хуанлийн 72 хоног байна.

Монгол Улсад мөрдөж буй хуулийн зохицуулалтын дагуу сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаа нь санал хураах өдрөөс 1 хоногийн өмнө дуусаж, сонгуулийн үр дүнг санал хураах өдрөөс

¹¹⁴ Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйл. Зөрчлийн хэрэг бүртгэлийн хугацаа. 1. Эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна. 2. Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно.

¹¹⁵ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйл. Шийтгэл ногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гомдол гаргах, 2. Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31, 6.33, 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61, 6.63, 6.64, 6.65, 6.66 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

¹¹⁶ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйл. Шийтгэл ногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гомдол гаргах, 1. Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26, 6.29, 6.30, 6.32, 6.62, 6.63 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор эрүүгийн хэргийн шүүхэд гомдол гаргана.

хойш УИХ-ын сонгуулийн хувьд 15 хоногийн дотор,¹¹⁷ орон нутгийнх 7 хоногийн дотор,¹¹⁸ ерөнхийлөгчийнх 10 хоногийн дотор¹¹⁹ тус тус эцэслэгддэг. Тиймээс энэ хугацааны дотор зөрчлийн шинжтэй эсхүл эрүүгийн шинжтэй үйлдлийг шалган, гэм бурууг тогтоох нь цаг хугацааны хувьд боломжгүйн зэрэгцээ, гэм бурууг тогтоолоо ч санал хураалтын үр дүнг хэсэгчлэн эсхүл хүчингүй болгох үр дагавар үүсгэхгүй.

Сонгуулийн сурталчилгаанд холбогдох зохицуулалтыг зөрчсөн нь¹²⁰ нэр дэвшигчээс хасах хүртэлх “ноцтой” үр дагавартай байх боломжтой гэж хуулийн зохицуулалтаас илэрхий харж болох ч эдгээр ноцтой үр дагавар бүхий зөрчлийг гаргалаа ч сонгогдож чадаагүй бол торгуулийн хариуцлага хүлээх, сонгогдсон нэр дэвшигчийн хувьд ямар ч хариуцлага хүлээхгүй¹²¹, санал хураалтын дүнг хүчингүй болгох тусгайлсан зохицуулалт байхгүй. Энэ нь сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сулруулах, цаашлаад сонгуулийн

¹¹⁷ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурал болон Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

¹¹⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4. Тухайн шатны сонгуулийн хороо сонгуулийн дүн болон Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш долоо хоногийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

¹¹⁹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн болон Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг санал хураалт дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

¹²⁰ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 Нэр дэвшигч энэ хуулийн 35.3, 38.2, 48.1, 48.5.1, 48.5.2, 56.2-т заасныг зөрчсөн болох нь санал хураалтын дүн гаргахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

48.5. Сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 48.5.1. энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;

48.5.2. зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;

¹²¹ УИХ-ын гишүүнээр сонгогдон тангараг өргөсөн тохиолдолд Эрүүгийн хэргийн шүүхээс зөрчлийн ямар ч төрлийн арга хэмжээ авах хууль зүйн боломжгүй.

маргааныг тухайлан, богино хугацаанд шийддэг процессыг хуульчлах зайлшгүй шаардлага үүссэн байна.

Харьцуулсан судалгаанаас авч үзвэл,

Харьцуулсан судалгаа хийсэн улс орнуудад сонгуулийн сурталчилгаа явуулах хугацааг авч үзвэл, Мексик Улсад 90 хоног,¹²² БНСУ-д ерөнхийлөгчийн сонгуульд 23 хоног, үндэсний хурал болон орон нутгийн сонгуульд 14 хоног,¹²³ Эстони Улсад тухайлсан хугацаа хуульчлаагүй,¹²⁴ АНУ-н Калифорни мужид мөн тодорхой хугацааг хуульчлаагүй байна.¹²⁵

Мексик Улсад гомдлыг 24 цагийн дотор хүлээн авах эсэхийг шийдвэрлэж¹²⁶, хүлээн авсан тохиолдолд 48 цагийн дотор шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн түр хамгаалалтын арга хэмжээ авдаг.¹²⁷ Эстони Улсад гомдлыг тухайн зөрчлийг гарснаас хойш 3 хоногийн дотор хүлээн авч¹²⁸, 3-5 хоногийн дотор шийдвэрлэх¹²⁹, уг шийдвэр

¹²² Instituto Nacional Electoral, International Affairs Unit, Mexican Electoral Regime 2024 Federal and Local Elections, Page 33

¹²³ National Election Commission of the Republic of Korea, <https://www.nec.go.kr/site/eng/03/10301020000002020070601.jsp> сүүлд хандсан 2025.11.10

¹²⁴ European Parliamentary Research Service, Length of the election campaign and the electoral silence period in European Parliament elections, September 2023, page 2-3

¹²⁵ Election Code, Division 20. Election Campaigns, https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=ELEC&division=20.&title=&part=&chapter=5.&article=3. Сүүлд хандсан 2025.11.10

¹²⁶ General Law on Electoral Institutions and Procedures (2024), art. 471(6) “The Technical Unit for Electoral Litigation of the Executive Secretariat must accept or reject the complaint within no more than 24 hours of receiving it. In the event of rejection, it will notify the complainant of its decision by the most expeditious means available within twelve hours; such decision must be confirmed in writing and reported to the Specialized Commission of the Superior Chamber for its information.

¹²⁷ General Law on Electoral Institutions and Procedures (2024), art. 471(8) “If the Technical Unit for Electoral Litigation of the Executive Secretariat considers it necessary to adopt precautionary measures, it will propose them to the Complaints and Reports Commission within the same period of forty-eight hours, in the terms established in art. 467 of this Law. This decision may be challenged before the Superior Chamber of the Electoral Tribunal.”

¹²⁸ Riigikogu Election Act (2024), art. 72(1) “A complaint is to be filed with the National Electoral Committee within three days after: 1) the performance of the contested act; or 2) the review of a notice provided in art. 68 of this Act.”

¹²⁹ Riigikogu Election Act (2024), art. 72(2) “The National Electoral Committee has to review a complaint and adopt a resolution within five working days after receipt of the complaint.”

гарсан өдрөөс 3 хоногийн дотор дээд шүүхэд хандах¹³⁰ цаг хугацааны хувьд тусгай журмыг хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

АНУ-ын Калифорни мужид гомдлыг ердийн журмаар буюу холбогдох захиргааны байгууллага хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбоотой хэрэг нээх, харьяаллын дагуу өөр байгууллагад шилжүүлэх, үйлдэл хийхгүй байх, хугацаа сунгах болон эрх бүхий албан тушаалтны зохистой гэж үзсэн арга хэмжээ авах зэргээр авах гэж байгаа арга хэмжээнийхээ талаар гомдол гаргагчид мэдэгдэхээр зохицуулжээ.¹³¹

Дээрхээс богино хугацаанд сонгуулийн сурталчилгаанд холбогдох гомдлыг шийдвэрлэхээр хуульчилсан нь хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нэр дэвшигч, нам, эвслээс зөрчил гаргасан тохиолдолд эрх тэгш, бодитоор хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Санал хураалтын үр дүнг хүчингүй болгоход холбогдох гомдол шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт

Монгол Улсын хувьд санал хураалтыг нэгдүгээрт, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авснаас бусад тохиолдолд санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол; хоёрдугаарт, саналын хуудас бүхий зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, санал авах журам зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол¹³² гэх үндсэн 2 нөхцөлийг хуульчилсан бөгөөд

¹³⁰ Riigikogu Election Act (2024), art. 72№(3) “A complaint or appeal against an act of the elections manager or a resolution or act of the National Electoral Committee is filed with the Supreme Court via the National Electoral Committee within three days after the communication of the resolution or performance of the act of the National Electoral Committee.”

¹³¹ Regulations of the Fair Political Practices Commission, Title 2, Division 6, California Code of Regulations, § (b)(2).

¹³² Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд санал авсан, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авснаас бусад тохиолдолд

үүнд нэр дэвшигч эсхүл нам, эвслийн хууль зөрчсөн үйлдлээс шууд хамааралтайгаар бий болох нөхцөл хамаарахгүй. Эдгээр нөхцөл байдал үүссэн ч голчлон анхаарах хүчин зүйл нь "Сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөх" үр дагавар үүсгэсэн байх. Үүнийг хуульд санал хураалтын явцад гарсан зөрчил нь сонгуулийн дүнд илт нөлөөлөхүйц буюу сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигч ба түүний дараах нэр дэвшигчийн авсан саналын зөрүүтэй тэнцүү, эсхүл илүү байхыг ойлгоно гэж тодорхойлсон.¹³³ Мөн санал хураалтыг хүчингүйд тооцох эрхийг орон нутгийн сонгуулийн хувьд тухайн шатны сонгуулийн хороо, УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд Сонгуулийн ерөнхий хороо хэрэгжүүлэхээр хуульчилжээ. Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гомдол гаргах бол Үндсэн хуулийн цэц маргааныг харьяалан шийдвэрлэх, орон нутгийн сонгуулийн хувьд дээд шатны сонгуулийн хороо, захиргааны хэргийн шүүх¹³⁴ зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

Харьцуулсан судалгаанаас үзвэл, БНСУ-д сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотой нэхэмжлэл, гомдлыг шийдвэрлэхдээ сонгуулийн удирдах хороо, дээд шүүх болон давж заалдах шатны шүүхээс уг зөрчил нь сонгуулийн үр дүнд бодитой нөлөөлсөн гэж дүгнэвэл сонгуулийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь хүчингүй болгох эрхтэйгээр хуульчилсан.¹³⁵

санал авахаар зарласнаас өөр өдөр санал авсан нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол;

79.1.2.саналын хуудас бүхий зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, санал авах журам зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр бол.

¹³³ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсгийн "Тайлбар"

¹³⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2.Сонгуулийн хороо шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сонгуулийн хороодын шийдвэртэй холбогдуулан энэ хуулийн 14.10-т заасан дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргана. 81.3.Сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

¹³⁵ Public Official Election Act (2022), Art. 224 (Ruling Invalidity of Election) Even where there exists facts of violating the provisions concerning the election in an election litigation, the election management commission, the Supreme Court, or the appellate court, upon receiving a petition or complaint, shall decide or rule the whole or partial invalidation of the election, or the invalidation of the election win only when it is deemed to have had a substantial effect on the result of election.

Мексик Улсад i) сонгуулийн зардал нь хуульд зөвшөөрөгдсөн нийт дүнгийн таван хувиас хэтэрсэн; ii) хуульд зааснаас бусад тохиолдолд радио, телевизийн мэдээний тойм, нэвтрүүлгийн цагийг худалдаж авах буюу өөр аргаар олж авсан; iii) сонгуулийн сурталчилгаанд хууль бус эх үүсвэрээс санхүүжилт авсан, төрийн нөөцийг хүлээн авсан буюу ашигласан зөрчлийг санаатайгаар, ноцтой, тодорхой үр дагавар үүсгэж үйлдсэн тохиолдолд холбооны болон орон нутгийн сонгуулийг хүчингүй болгох¹³⁶ эрхийг сонгуулийн шүүх хэрэгжүүлнэ. Ийнхүү хүчингүй болгох шийдвэрийг сонгуулийн шүүх¹³⁷ гаргах эрхтэй.

Эстони Улсад хууль зөрчсөн нь сонгуулийн дүнд бодитоор нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байсан тохиолдолд дээд шүүхээс,¹³⁸

¹³⁶ Political Constitution of the United Mexican States (1917), art. 41(VI). ... In electoral matters, the filing of constitutional or legal remedies shall not produce suspensive effects on the challenged resolution or act.

The law shall establish the system of annulments of federal or local elections due to serious, willful, and decisive violations in the following cases:

a) When campaign expenses exceed by five percent the total amount authorized;
b) When information coverage or airtime in radio and television is purchased or acquired outside the cases provided by law;
c) When resources of illicit origin or public funds are received or used in campaigns. Such violations must be proven objectively and materially. It shall be presumed that the violations are decisive when the difference in votes obtained between the first and second place is less than five percent.

In the case of annulment of the election, an extraordinary election shall be called, in which the sanctioned person may not participate.

¹³⁷ Political Constitution of the United Mexican States (1917), art. 99 The Superior Chamber will be composed of seven Electoral Judges. The presidency of the Court will be renewed every two years on a rotating basis based on the number of votes each candidate receives in the respective election, with the presidency going to those with the highest number of votes.

The Electoral Tribunal is responsible for making a final and unassailable decision, in accordance with this Constitution and as provided by law, on:

(II) “Any challenges to the election of the President of the United Mexican States shall be resolved in a single instance by the Superior Chamber. The Superior and Regional Chambers of the Court may only declare an election null and void for reasons expressly established by law.”

¹³⁸ Constitutional Review Procedure Act (2020), art. 46(2) “Where the violation of the law materially affected or may have so affected voting results, the Supreme Court may declare invalid the voting results that were recorded for the polling station, electoral district, municipality, county or national territory, or in the election of the President of the Republic or of the Board of the Riigikogu, or declare the results of electronic voting invalid in their entirety or in part.”

эсхүл үндэсний сонгуулийн хорооноос¹³⁹ сонгуулийн үр дүнг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь хүчингүй болгоно. Сонгуулийн үр дүнд холбогдох гомдлыг Үндэсний сонгуулийн хороонд 3 хоногийн дотор гаргах ба гомдлыг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.¹⁴⁰ Уг шийдвэрийг 3 хоногийн дотор дээд шүүхэд давж заалдах¹⁴¹ ба шүүх ажлын 7 хоногийн дотор¹⁴² маргааныг хянан шийдвэрлэнэ.

Калифорни мужид сонгуулийн үр дүнг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг (а) сонгуулийн хэсгийн хороо буюу түүний аль нэг гишүүн нь хууль бус үйл ажиллагаа явуулсан; (б) тухайн албан тушаалд сонгогдсон гэж зарлагдсан хүн сонгуулийн үед уг албан тушаалд томилогдох эрхгүй байсан; (в) нэр дэвшигч эсхүл сонгогдсон этгээд нь сонгогч эсхүл сонгуулийн хорооны гишүүнд сонгуульд ялах зорилгоор авлига, шан харамж өгсөн, өгөхөөр санал болгосон болон сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг бусад гэмт хэрэг үйлдсэн, (г) саналыг хууль бусаар авсан; (д) сонгох эрхтэй иргэний эрхийг хууль бусаар хассан; сонгуулийн хэсгийн хороо сонгуулийг явуулахдаа эсхүл дүнг нэгтгэн тоолохдоо сонгуулийн үр дүнг өөрчлөхүйц хэмжээний

¹³⁹ Riigikogu Election Act (2024), art. 9(2)(3) “For the performance of their functions, the National Electoral Committee has the right: to declare the voting results in a voting district, rural municipality, city, electoral district or the state invalid, or to declare the electronic voting results invalid in whole or in part, and to hold a repeat vote where the violation significantly affected or could have significantly affected the voting results.”

¹⁴⁰ Riigikogu Election Act (2024), art. 72 “(1) A complaint is to be filed with the National Electoral Committee within three days after: 1) the performance of the contested act; or 2) the review of a notice provided in art. 68 of this Act. (2) The National Electoral Committee has to review a complaint and adopt a resolution within five working days after receipt of the complaint. (3) The National Electoral Committee adopts one of the following resolutions: 1) to refuse to grant the complaint; 2) to grant the complaint; 3) to grant the complaint in part.”

¹⁴¹ Riigikogu Election Act (2024), art. 72№(3) “A complaint or appeal against an act of the elections manager or a resolution or act of the National Electoral Committee is filed with the Supreme Court via the National Electoral Committee within three days after the communication of the resolution or performance of the act of the National Electoral Committee.”

¹⁴² Constitutional Review Procedure Act (2020), art. 44(1) “Having received a complaint against an operation of the election’s organiser – or appeal against a decision, or complaint against an operation, of the electoral committee – the Court disposes of it without delay but not later than within seven business days following reception of the version that meets the requirements.”

алдаа гаргасан; (e) санал тоолох программ эсхүл саналын дүнг нэгтгэх явцад алдаа гарсан гэсэн үндэслэлээр гаргана.¹⁴³ Саналын үр дүнг албан ёсоор мэдээлснээс хойш 5 хоногийн дотор мужийн шүүхэд эсэргүүцлээ гаргах боломжтой.¹⁴⁴

Дээрхээс дүгнэвэл, сонгууль буюу санал хураалтын үр дүнг хэсэгчлэн, бүхэлд нь хүчингүй болгох шийдвэрийг гомдол, нэхэмжлэл, эсэргүүцэлд үндэслэн сонгуулийн шүүх, дээд шүүх, мужийн шүүх хэрэгжүүлж байна. Зарим улсуудад сонгуулийн дүнд бодитоор нөлөөлсөн эсхүл нөлөөлж болзошгүй эсэх нь санал хураалтын үр дүнг хүчингүйд тооцох шийдвэр гаргах үндэслэл болж байгаа ч зөрчлийн төрөл нь зөвхөн “санал хураалтын үйл явц”-аар хязгаарлагдахгүй ердийн хууль тогтоомж, сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлүүд хамаарахаар өргөн хүрээнд хуульчилжээ.

Монгол Улсын хувьд санал хураалтын дүнг хүчингүй болгох эрх нь сонгуулийн хороодод хадгалагдаж байгаагийн зэрэгцээ зөрчлийн хувьд зөвхөн санал авах процессын алдааг хамааруулсан, нэр дэвшигч бусад төрлийн зөрчил гаргасан нь тогтоогдсон ч уг үндэслэлээр саналын үр дүнг хүчингүй болгох хууль зүйн зохицуулалтгүй байгааг анхаарах шаардлагатай.

¹⁴³ California Elections Code § 16100(a)–(g) (2024).

¹⁴⁴ Elections Code, Division 16, Chapter 5, Article 4. Contests Involving a Recount (16460-16467)... The affidavit shall be filed in the office of the clerk of the superior court within five days after the completion of the official canvass... https://leginfo.ca.gov/faces/codes_displaySection.xhtml Сүүлд хандсан: 2025.08.29

3.2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны хяналт, цахим систем хэрэгжүүлж буй олон улсын туршлага ба харьцуулалт: Мексик, Бүгд Найрамдах Солонгос, Эстони, АНУ (Калифорни)

Сонгуулийн маргаан шийдвэрлэлтийн системийг бий болгох нь дүрэм журмыг практикт үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэх, гомдол шийдвэрлэлтийн процессыг ил тод, хариуцлагатай, үр дүнтэй болгодог.¹⁴⁵ Тухайлбал, маргаан шийдвэрлэх платформтой байх нь шийдвэр гаргах эрх бүхий этгээдүүдэд гомдлыг хугацаанд нь хянан шийдвэрлэх, мэдээлэл хүргэх, нотлох баримт цуглуулж, баталгаажуулах, хэргийг шийдвэрлэх, бусад хэргийн шийдвэрлэлтийг харах, шийдвэрлэсэн болон татгалзсан гомдлын хураангуй харах боломж олгодог байна. Иймд сонгуулийн маргаан шийдвэрлэлтийн систем нь олон тооны гомдлыг богино хугацаанд шийдвэрлэдэг сонгуулийн маргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Цаашлаад сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны үр дүнтэй байдлыг гомдлын дагуу явуулсан ажиллагааны талаарх мэдээллийг бичгэн, үндэслэл бүхий шийдвэрийг оролцогч талуудад нээлттэй болгодог эсэх¹⁴⁶ асуултаар тодорхойлж байна. Иймд сонгуультай холбоотой гомдол, мэдээллийг шийдвэрлэх явц дахь оролцоо, ил тод байдлыг гадаад улс оронд хэрхэн зохицуулсныг дараах хэсэгт авч үзлээ.

АНУ-ын Калифорни мужийн Сонгуулийн тухай хуулийн §17-д¹⁴⁷ Төрийн нарийн бичгийн дарга нь сонгуулийн зохион байгуулалттай холбоотой гомдлыг шийдвэрлэхийн тулд 2002 оны Холбооны АНУ-ын Санал хураалтын тухай хуулийн (52 U.S.C. Sec. 21112) шаардлагын дагуу захиргааны гомдол гаргах журмыг тогтоож, дагаж мөрддөг. Энэ хүрээнд АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын веб сайтад сонгуулийн сонгогчдын гомдлын албан ёсны маягтыг байршуулж,

¹⁴⁵ Katherine Ellena, Chad Vickery and Lisa Reppell, Elections on Trial: The Effective Management of Election Disputes and Violations, 2018, page 15. https://www.ifes.org/sites/default/files/2022-09/IFES%20Managing%20Electoral%20Disputes%20and%20Violations_FINAL_0.pdf

¹⁴⁶ мөн тэнд, 42 дахь тал

¹⁴⁷ California Code, ELEC 17.

хүмүүст Сонгуулийн хуулийг зөрчсөн сэжигтэй үйлдэл, гэмт хэргийн талаар онлайнаар мэдээлэх боломжийг олгодог.¹⁴⁸ Үүний зэрэгцээ Улс төрийн шинэтгэлийн тухай хуулийн дагуу Улс төрийн шударга үйл ажиллагааны хороо (Fair Political Practices Commission - FPPC) цахим гомдлын системээр дамжуулан гомдол хүлээн авдаг бөгөөд энэ системээр гомдол гаргагчид мөрдөн байцаалтын явц, эцсийн шийдвэрийг мэдэгдэнэ.¹⁴⁹ Тодруулбал, FPPC-н дэргэдэх Хэрэгжилтийн хэлтэс гомдлыг шалгаад үндэслэлтэй бол захиргааны шийтгэл ногдуулах, торгох арга хэмжээ авах эсхүл гомдол гаргагч болон гомдолд холбогдсон этгээдэд хандсан анхааруулах (warning), зөвлөгөө өгөх (advisory), эсхүл гомдлоос татгалзсан (no action closure) захидлыг гаргадаг бөгөөд тэдгээрийг вэбсайтдаа нээлттэй байршуулж¹⁵⁰ байна.

Цахим систем нь сонгогчдод гомдол гаргах хялбар суваг, хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна гомдол гаргагчид гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээлэл авах, гомдлын хариуг хүлээн авах боломжийг олгож байна. Цаашлаад гомдлын дагуу авсан арга хэмжээнүүдийг вэбсайтдаа нээлттэй байршуулж байгаа нь олон нийтийн оролцоо, сонгуулийн зохион байгуулалтын ил тод байдлыг хангах нэг хэлбэр болж байна.

Эстони Улсын хувьд сонгуулийн зохион байгуулалтын явцад гарсан маргааныг Сонгуулийн тухай хууль болон Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасан гомдлыг хянан шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэнэ. Сонгуультай холбоотой гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэх ёстой тул сонгуулийн хуульд шүүхээс өмнөх шатанд гомдлыг тойргийн сонгуулийн хороо (анхан шатны) болон Үндэсний сонгуулийн хороогоор хянан шийдвэрлүүлэх журмыг заавал дагаж мөрдөхөөр заасан.¹⁵¹ Үндэсний сонгуулийн хорооны тогтоол, шийдвэр нь гомдол гаргагчийн эрхийг зөрчсөн гэж үзвэл Дээд шүүхэд¹⁵² шууд

¹⁴⁸ California Secretary of State, Election Voter Complaint. Accessed: 2025.08.08 <https://www.sos.ca.gov/elections/publications-and-resources/voter-complaint>

¹⁴⁹ Fair Political Practices Commission, California. File a Complaint. Accessed 2025.08.08 <https://www.fppc.ca.gov/enforcement/file-a-complaint.html>

¹⁵⁰ Enforcement Case Resolutions

¹⁵¹ Complaints | Elections in Estonia

¹⁵² Constitutional judgment 3-4-1-17-02 | The Estonian Supreme Court

гомдол гаргах бөгөөд гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны богино хугацааг хуульчилжээ.

Гомдол гаргагч тухайн шийдвэр, үйлдэл гарснаас хойш 3 хоногийн дотор сонгуулийн хороонд гомдлоо гаргах бөгөөд Сонгуулийн хороо ажлын 5 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Дээд шүүх маргааныг 7 хоногийн дотор шийдвэрлэдэг. Ийнхүү хянан шийдвэрлэх ажиллагаа нь нийтэд ил тод бөгөөд гомдол гаргагчид гомдлыг хэзээ хянах өдөр, газрыг мэдээлнэ.

Сонгогчдод хээл хахууль өгөх, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, залилан мэхлэх гэх мэт гэмт хэргийн шинжтэй гомдол гарсан тохиолдолд дүүргийн дүүргийн цагдаагийн байгууллага оролцож болно. Тойргийн сонгуулийн хороод Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэжиглэж байгаа тохиолдолд гомдлыг цагдаад шилжүүлж, үнэлгээ, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж болно.¹⁵³

Сонгуулийн гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоо нь ардчилсан сонгуулийн шударга байдлыг хангах үндсэн баталгаа юм. Энэ тогтолцоо нь сонгогчид, нэр дэвшигчид, улс төрийн намуудын эрх зөрчигдсөн тохиолдолд шударгаар шийдвэрлүүлэх боломжийг олгодог. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд сонгуулийн тогтолцоог хугацаандаа, хүртээмжтэй, үр дүнтэй байхыг шаарддаг бөгөөд Европын комиссын "Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын кодекс"-т¹⁵⁴ хараат бус байдал, ил тод байдал, эрх зүйн тодорхой байдлыг онцолсон байна. Энэ хүрээнд хүртээмжтэй, үр дүнтэй, ил тод байдлыг хангах зорилгоор Шри Ланка болон Энэтхэг улсууд сонгуулийн гомдол хүлээн авах, гомдол маргаан шийдвэрлэлтэд цахим системийг ашиглаж байгааг дараах хэсэгт авч үзлээ. Шри Ланка Улсад Сонгуулийн хороо нь шүүн таслах бүрэн эрхгүй буюу сонгуулийн зөрчил, хууль бус үйл ажиллагаа, залилан зэрэг нь шүүх, хууль сахиулах байгууллагын харьяалалд шийдвэрлэгддэг. Сонгуулийн хороо нь зөвхөн урьдчилан сэргийлэх

¹⁵³ https://www.inimoigustegiid.ee/en/themes/civic-participation/standing-for-election/restrictions/how-to-complain?utm_source=chatgpt.com

¹⁵⁴ Европын зөвлөл, Венецийн комисс. (2002). Code of Good Practice in Electoral Matters.

үүрэгтэй. 2015 болон 2019 оны сонгуулиудаар сонгуулийн хорооны дэргэд гомдлын төвүүдийг байгуулж, тэдгээр нь шүүхийн шинжтэй бус, харин зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэх механизмаар ажилласан. Тодруулбал, сонгуулийн хорооны www.elections.gov.lk вэбсайтаар дамжуулан сонгогчид, намуудын гомдлыг хүлээн авч, зуучлал хийх ба шаардлагатай тохиолдолд цагдаа, шүүхэд шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Улмаар сонгуулийн хороо чөлөөт, шударга сонгуулийг хангахын тулд Сонгуулийн маргаан шийдвэрлэх (Election Dispute Resolution - EDR) аппликейшныг олон нийтэд танилцуулсан. Хэдийгээр тус аппликейшны ашиглалтыг хуулиар тогтоож, зохицуулаагүй ч сонгуулийн хорооны бүрэн эрхийн хүрээнд ашиглаж байна. Үүнийг сонгуулийн асуудлыг шуурхай мэдээлэх, дуу хоолойгоо хүргэхээс гадна сонгуулийг ил тод явуулахын тулд иргэдийг чадавхжуулах арга¹⁵⁵ гэж сонгуулийн хороо онцолжээ.

Харин Энэтхэг Улс сонгуулийн гомдол шийдвэрлэх үйл явцдаа цахим системийг амжилттай суулгаж чадсан. Энэтхэгийн Сонгуулийн хороо нь Citizen Services нэртэй төвлөрсөн цахим платформыг ажиллуулж, сонгогчид гомдлоо цахимаар гаргах, сонгогчийн нэрийн жагсаалт, санал авах байр, сонгуулийн дүнтэй танилцах боломжтой болгосон. Энэхүү гомдлын систем нь СХ-ны албан ёсны цахим хуудас www.eci.gov.in -д байрладаг. 2014 оны сонгуулийн үеэр иргэд энэ системээр дамжуулан цахимаар гомдол гаргаж, сонгуулийн зөрчил болон холбогдох хууль зүйн шийдвэрийн талаарх мэдээлэлд олон нийт нэвтрэх боломжтой болсон.¹⁵⁶

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь ардчилсан сонгуулийн шударга, ил тод байдлыг хангах үндсэн баталгаа бөгөөд гомдол, маргааныг шуурхай, хүртээмжтэй, үр нөлөөтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг билээ.

Нэгдүгээрт, цахим систем бүхий маргаан шийдвэрлэх платформ нь гомдол гаргагчдад өөрийн дуу хоолойгоо хүргэх, шийдвэрлэлийн

¹⁵⁵ Election Commission EDR Mobile APP

¹⁵⁶ Open Election Data Initiative. (n.d.). Complaints and Disputes.

<https://openelectiondata.net/en/guide/key-categories/complaints-and-disputes/>

явцыг хянах, нотлох баримт хүргүүлэх, шийдвэр болон арга хэмжээний талаарх мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь сонгуулийн үйл явцыг ил тод, хариуцлагатай, олон нийтийн итгэлийг хамгаалахад чухал нөхцөл болдог.

Хоёрдугаарт, АНУ, Эстони, Энэтхэг, Шри Ланка зэрэг улс орнуудын туршлагаас харахад сонгуулийн гомдол шийдвэрлэх тогтолцоог цахимжуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, шүүхээс өмнөх шатны хяналтыг богино хугацаанд явуулах, эцсийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх нь маргааныг үр нөлөөтэй шийдвэрлэх боломж олгодог байна.

Гуравдугаарт, олон улсын эрх зүйн баримт бичиг, жишээлбэл Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Европын комиссын сонгуулийн асуудлаарх сайн туршлагын кодекс зэрэгт заасанчлан сонгуулийн гомдол шийдвэрлэлтийн систем нь хараат бус, ил тод, хүртээмжтэй, үр дүнтэй байх шаардлагыг хангах ёстой.

Дөрөвдүгээрт, цахим системийн хэрэглээ нь зөвхөн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх бус, урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдээллээр хангах, олон нийтийн хяналтыг бий болгох, төрийн байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Иймд сонгуулийн маргаан шийдвэрлэх цахим тогтолцоог бий болгож, эрх зүйн зохицуулалттай уялдуулан хөгжүүлэх нь зүй ёсны сонгууль явуулах, сонгуулийн үндсэн зарчмуудыг хангах, ардчилсан тогтолцооны үнэт зүйлсийг хангах оновчтой шийдэл болохыг дээрх туршлагууд харуулж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс сонгуулийн эрх, эрх чөлөөний суурь зарчмуудыг Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомждоо тусган баталгаажуулсан нь ардчиллын хөгжлийн нэгэн чухал ололт мөн боловч тэдгээрийн хэрэгжилт бодит амьдрал дээр бодитой, тогтвортой, бүх шатанд жигд хангагдахгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Сонгуулийн үеийн маргаан, гомдлыг шийдвэрлэх байгууллагын харьяаллыг хууль тогтоомжид тодорхой заасан боловч практик дээр энэ нь олон нийтэд ойлгомжгүй, байгууллагуудын хооронд өргөдөл гомдлын шилжүүлэлт ихтэй хэвээр байна. СЕХ-д ирсэн өргөдөл, гомдлын дөрөвний нэг орчим нь буруу харьяаллаар ирж, цагдаа болон бусад байгууллагад шилжүүлж буй нь маргаан шийдвэрлэх үйл явцыг удаашруулж, үр нөлөөг сулруулж байна. Энэ нь хууль, журмын талаарх иргэдийн ойлголт дутмаг байгаагийн зэрэгцээ холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэл, үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаагийн илрэл юм.

Сонгуулийн байгууллага болон сонгуулийн маргааныг шалган шийдвэрлэж буй төрийн байгууллага, албан тушаалтны хараат бус байдлыг хууль тогтоомжийн ерөнхий зарчмын хүрээнд баталгаажуулсан боловч зохион байгуулалт, институцийн түвшинд улс төрийн нөлөөллөөс ангид байх хууль зүйн баталгаа, арга механизм, зохицуулалтын орчин хангалттай биш байна.

Сонгогчдын бүртгэл, мэдээллийн үнэн зөв байдалд илэрч буй алдаа, доголдол нь сонгуулийн шударга байдалд ноцтой эрсдэл

дагуулдаг. Нэг хаягт олон зуун хүн бүртгэлтэй байх, гадаадад оршин суугаа иргэдийг түр хасах, сонгуулийн өмнөхөн бөөнөөр нь сэргээх зэрэг үзэгдэл нь сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой гомдол маргааны гол шалтгаан болж байна.

Эрүүгийн болон зөрчлийн шинжтэй гомдол маргааныг шийдвэрлэх тогтолцооны томоохон хэсэг буюу эрх бүхий байгууллагын төвлөрөл цагдаагийн байгууллагад шилжсэн хэдий ч эрүү, зөрчлийн хэрэг нээх, мөрдөн шалгах хувь буурсан, гомдлын тоо эрс өссөн зэрэг нь нотлох баримтыг цуглуулах, шуурхай шалган, шийдвэрлэх процессын чанар сул байгааг илтгэнэ. Нөгөө талаар Сонгуулийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын цаг хугацааны онцлогтой харьцуулахад энэ нь маргааныг сонгуулийн хугацаанд нь шийдвэрлэх боломжийг боомилж, шалган шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрлэлтийн үр нөлөө, ач холбогдлыг бууруулж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1-д “хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн” тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулах үндэслэл болох бөгөөд дээрх сонгуулийн зөрчлүүдийг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд илрүүлэх хууль зүйн болон бодит боломжгүй байгаа нь сонгуулийн зөрчлүүдийг бүрэн илрүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, зөрчил шалгах шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчлийг үр дүнтэй шалгаж шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхэд гомдлыг хурдан хугацаанд шийдвэрлэх нь ач холбогдолтой боловч ийнхүү шийдвэрлэхэд нэг талаар тухайлсан сонгуулийн шүүх (шүүхийн танхим)-ийн ажиллагаа, нөгөө талаар энгийн ойлгомжтой маргаан шийдвэрлэх бүтэц, тогтолцоо чухал үүрэгтэй байна.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улсад сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн орчны суурь зохицуулалт харьцангуй сайн хийгдсэн мэт боловч системийн түвшний хийдэл дутагдлууд

оршсоор байна. Тодруулбал, сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хууль болон олон улсын зарчмуудтай нийцүүлэх алхмууд хийгдсэн хэдий ч хэрэгжилт сул, зарим процесс ээдрээ төвөгтэй, процессын урсгал логик зөрчилтэй, сонгуулийн маргаан шийдвэрлэсэн шүүх, эрх бүхий байгууллагын зарим шийдвэр үр нөлөөгүй, институцийн хараат бус байдлын баталгаа хангалтгүй хэвээр байгаа нь нийт тогтолцооны үр ашигт байдлыг алдагдуулж байна. Сонгуулийн маргааныг шуурхай, үр нөлөөтэй шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, гомдол гаргах боломжийг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх процедурын тодорхой байдлыг хангах, хараат бус байдлыг институцийн түвшинд бэхжүүлэх шаардлагатай байна. Тиймээс цаашид хууль тогтоомж, маргаан шийдвэрлэх байгууллагын уялдаа холбоог сайжруулах, маргаан шийдвэрлэх журмыг энгийн, ойлгомжтой, тохиромжтой болгох, цахим систем нэвтрүүлэх, иргэдийн гомдол гаргах бололцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн байгууллагуудын хараат бус байдлыг бодитоор баталгаажуулах зэрэг арга хэмжээг бодлогын түвшинд нарийвчлан авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Сонгуулийн шударга, ил тод байдал нь ардчиллын суурь баталгаануудын нэг мөн. Манай улс цөөнгүй удаагийн сонгуулийн туршлага хуримтлуулсан ч маргааны шийдвэрлэлт, хариуцлагын хэрэгжилт, үр нөлөө, байгууллагуудын хараат бус байдал, мэдээллийн ил тод байдлын хувьд тогтолцооны түвшний сорилт байсаар байна. Энэ судалгаанд 2019–2025 онд үйлчилж буй хууль тогтоомж, институцийн практик, 2020, 2021, 2024 оны сонгуулийн үеийн тоон мэдээлэлд тулгуурлан хууль эрх зүйн орчин, байгууллагын зохион байгуулалт, маргаан шийдвэрлэх горим журам, бодит хэрэгжилтийг шинжилж, олон улсын хандлагатай харьцуулан судалсны үндсэн дээр дараах зөвлөмжийг боловсрууллаа.

- Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохын тулд юуны өмнө улс төрийн мэдрэг асуудлаар шийдвэр гаргахаас зайлсхийх хандлагыг халах шаардлагатай бөгөөд маргааныг шийдвэрлэх байгууллагуудын хууль зүйн баталгааг хангаж, хүлээлгэх хариуцлагыг тодорхой, үр дүнтэй болгох шаардлагатай байна. Энэ нь шийдвэр гаргалтын ил тод байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн эрх, эрх чөлөө, процессын хууль ёсны, шударга байдлыг хангах нөхцөл болно. Мөн энэ хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны хараат бус байдлыг хангах нь онцгой ач холбогдолтой бөгөөд гишүүдийг сонгон шалгаруулах үйл явцын ил тод, шударга байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

- Зарим төрлийн зөрчлүүдийн үр дагаврын ноцтой байдлаас нь хамааруулж, шаардлагатай тохиолдолд эрүүгийн хуульд тусгах боломжийг судлах нь зүйтэй. Энэ нь сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөний үр дагавар, хүлээх хариуцлагыг үл тоох, эсвэл санаатайгаар зөрчих үйлдлийг хязгаарлахад бодит нөлөө үзүүлнэ.
- Сонгуулийн хууль тогтоомжид нам, нэр дэвшигч нь сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн буюу ажилтан, менежер, шатар туслах, ухуулагч зэрэг этгээдүүдийн үйлдэл үйл ажиллагаанд хяналт тавих, үйлдлийн үр дагаврыг нам, нэр дэвшигч хариуцах агуулга бүхий зарчмын зохицуулалтыг тусгах замаар нам, нэр дэвшигчийн хууль зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Нэр дэвшигчээс хасах үр дагавартай зөрчлүүдийг санал хураалтаас өмнө шуурхай шийдвэрлэх, сонгуулийн үр дүнгээс хойш тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэл, боломжийг бүрдүүлэх нь зайлшгүй бөгөөд үүний зэрэгцээ ийм төрлийн зөрчлийг шийдвэрлэх хүрээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага бий. Ийнхүү нэр дэвшигчийн эрх зүйн байдалд тодорхой үр нөлөө бүхий шийдвэрийг цаг хугацаанд нь гаргах нь сонгогчдын эрхийг хамгаалах чухал баталгаа болно.
- УИХ-ын тухай хуульд тусгагдсан УИХ-ын гишүүнд эрүүгийн хэргийн шүүхээс зөрчлийн хэрэгт хариуцлага хүлээлгэхгүй гэх зохицуулалтыг хасах нь зүйтэй бөгөөд энэхүү зохицуулалтын нөлөөгөөр сонгуулийн хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн зөрчил гаргасан УИХ-ын гишүүнд хууль зүйн ямар ч хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл үүсэж байна.
- УИХ-ын гишүүн сонгуулийн үйл ажиллагааны явцад хууль тогтоомжийн ноцтой зөрчил (нэр дэвшигчээс хасах үр дагавар бүхий зөрчил) гаргасан болохыг шүүх тогтоосон бол Үндсэн хуулийн цэц эсхүл СЕХ-оос гишүүнийг эгүүлэн татах асуудлыг УИХ-д оруулах зэрэг хариуцлагын бодит механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн хууль зүйн орчныг бий болгох;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд сонгуулийн үеийн гэмт хэрэг, зөрчлийг шуурхай шийдвэрлэх, нэр дэвшигчийн хууль зүйн баталгааг хангах зэрэг тулгамдсан асуудлуудаар процессын тусгай зохицуулалтыг тусгах нь үр дүнтэй. Ингэснээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, чанар сайжирч, сонгуулийн үйл явцад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ. Илүү тодруулбал, сонгуулийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой материаллаг хууль тогтоомжийн тусгай зохицуулалтууд нь процессын явцад хэрэгжих баталгаа болж чадахгүй байна.
- Сонгуулийн үеийн хэрэг маргааны онцлог, шуурхай шийдвэрлэх шаардлага зэргийг харгалзан шүүх дотооддоо сонгуулийн маргааныг (зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй) хянан шийдвэрлэх мэргэшсэн шүүгчдийг бэлтгэн тодорхой хугацаанд тусгайлан журмаар ажиллуулах хууль зүйн боломжийг бүрдүүлэх асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.
- Мөн цаашид сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны хугацааг богиносгох хүрээнд хэрэг маргааныг хянан шалгаж, шийдвэрлэж буй шатлалыг богиносгох боломжит хувилбаруудыг эрэлхийлэх нь зүйтэй байна.
- Хүлээн авахаас татгалзсан болон хэрэгсэхгүй болгосон (ялангуяа цагдаагийн байгууллагын) гомдол, хэргүүдэд тогтмол мониторинг хийх замаар шийдвэрлэлтэд ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох боломжтой. Үүнтэй уялдуулан Сонгуулийн ерөнхий хороо нь өөрийн хяналт тавих чиг үүргийн хүрээнд гомдол маргааныг нэгтгэн бүртгэх, хянах нэгдсэн цахим платформ хөгжүүлж, түүний үйл ажиллагааг хариуцах боломжтой.
- Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн, иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд гомдол,

мэдээллийг хаана гаргах талаар сонгогчдыг мэдээллээр хангах үйл ажиллагааг сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж буй сонгуулийн төв байгууллагын хувьд өргөн хүрээнд, тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

- Сонгуулийн зөрчилтэй холбоотой тайлан, мэдээллийг Төрийн аудитын байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдэд цаг алдалгүй хүргүүлэх нь хууль зүйн үндэслэлийг тодорхойлох нь чухал бөгөөд ингэснээр зөрчлийг шуурхай илрүүлж, цаг тухайд нь арга хэмжээ авах боломж нэмэгдэнэ. Мөн шалган шийдвэрлэх харьяаллын шинжилгээг нарийвчлан хийж зөрчил шалгах эрх бүхий этгээд, байгууллагуудын үйл ажиллагааны хүрээ, чиг үүрэгтэй уялдуулан оновчтой тогтоох шаардлагатай байна.
- Сонгуулийн үеэр цахим хаяг хаах, хязгаарлах, контент устгах ажиллагааг одоогоор СЕХ-ны журмаар зохицуулж буй нь хүний үндсэн эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байгаа тул энэ асуудлыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн шаардлагуудад нийцүүлэн зөвхөн хуулиар зохицуулах нь зүйтэй.
- Үндсэн хуулийн цэцэд гаргасан сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой өргөдөл, мэдээллийг сонгуулиас өмнө заавал шийдвэрлэх зохицуулалт бий болгох нь зохистой. Ингэснээр маргаан сунжрахгүй, сонгуулийн дүнгийн хууль ёсны байдалд эргэлзээ үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой.
- Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааны харьяаллыг өргөтгөн зөвхөн УИХ-ын сонгуулийн дүнг өргөн барьсан шийдвэрээс гадна сонгуулийн үйл ажиллагааны явцад гарсан сонгуулийн төв байгууллагын шийдвэр сонгуулийн зарчмуудыг зөрчсөн эсэх талаар маргаан үүсгэх улмаар Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд сонгуулийг хүчингүйд тооцох зохицуулалтыг бий болгох;

- Иргэний нийгмийн байгууллагууд, ажиглагчдын сонгуулийн үйл явц дахь оролцоог хуулиар тодорхой болгож, хяналтын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Санал хураалтын дүнг хүчингүй болгох үндэслэлийг зөвхөн сонгуулийн санал процессын алдаагаар хязгаарлахгүй, сонгуулийн хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн нэр дэвшигчийн үйлдэл, сонгуультай холбогдуулан сонгуульд ялах зорилгоор бусад төрлийн хуулийг зөрчсөн зөрчил хамаарахаар өргөжүүлэх. Үр дүнд нь санал хураалтыг хүчингүй болгох эрхийг зөвхөн сонгуулийн хороод биш, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах замаар хэрэгжүүлэх нөхцөлийг хуульчлах нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ

- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
- НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж, №25
- Олон улсын Парламентын холбоо, Чөлөөт шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтийн тунхаг
- Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Хүний эрхийн бага хурлын Копенгагений уулзалтын баримт бичиг, 1990
- Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Москвагийн баримт бичиг, 1991
- Хүний эрхийн тухай Европын конвенц
- НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№25, §25, 1996)

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 1992
- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2005
- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2011
- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2019

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2020
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020
- Сонгуулийн тухай хууль, 2015
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2006
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016
- Зөрчлийн тухай хууль, 2017
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017
- Эрүүгийн хууль, 2015
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015
- Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журам, 2021
- Сонгууль ажиглах нийтлэг журам, 2021
- Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам, 2021
- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам, 2024
- Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам, 2024
- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам, 2024

Монгол хэл дээрх эх сурвалж:

- IDEA, Зүй ёсны сонгууль: Ардчилал, Сонгуульд туслах олон улсын хүрээлэнгийн гарын авлага, 2010
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 1 дүгээр тогтоол
- Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын

Хөгжлийн хөтөлбөр, Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь, 2014

- 2019 оны Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн танилцуулга
- АИХЭГ, Улсын Их Хурлын Сонгууль. АИХЭГ-ын Сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан. 2024
- Д.Энхцэцэг, Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт болон бусад анхаарал татсан асуудал, 2020
- Д.Бат-Эрдэнэ, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал, 2022
- Ш.Сүхбаатар, Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон , Улаанбаатар, 2022
- Монгол Улсын Их Сургууль, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд, 2022
- Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал №6, 2022
- Ш.Сүхбаатар, Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон, 2022
- Д.Энхцэцэг, Ерөнхий тойм. Чөлөөт шударга сонгуулийн зарчмуудыг хөндсөн зарим асуудал, 2024
- Б.Амарсанаа, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих эрх зүйн орчны судалгаа, 2024
- Х.Норовсүрэн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн биелэлтийг хангах нь, 2025
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Сонгуулийн боловсрол онол, арга зүйн сэтгүүл, 2025, №1, 2025
- Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, 2025

Гадаад хэл дээрх эх сурвалж:

- Office of the High Commissioner for Human Rights, General Comment No.25:The right to participate in public affairs, voting rights and the right of equal access to public service (Art.25):

12/07/96. CCPR/C/21/Rev.1/Add.7, General Comment No.25.
(General Comments)

- Office for Democratic Institutions and Human Rights, Resolving Election Disputes in the OSCE Area: Towards a Standard Election Dispute Monitoring System, 2000
- Office for Democratic Institutions and Human Rights, Resolving Election Disputes in the OSCE Area: Towards a Standard Election Dispute Monitoring System, 2000
- International Institute for Democracy and Electoral Assistance, International Electoral Standards Guidelines for reviewing the legal framework of elections, 2002
- IDEA, Electoral Justice: An overview of the International IDEA Handbook, 2010
- IFES Chad Vickery, Guidelines for Understanding, Adjudicating, and Resolving Disputes in Elections, 2011
- Katherine Ellena, Chad Vickery and Lisa Reppell, Elections on Trial: The Effective Management of Election Disputes and Violations, 2018
- OSCE Office for Democratic Institutions and Human Rights (ODIHR), Handbook for the Observation of Election Dispute Resolution, 2019
- European Commission for Democracy through Law (Venice Commission), Report on Election Dispute Resolution, 2020
- Michael Krennerich, Report on Electoral Law and Electoral Administration in Europe, 2020
- Michael Krennerich, Free and fair elections?, 2021
- South Korea, Public Official Election Act
- Mexico, General Law on Electoral Institutions and Procedures
- Estonia, Riigikogu Election Act
- Estonia, Constitutional Review Court Procedure Act
- California, Regulations of the Fair Political Practices Commission
- California Elections Code
- European Commission, Code of Good Practice in Electoral Matters, 2022

Цахим эх сурвалж:

- “СЕХ-ыг хэн хянах вэ”, <https://www.unuudur.mn/a/258746>
- Монгол Улсад Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын талаар НҮБ-ын Тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалт, 20231115-eom-mongolia-sr-ijl-en.pdf
- 2024 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч Н.Номтойбаяр нь “авлига, албан тушаалын хэргээр ял шийтгүүлсэн” гэх мэдээ, <https://itoim.mn/a/2024/06/03/politic/btm>
- Л.Галбаатар: Мэдээллийн ил тод байдлыг хатуу хязгаарласан хэвээр байна, <https://www.polit.mn/a/104902>
- СЕХ-оос сонгуулийн дүнг УИХ-д өргөн барьсан шийдвэрийн Д.Арвин гишүүнд холбогдох хэсэгт гаргасан мэдээлэл, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9450>
- California Secretary of State, Election Voter Complaint, <https://www.sos.ca.gov/elections/publications-and-resources/voter-complaint>
- Fair Political Practices Commission, California. File a Complaint, <https://www.fppc.ca.gov/enforcement/file-a-complaint.html>
- Fair Political Practices Commission, California, Enforcement Case Resolutions, <https://fppc.ca.gov/enforcement/EnfDivCaseResults.html>
- Supreme Court of Estonia, Constitutional judgement, <https://www.riigikohus.ee/en/constitutional-judgment-3-4-1-17-02>
- https://www.inimoigustegiid.ee/en/themes/civic-participation/standing-for-election/restrictions/how-to-complain?utm_source=chatgpt.com
- Open Election Data Initiative. (n.d.). Complaints and Disputes. <https://openelectiondata.net/en/guide/key-categories/complaints-and-disputes/>

ХАВСРАЛТ

Хавсралт №1: Нэр дэвшигчээс хасах гэмт хэрэг, зөрчлийн зохицуулалт

	Сонгуулийн хуулийн зохицуулалт	Хариуцлага	Үйлдэлд хамаарах хугацаа
1	МУИХСтХ-ийн 35.3. Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно.	ЭХТА-ийн 14.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол /дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ./	Нэр дэвшигчийн үнэмлэх авснаас хойш
2	МУИХСтХ-ийн 38.2.Нам, эвслээс нэр дэвшигч тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.4 нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр гаргаж ашигласан; /хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./	Нэр дэвшигчийн үнэмлэх авснаас хойш

3	48.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг уустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 48.1.1. мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх; 48.1.2.нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх; 48.1.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах; 48.1.4.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх; 48.1.5.хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах; 48.1.6.сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;	ЭХТА-ийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Иргэний сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд ... зориуд саад учруулсан бол ...” 2.Энэ гэмт хэргийг: 2.3. сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн бол /таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хутацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хутацаагаар хорих ял шийтгэнэ./ Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16.1.бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн; 16.2.нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн; 16.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан; 16.4.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн; 16.5.хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн, эсхүл тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэхээр зарласан;	Сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийн дуустал
---	--	---	---

48.1.7.хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх; 48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.	16.6.сонгуульд оролцохоос тагталзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан; 16.7.харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан, нийтэлсэн, нэвтрүүлсэн /эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно/	Сонгуулийн сурталчилгааны явцад
4 МУИХСтХ-ийн 48.5.1.энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.1.хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан; /хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./	Сонгуулийн сурталчилгааны явцад
5 МУИХСтХ-ийн 48.5.2. зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18.2. зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн; /хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./	Сонгуулийн сурталчилгааны явцад

6	МУИХСтХ-ийн 56.2. Хандив өгөхийг хориглосон этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлнэ.	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23.Хандив өгөхийг хуулиар хориглосон этгээдээс хандив өгсөн бол, тус хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө буцаан шилжүүлээгүй бол, эсхүл хуульд зааснаас илүү хэмжээний хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө буцаан шилжүүлээгүй бол /хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./	Нэр дэвшигчийн үнэмлэх авснаас хойш
---	--	--	-------------------------------------

Хавсралт №2: Гомдол мэдээлэл гаргах эрх олгосон хууль тогтоомжийн зохицуулалтууд

Гаргаж буй хэлбэр	Үндэслэл	Хандах, шийдвэрлэх этгээд	Зохицуулалт
Мэдээлэл	Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан	Цагдаагийн байгууллага	МУЕСтХ 80.7, МУИХСтХ 81.7 АНСДИТХСтХ 81.6
Өргөдөл, гомдол	Сонгуулийн хороодын шийдвэрт	Дээд шатны сонгуулийн хороо	МУИХСтХ 81.5 МУЕСтХ 80.5 АНСДИТХСтХ 81.4
	Сонгуулийн хороодын шийдвэр, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар	Дээд шатны сонгуулийн хороо	МУЕСтХ 18.19, МУИХСтХ 19.21 АНСДИТХСтХ 19.19
	Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой	Улсын бүртгэлийн байгууллагад	МУЕСтХ 23.1, МУИХСтХ 23.1 АНСДИТХСтХ 23.1

	Бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашигласан, Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг	Харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага	МУЕСТХ 42.7, МУИХСтХ 47.7 АНСДИТХСтХ 46.7
	Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаатай холбоотой	Цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчид	МУЕСРТССНХТ Журам ¹⁵⁷ 5.1 Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам 5.1.
	Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой	Цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт	Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын 6.1.
	Зөрчлийн тухай хуульд заасан бусад сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчлүүд	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл

Хавсралт №3: Цэцийн шийдвэрүүдийн түүвэр шинжилгээ

	Шийдвэр	Агуулга	Ач холбогдол, үр дагавар
1	2020.12.23-ны 11-р дүгнэлт	МУИХСтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтад "... баривчлах, ... цагдан хорих нь ҮХ-ийг зөрчөөгүй	МУИХСтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтад нэр дэвшигчийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдолд эрх бүхий этгээд

¹⁵⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам, 2021, 5.1

		Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрөл авахаар зохицуулсан нь сонгогдох эрхийн хэрэгжилтийн хангах, нэр дэвшигчийн хууль зүйн баталгаанд хамаарна гэж үзсэн. Гэвч 2020 оны сонгуулиар тус зохицуулалтын агуулгыг Эрүүгийн хэргийн шүүхүүд хэрэгжүүлээгүй тохиолдол гарсан бөгөөд шүүхийн зүгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гагцхүү ЭХХШТХ-иар зохицуулна гэж тайлбарыг гаргаж байв. Тиймээс дүгнэлтийн Үндэслэх хэсгийн 2 дахь заалтад тусгагдсаны дагуу “... нарийвчлан зохицуулсан төрөлжсөн хуультай уялдуулах, холбогдох журмыг тусгайлан тогтоох, хууль зөрчсөн тохиолдолд гарах үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулах”, ЭХХШТХ-д холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлагатай.
2	2018.11.14-ний 14-р дүгнэлт /УИХ-н 2018.11.22-ны 85 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн/	2015 оны Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт “Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.” гэж заасан нь МУҮХ-ийн 14.1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна

3	2011.01.05-ны 01-р тогтоол	2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.” гэсэн заалтын “...эцэслэн...” гэсэн нь шүүхэд хандах үндсэн эрхийг хязгаарласан байна	Тус тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлтийг үндэслэлтэй гэж дүгнэн эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд сонгуулийн маргааныг шүүхээс гадуур эцэслэн шийдвэрлэх агуулга, зохицуулалтыг Үндсэн хуулийн хэмжээнд хүлээн зөвшөөрөөгүй болохыг баталгаажуулсан.
4	2016.09.21-ний 9-р дүгнэлт /УИХ-ын 2016.10.06- ны 49-р тогтоолоор хүлээн зөвшөөрсөн/	2015 оны Сонгуулийн тухай хуулийн 160.5-д “нэр дэвшигч нэрийн жагсаалтаас хасагдсаны улмаас дахин сонгууль явагдсан бол хасагдсан нэр дэвшигч хүн 6 жилийн хугацаанд сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдах ба урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй” гэсэн нь Үндсэн хуулийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн	Эрх зүйн харилцааны ижил нөхцөл байдалд тэгш эрхийн зарчим үйлчлэх чиг хандлага, эрх зүйн үзэл баримтлал нэгэнт тогтсон байдаг. Үүнээс үзэхэд, ижил зөрчил гаргасан Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчтэй харьцуулахад орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчид хэт өндөр хариуцлага хүлээхээр хуульчилснаас гадна хууль зүйн хэд хэдэн хариуцлагыг нэгэн зэрэг нэг хүнд ногдуулахаар заасан эрх тэгш байх зарчмыг зөрчсөн гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид тавигдах шаардлага болон хариуцлага ижил байх зарчмыг дахин тусгасан дүгнэлт болсон.

Хавсралт №4: Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын суурь зарчим, шаардлагуудын тодорхойлсон баримт бичгийн түүвэр

Холбогдох хэсэг	
Эх сурвалж	
1	НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№25, §25, 1996):
2	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-аас эрхлэн гаргасан “Сонгуулийн маргаан шийдвэрлэх аргачилсан зөвлөмжүүд
3	Венецийн комиссын 2002 оны 51-р хуралдаанаар баталсан “Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын кодекс”:
... 20. Сонгуулийн үйл явцад хяналт тавих, ... санал гаргах болон тоолох үйл явцыг хараат бусаар хянах, маргаантай асуудлаар шүүх, маргаан таслах бусад байгууллагад хандах боломж олгох нь саналын хуудас ба санал тоолох үйл явцад итгэх сонгогчдын итгэлийг нэмэгдүүлнэ. Маргаан шийдвэрлэх процессын дараах үндсэн зарчмуудыг тодорхойлсон. 1. Үр дүнтэй бодитой арга хэмжээ авах буюу хууль бус үйлдлийг эсэргүүцэх, шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх боломж олгогдсон байх, 2. Гомдол гаргах, процесст оролцох эрх өргөн хүрээнд олгогдсон байх, 3. Сонгуулийн маргаан сонгуулийн эрхээ эдлэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээлгэх, үйлдэгдсэн зөрчлийг тогтоох боломжтой хугацаанд шийдвэрлэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байх, 4. Шүүхэд шударгаар шүүлгэх эрхийн баталгааг бүрдүүлсэн байх, 5. Өөрийн эрх ашиг, байр суурийг бодитой илэрхийлэн хамгаалах боломжийг маргааны талуудад олгосон байх, 6. Маргаан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын бие даасан хараат бус байх, 7. Маргаан шийдвэрлэх байгууллагуудын шийдвэр үргэлж шударга бөгөөд объектив байх, 8. Сонгуулийн маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд маргааныг шийдвэрлэх үйл явцдаа ил тод байдлыг бүхий л талаар хангасан байх, 9. Хууль тогтоомжийн хувьд хууль ёсны бөгөөд тодорхой байх, 10. Гомдол гаргах, маргаан шийдвэрлэх үйл явц хүн бүрд хүртээмжтэй, ойлгомжтой, ил тод байх; 3.3. Гомдол хянан шийдвэрлэх үр нөлөөтэй тогтолцоо: “... хуулийн хэрэгжилтийг зөрчсөн тохиолдолд гомдол гаргах боломж заавал байх ёстой. Энэ нь ялангуяа сонгуулийн дүнтэй холбоотой тохиолдолд чухал: иргэн бүр санал авах ажиллагааны зөрчлийн улмаас дүн буруу тогтоогдсон гэж үзвэл түүнийг хянан хэлэлцүүлэх эрхтэй байх ёстой.” Гомдол шийдвэрлэх үйл явц дараах зарчмыг хангасан байх ёстой: 1. Богино хугацаанд шийдвэрлэгддэг байх: ялангуяа сонгуулийн өмнөх шийдвэрүүдэд хамаарах гомдлыг шуурхай шийдвэрлэх, 2. Сонгуулийн дүнтэй холбоотой маргааныг ч мөн маш богино хугацаанд шийдвэрлэх ёстой — ялангуяа улс төрийн орчин хурцадмал үед,	

		3. Хугацааны зохистой тэнцвэрийг хадгалах. Нэг талаас, хэт богино хугацаа нь эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болгоно. Нөгөө талаас, хэт сунжрах нь улс төрийн тогтворгүй байдал үүсгэнэ. 4. Эхний шагны гомдлыг гаргах болон шийдвэрлэх хугацаа 3–5 хоног байх нь зохистой. Харин Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүх гомдлыг шийдвэрлэхэд арай илүү хугацаа авах боломжийг олгож болно. 5. Гомдол гаргах журмыг хялбаршуулсан байх шаардлагатай. Сонгогчдод зориулсан тусгай гомдлын маягт гаргаж өгвөл зохистой. 6. Хэт формализм буюу хэлбэрдэлтээс зайлсхийх ёстой. Ялангуяа улс төрийн эмзэг асуудлаар шийдвэр гарахаас зайлсхийх байдлаар “гомдлыг хүлээн авах боломжгүй” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгохгүй байх ёстой. 7. Гомдол шийдвэрлэх ажиллагаа, уг ажиллагаанд оролцох байгууллагуудын бүрэн эрх, үүргийг хуульд тодорхой, ойлгомжтой зааж өгөх ёстой. Энэ нь эрх зүйн харьяаллын зөрчил буюу хоёр байгууллага бие бие рүү гомдлыг шилжүүлж, шийдвэр гаргахаас зайлсхийх эрсдэлийг бууруулна.”
4	Сонгуулийн тогтолцооны олон улсын сангаас боловсруулсан “Сонгуулийн маргааныг ойлгох, хянан шийдвэрлэх, зохицуулах зааварчилгаа”,	Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх хүрээнд баримтлах дараах 7 зарчмыг санал болгосон. Үүнд: 1. Сонгуулийн гомдол, маргааныг шийдвэрлүүлэх эрхийг хангах, 2. Сонгуулийн журам, стандартыг нарийн, тодорхой тогтоосон байх, 3. Шийдвэр гаргах эрх бүхий, төвийг сахисан, эрх бүхий байгууллагатай байх, 4. Маргаан шийдвэрлэлтийг шүүхийн журмаар түргэн шуурхай явуулах тогтолцоог бий болгох, 5. Ноглох баримт ба нотолгооны стандартыг тогтоосон байх, 6. Үр нөлөөтэй, бодитой шийдвэрлэх арга хэмжээг авах боломжтой байх, 7. Оролцогч талуудын сонгуулийн боловсролыг дээшлүүлэх
5	Ардчилал, Сонгуульд туслах олон улсын хүрээлэнгээс боловсруулсан “Зүй ёсны сонгууль гарын авлага”	Сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцооны үндсэн зарчмууд: 1. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын хараат бус байдал, 2. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн хараат бус байдал, бие даасан байдал, 3. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллага, гишүүдийн хариуцлага, эргэн тайлагнах байдал, 4. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын гишүүдийн мэргэжлийн ур чадвар, шударга байдал, 5. Сонгуулийн маргаан шийдвэрлэх байгууллагын санхүүгийн хараат бус, тогтвортой байдал

6	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (АИХЭА)-аас боловсруулсан Сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны гарын авлага	Сонгуулийн маргаан шийдвэрлэх процессын үндсэн 8 зарчмыг тодорхойлсон. Үүнд: 1) Эрхээ үр нөлөөтэйгөөр хамгаалуулах боломж; (2) Хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөх байдал; (3) Цаг үедээ таарсан байдал; (4) Хараат бус байдал; (5) Алагчлалгүй, шударга байдал; (6) Ил тод байдал; (7) Хууль ёсны баталгаа; (8) Хүртээмжтэй байдал
	Олон улсын парламентын холбооны “Чөлөөт, шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтийн тунхаг”	Улс төрийн болоод сонгуулийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх, эрхийг сэргээх шаардлага, сонгуулийн хутацаанд шуурхай шийдвэрлэх шаардлагыг тодорхойлон тусгасан.

Хавсралт №5: Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчил ба түүнийг шалган шийдвэрлэх байгууллагын чиг үүргийн уялдаа

	Байгууллага	Зөрчлийн тухай хууль дахь холбогдох зөрчлүүд	Чиг үүргийн уялдаа
1	ЦЕГ/эрх бүхий албан хаагч	17.1 дүгээр зүйл: 1.Хүн, хуулийн этгээд нь сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг илтэд гуйвуулсан, өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн 5.Нэр дэвшигчээр бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нэр дэвшигчээр бүртгэгдсэн этгээд нэр дэвшихээс татгалзсан 6.Бие даан нэр дэвшигчид нэгдэж сонгууль эрхэлсэн байгууллага байгуулсан 13.Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан 15.Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн 17.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн 18.3.сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт өгсөн, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашигласан	Тус зөрчлүүдэд холбогдох хяналтын чиг үүрэг нь сонгуулийн байгууллага, сонгуулийн хороодод байх бөгөөд цагдаагийн байгууллагад тусгайлсан гомдол мэдээлэл ирсэн эрх бүхий байгууллагаас шилжүүлснээс бусад тохиолдолд буюу цагдаагийн байгууллага өөрийн оролцоо, чиг үүргийн хүрээнд илрүүлэх тогтоох боломжгүй зөрчлүүд байна. Тухайлбал, нэр дэвшигчийн бүртгэлтэй цахим хуудас аль нь болох, сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд мөн эсэх, тус амлалт мөрийн хөтөлбөрт хамаарах эсэх, бүртгэгдсэн нэр дэвшигч нэрээ татсан эсэх зэрэг асуудлуудад цагдаагийн байгууллагаас хяналт тавих, илрүүлэх боломжгүй бөгөөд зөрчилд хариуцлага хүдээлгэх эсэх нь сонгууль эрхэлсэн байгууллагаас шууд хамаарахаар байна.

		32.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд болон ажиглагч нь сонгуулийн хорооны ажиллах байр болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулсан	
2	Монголбанк/хянан шаллагч	17.1.26.Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй	Дансны хуулгыг төрийн аудитын байгууллага хүлээн авч хянах бөгөөд ирүүлсэн эсэхэд Монголбанкны хянан шаллагч шууд хяналт тавих боломжгүй.
3	Монополын эсрэг газар	17.1.8.Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй	Сурталчилгаа явуулах байгууллага мэдэгдлээ ХХЗХ-д гаргахаар хуульчилсан ¹⁵⁸ бөгөөд хэдий нийтэд мэдээлсэн тайлангаа Монополын эсрэг газарт хүргүүлэхээр заасан боловч мэдэгдэл өгсөн байгууллагуудын мэдээллийг Монополын эсрэг газар хүлээн авах, хянах хууль зүйн үндэслэл боломжийг тодорхой тусгаагүй байна.

4	Сангийн яам /НББ-н хяналтын улсын байцаагч/	17.1.25.Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй 27.Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй	Тайланг хүлээн авах хянах үүргийг төрийн аудитын байгууллага хүлээх бөгөөд хэдий хуулиар сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар холбогдох байгууллагад хүргүүлэх үүргийг хүлээлэг159 боловч зөрчлийг хянан шалгах хариуцлага хүлээлгэх субьектүүд болох НББ-ын улсын байцаагч, эрүүгийн шүүх/цагдаа/ зэрэг эрх бүхий этгээдүүд шууд хяналт тавих зөрчлийг шуурхай илрүүлэх, хариуцлага хүлээлгэх бодит болон хууль зүйн боломжгүй.
5	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17.1.16.7.харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан, нийтэлсэн, нэвтрүүлсэн	Тухайн зөрчлүүд нь санал хураалтаас өмнө тогтоогдсон тохиолдолд нэр дэвшигчдийн жагсаалтаас хасах үр дагавартай тул сонгуулийн хугацаанд шийдвэрлэгдээгүй тохиолдолд үр нөлөөгүй болох магадлал өндөр юм. Гэтэл 3 шаг дамжлагаар шалган шийдвэрлэхээр байгаа нь сонгуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх боломжгүй болгож байна.

¹⁵⁹ МУИХСтХ-ийн 58.2.3

	17.1.18.1.хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан 17.1.18.2.зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн	Тус зөрчлийн хянах, илрүүлэх чиг үүрэг, эрх хэмжээ, зохион байгуулалт нь ХХЗХ-д байна. Гэгэл эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрлэх зөрчилд цагдаагийн эрх бүхий албан хаагч шалгах ажиллагаа явуулахаар хуульчилсан тул чиг үүргийн зөрчил үүсэхээр байна. Хэдий холбогдох журмуудаар зөрчлийн шинжтэй тохиолдол бүртгэгдсэн бол харьяаллын дагуу шилжүүлнэ гэж заасан боловч хуулийн хүрээнд нэг мөр шийдвэрлэх шаардлагагүй байна.
	23.Хандив өгөхийг хуулиар хориглосон этгээдээс хандив өгсөн бол, тус хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө буцаан шилжүүлээгүй бол, эсхүл хуульд зааснаас илүү хэмжээний хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө буцаан шилжүүлээгүй /аудитын байгууллагын бүрэн эрх/	Хандив өгөхийг хориглосон этгээд хандив өгсөн эсэхэд хяналт тавих чиг үүргийн төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэхээр байх бөгөөд эрүүгийн хэргийн шүүх /цагдаа/ тус зөрчлийг өөрөө илрүүлэх сонгуулийн хугацаанд шуурхай шалган шийдвэрлэх хууль зүйн болон цаг хугацааны боломжгүй байна.¹⁶⁰

¹⁶⁰ Тухайлбал, УИХ-ын Э.Болормаа 2024 оны сонгуульд нэр дэвшиж байхдаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс хандив авсан буюу нэр дэвшигчээс хасах төрлийн зөрчил үйлдсэн болох нь 10 сарын дараа тогтоогдсон боловч зөвхөн аудитын компанид хариуцлага тооцсон бөгөөд УИХ-ын гишүүнд хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломжгүй нөхцөл байдал үүссэн.

6	Татварын улсын байцаагч	17.1 дүгээр зүйл 21.Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн 22.Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн	Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны хүрээнд хамаарах тул татварын улсын байцаагч чиг үүргийнхээ хүрээнд бие даан илрүүлэх боломжгүй.
---	-------------------------	---	---

Хавсралт №6: 1992 оноос 2020 он хүртэлх УИХ-ын сонгуулийн тухай хуулиуд болон холбогдох хуулиудын маргаан шийдвэрлэх зохицуулалтуудын харьцуулалт¹⁶¹

Хугацаа	Маргаан шийдвэрлэх процессын онцлог (үндсэн бүтэц, зохицуулалт)	Дээд шатны байгууллагад гомдол шийдвэрлэх хугацаа	Нэрсийн жагсаалттай холбоотой гомдол шийдвэрлэх журам
1992, 1996, 2000, 2004 оны сонгууль: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (1992)	Маргаан шийдвэрлэх үндсэн бүтэц: Сонгуулийн хэсгийн/салбар хороо, Тойргийн хороо, Сонгуулийн Ерөнхий хороо (СЕХ), Шүүх/Цэц Онцлог: - Сонгуулийн үеийн зөрчил, түүний хариуцлага, хариуцлага хүлээлгэх суб'ект /шүүх/-ийн талаар сонгуулийн хуульдаа сонгуулийн эрхийн хууль зүйн баталгааг гэх хэсгийн хүрээнд тусган зохицуулсан.	10 хоног	Сонгогч хэсгийн хороонд гомдол гаргах бөгөөд 3 өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ. Шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргана.

¹⁶¹ Сонгуулийн хууль бүрд тусгайлан зохицуулагдаж ирсэн гол үзүүлэлтүүдээр харьцуулахыг зорьсон бөгөөд харьцуулалтын шалгуур үзүүлэлт болоогүй бусад ялгаа, онцлогуудыг маргаан шийдвэрлэх процессын онцлог хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

	- Тус зохицуулалтуудын хүрээнд сонгуулийн зөрчил маргаануудыг шийдвэрлэхэд шүүх, шүүгчийн орон тоо хүрэлцээ муутай, цаг хугацааны хувьд хэрэгжих боломжгүй, хуулийн заалт тус бүрийг хэрэгжүүлэх механизм байхгүй¹⁶² зэрэг хүндрэл бэрхшээлүүд гарч байсан. - 2002 онд батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу 2004 оны сонгуулийн үед СЕХ-ны шийдвэрийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зохицуулалт үйлчилж байв.		
2008 оны сонгууль: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2005)	Маргаан шийдвэрлэх үндсэн бүтэц: Сонгуулийн хэсгийн/салбар хороо, Тойргийн хороо, Сонгуулийн Ерөнхий хороо (СЕХ), Шүүх/Цэц Онцлог: - Сонгуулийн хороонд харьяалан шийдвэрлэх зөрчлийг сонгуулийн хороо шийдвэрлэнэ. - СЕХ дараах маргааныг 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.¹⁶³ - Нам, эвслийг бүртгэхээс татгалзсан асуудлаар гарсан маргааныг шийдвэр гарсан өдрөөс хойш - Тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш - Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, нэр дэвшигчийг нэрсийн жагсаалтаас хассан - Санал хураалтыг хүчингүй тооцуулах асуудлаар гарсан маргааныг санал хураалт дууссанаас хойш	Ажлын 3 өдөр	Сонгогч, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч тухайн хэсгийн хороонд гомдол гаргах бөгөөд гомдлыг ажлын 3 өдөрт / санал авах өдөр хүртэл 3-с цөөн өдөр үлдсэн бол нэн даруй өдрийн дотор/ шийдвэрлэнэ. Шийдвэрийг эс зөвшөөрвөл 2 хоногийн дотор салбар/тойргийн хороонд гомдол гаргана.

¹⁶² Ш.Сүхбаатар, Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон, 2022, 209 дэх тал.

¹⁶³ Энэхүү зохицуулалтыг Үндсэн хууль зөрчсөн талаар ҮХЦ-ийн 2011 оны 1 сарын 5-ны өдрийн 1 дугаартай тогтоол гарсан.

	- Захиргааны шийтгэлийг сум, дүүргийн шүүгч, давж заалдсан гомдлыг сум, дүүргийн шүүх шийдвэрлэнэ. - Зөрчлийн шинж нь эрүүгийн болон иргэний хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болж байвал асуудлыг холбогдох процессын хуулийн дагуу шийдвэрлэнэ. - Хандивын данс нээх, захиран зарцуулах журмыг зөрчсөн бол шийтгэл ногдуулах, хөрөнгийг улсын орлого болгох асуудлыг хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн СЕХ иргэний шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлнэ.		
2012 оны сонгууль: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2011)	Маргаан шийдвэрлэх үндсэн бүтэц: Сонгуулийн хэсгийн/салбар хороо, Тойргийн хороо, СЕХ, Шүүх/Цэц + бүртгэлийн байгууллага /нэрсийн жагсаалтын гомдол/ Онцлог: - Санал хураалтын дүнтэй холбоотой маргаан гарвал тойргийн хороо санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэх зохицуулалт тусгасан. - Захиргааны шийтгэлийг сум, дүүргийн шүүгч, давж заалдсан гомдлыг сум, дүүргийн шүүх шийдвэрлэнэ. - Зөрчлийн шинж нь эрүүгийн болон иргэний хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болж байвал асуудлыг холбогдох процессын хуулийн дагуу шийдвэрлэнэ. - Хэсгийн хороо, тойргийн хороо, ерөнхий хороо тус бүрийн шийдвэрлэх маргааныг ангилан жагсаалт гаргасан.	Ажлын 3 өдөр	Сонгогч болон гэр бүлийн гишүүн нь санал авах өдрөөс 10-с доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагад гомдол гаргах бөгөөд иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан 3 хоногийн дотор сонгогчийн нэрсийн жагсаалтад өөрчлөлт оруулна.

	- Хэсгийн хороо нь нэрсийн жагсаалттай холбоотой гомдол, маргааныг ажлын 2 өдрийн дотор - Тойргийн хороо нь маргааныг 3 хоногийн дотор - Ерөнхий хороо нь маргааны төрлөөс хамаарч 3–14 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан. - СЕХ нь гомдлыг шийдвэрлэх хүртэл доод шатны байгууллагуудынхаа шийдвэрийг түдгэлзүүлэх эрхтэй. - Сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан гомдлыг дээд шатны байгууллага нь ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэж хариуг өгнө.		
2016 оны сонгууль: Сонгуулийн тухай хууль (2015)	Маргаан шийдвэрлэх үндсэн бүтэц: Сонгуулийн хэсгийн/салбар хороо, Тойргийн хороо, СЕХ, Шүүх/Үндсэн хуулийн цэц + цагдаа, бүртгэлийн байгууллага Онцлог: - УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулийн харилцааг нэг хуулиар зохицуулсан. - Сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг сонгуулийн байгууллагад гаргах ба 3 хоногийн дотор шийдвэрлэнэ. - Сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой гомдол нэхэмжлэлийг шүүхэд гаргахаар зохицуулсан. - Орон нутгийн сонгуулийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүхэд, ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар шийдвэрлэх, шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргана.	3 хоног	Сонгогч болон гэр бүлийн гишүүн нь санал авах өдрөөс 14-с доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагад гомдол гаргах бөгөөд иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан 3 хоногийн дотор сонгогчийн нэрсийн жагсаалтад өөрчлөлт оруулна.

	- Хүлээн авсан шүүгч хэрэг үүсгэх эсэхийг 3 хоногийн дотор шийдвэрлэх ба хэргийн 30 хоногт /1 удаа 10-с илүүгүй хоногоор сунгаж болно/. - Давж заалдах журмаар гаргасан гомдлыг 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. - Маргааныг шийдвэрлэх явцад нэхэмжлэл хүлээн авахаас тагталзахаас бусад захирамж, тогтоолд гомдол гаргахгүй. - Захиргааны зөрчил, гэмт хэргийг шалгахад холбогдох процессын хуулийг баримтална. - Захиргааны зөрчлийн талаар гомдлыг цагдаагийн байгууллагад эсхүл шууд эрүүгийн шүүхэд гаргаж болно. - Захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэр, захирамжид гаргасан гомдлыг хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.	
--	---	--

Хавсралт №7: Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зураглал

Маргааны төрөл	Хэрэг, маргаан үүсгэх үндэслэл	Шийдвэрлэх байгууллага/шатлал	Маргаан шийдвэрлэх хууль тогтоомж	Хэрэг маргааны жишээ
I. Үндсэн хуулийн маргаан	Сонгуулийн хууль тогтоомж, СЕХ-ны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн талаарх өргөдөл, мэдээлэл, хүсэлт	Дунд суудлын хуралдаан Үндсэн хууль зөрчсөнгэж дүгнэсэн бол Улсын Их Хурал Дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол Их суудлын хуралдаан	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль	Сонгуулийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх, УИХ-ын сонгуулийн дүнг өргөн барьсан СЕХ-ны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх

II. Захиргааны хэрэг, маргаан (сонгуулийн байгууллагын шийдвэртэй холбоотой)	Сонгуулийн хороол, УБЕГ зэрэг байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдол	Дээд шатны сонгуулийн байгууллага, УБЕГ Эс зөвшөөрөөл Захиргааны хэргийн анхан шатны шүүх Эс зөвшөөрөөл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Эс зөвшөөрөөл Улсын дээд шүүх	Сонгуулийн хуулиуд, Захиргааны ерөнхий хууль, ИБАТӨГШТХ, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, СЕХ-ны холбогдох журмууд,	Улс төрийн нам, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, Сонгуулийн байгууллагын зохион байгуулалтын бусад шийдвэр үйл ажиллагааг эс зөвшөөрсөн
III. Зөрчлийн хэрэг (сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчил)	Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчилтэй холбоотой гаргасан гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагаас шилжүүлсэн болон өөрөө илрүүлсэн үйлдэл	ТБГ, ЦБ, Монополийн эсрэг газар, Улсын бүртгэлийн хяналтын байцаагч зэрэг зөрчлийн Эрх бүхий албан тушаалтан (9 ЭБАТ) Эс зөвшөөрөөл Захиргааны хэргийн анхан шатны шүүх **Эрүүгийн хэргийн шүүх Эс зөвшөөрөөл ***Давж заалдах шатны шүүх	СЕХ-ны холбогдох журмууд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Сонгуулийн үйл ажиллагааны явцад хориглосон үйлдэл гаргасан, бусад хэлбэрээр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн
IV. Эрүүгийн хэрэг (Сонгуулийн эрх, чөлөөний эсрэг гэмт хэрэг)	Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэлд холбогдох гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагаас шилжүүлсэн болон өөрөө илрүүлсэн үйлдэл	ТБГ, ЦБ (Прокурорын хяналт) Ялгах дүгнэлт үйлдвэл Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эс зөвшөөрөөл Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх Эс зөвшөөрөөл Улсын дээд шүүх	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийсэн, сонгуульд бусаар нөлөөлсөн, сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасан зэрэг

* Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн захиргааны хэрэг маргааны Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

** Монополын эсрэг газар, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, тагварын улсын байцаагч, монголбанкны хянан шалгагч нарын шалган шийдвэрлэсэн зөрчилд холбогдох гомдлыг захиргааны хэргийн шүүхэд

*** Тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагын шалган шийдвэрлэсэн зөрчилд холбогдох гомдлыг эрүүгийн хэргийн шүүхэд

**** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар зөрчлийг хэргийн хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

Хавсралт №8: Түгээмэл сонгуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны харьцуулалт (харьцуулсан судалгаанд сонгон авсан улсуудын хүрээнд)

А. Захиргааны хэрэг, маргаан

Харьцуулалтын зүйл	Монгол	Мексик	Эстони	БНСУ
Маргааны төрөл	Захиргааны хэрэг, маргаан (сонгуулийн байгууллагын шийдвэртэй холбоотой)	Сонгуулийн байгууллагаас гаргасан бүх төрлийн шийдвэртэй холбоотой	Сонгуулийг зохион байгуулагч байгууллагын үйл ажиллагаа, Сонгуулийн хорооны шийдвэртэй холбоотой	Сонгуулийн үр дүнг хүчингүй болгуулахтай холбоотой
Хэрэг, маргаан үүсгэх үндэслэл	Сонгуулийн хороод, УБЕГ зэрэг байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдол	Холбогдох шийдвэр, актад гаргасан гомдол	Холбогдох шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдол	Хариуцсан сонгуулийн хорооны дарга эсвэл сонгогдсон нэр дэвшигчид холбогдуулан гаргасан гомдол

Шийдвэрлэх байгууллага, шатлал	Дээд шатны сонгуулийн байгууллага, үнэг Эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн анхан шатны шүүх Эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Эс зөвшөөрвөл Улсын дээд шүүх	Холбооны сонгуулийн байгууллага Эс зөвшөөрвөл Холбооны шүүхийн сонгуулийн танхим	Үндэсний сонгуулийн хороо Эс зөвшөөрвөл Дээд шүүх	Орон нутгийн сонгуулийн хувьд Үндэсний/Хотын сонгуулийн хороонд, Ерөнхийлөгч болон үндэсний хурлын сонгуулийн хувьд Дээд шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ
Маргаан шийдвэрлэх хууль тогтоомж	Сонгуулийн хуулиуд, Захиргааны ерөнхий хууль, ИБАТГӨГШтХ, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, СЕХ-ны холбогдох журмууд,	Сонгуулийн асуудлаарх гомдол, маргааныг шийдвэрлэх тогтолцооны тухай ерөнхий хууль, Дээд шүүхээс гаргасан зөвлөмж, Холбооны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Constitutional Review Court Procedure Act болон сонгуулийн байгууллага шийдвэр гаргахдаа баримтлах ёстой сонгуулийн хуулиуд	Public Official Election Act, Administrative Litigation Act, зардал, хохирол холбогдох асуудлыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
Хэрэг, маргааны жишээ	Улс төрийн нам, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, Сонгуулийн байгууллагын зохион байгуулалтын бусад шийдвэр үйл ажиллагааг эс зөвшөөрсөн Сонтогчдын нэрсийн жагсаалт, улс төрийн нам, нэр дэвшигчийн бүртгэлд зэрэг сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн байгууллагаас гаргасан бүх төрлийн шийдвэр Сонтогчдын нэрсийн жагсаалт, улс төрийн нам, нэр дэвшигчийн бүртгэлд зэрэг сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн байгууллагаас гаргасан бүх төрлийн шийдвэр, авсан арга хэмжээ, үйл ажиллагаа Нэр дэвшигчийн бүртгэл хүчингүй болгох, санал хураалтын зарласан үр дүнг хүчингүй болгуулах			

Б. Зөрчлийн хэрэг, маргаан

Харьцуулалтын зүйл	Монгол	Мексик	БНСУ
Маргааны төрөл	Зөрчлийн хэрэг (сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчил)	Сонгуулийн компанит ажилд холбогдох Үндсэн хууль болон бусад хууль, зохицуулалтын зөрчил	Нийтийн албан тушаалтны сонгуулийн хуульд заасан зөрчил (гэмт хэрэг)
Хэрэг, маргаан үүсгэх үндэслэл	Сонгуулийн хууль тогтоомж зөрчих зөрчилтэй холбоотой гаргасан гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагаас шилжүүлсэн болон өөрөө илрүүлсэн үйлдэл	Сонгуулийн компанит ажил явуулах зохицуулалтыг зөрсөнд хамаарах сонгуулийн эрх бүхий байгууллагын гомдол	Хуульд хариуцлага хүлээлгэхээр засан зөрчил үйлдсэн талаар гаргасан гомдол
Шийдвэрлэх байгууллага, шатлал	ТЭГ. ЦБ, Монополийн эсрэг газар, Улсын бүртгэлийн хяналтын байцаагч зэрэг зөрчлийн Эрх бүхий албан тушаалтан (9 ЗБАН) Эс зөвшөөрвөл Захиргааны хэргийг өлхөт шатны шүүх Эрхгүйн хэргийн шүүх Эс зөвшөөрвөл Давж заалдах шатны шүүх	Үндэсний Сонгуулын Хорооны хэрэг эрхлэх газрын сонгуулийн маргааны Техниккийн алба Эс зөвшөөрвөл Сонгуулийн шүүхийн Дээд танхим	Лүүргийн эсхүл түүний салбар шүүх Эс зөвшөөрвөл Давж заалдах шатны шүүх Эс зөвшөөрвөл Дээд шүүх
Маргаан шийдвэрлэх хууль тогтоомж	СЭХ-ны холбогдох журмууд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Үндсэн хууль, General Law of Electoral Institutions and Procedures	Нийтийн албан тушаалтны сонгуулийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Хэрэг, маргааны жишээ	Сонгуулийн үйл ажиллагааны явцад хориглосон үйлдэл гаргасан, бусад хэлбэрээр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн	Сонгуулийн компани ажлыг хууль тогтоомж зөрчиж явуулсан	Санал авах, бусад нэр дэвшигчийг сонгуулах эсхүл сонгуулахгүй байх зорилгоор сонгогч, сонгуулийн компани ажлын менежер, өөр намын нэр дэвшигч зэрэг хуульд заасан этгээдүүдэд мөнгө, эд зүйл, аливаа эд хөрөнгө, хувийн болон нийтийн албан тушаал санал болгох гэх мэт
--------------------------	---	---	--

